

“ЗОХИОГЧИЙН ЭРХ БОЛОН ТҮҮНД ХАМААРАХ ЭРХИЙН ТУХАЙ ”

2018

Хуулийн төслийн үр нөлөөний үнэлгээ

Судалгааны захиалагч:

Хууль зүй, дотоод хэргийн яам

Гүйцэтгэгч:

“Мирим Консалтант” ХХК

Судалгааг гүйцэтгэсэн:

Ж.Очирхуяг	Багийн ахлагч, хуульч
Х.Дондог	Оюуны өмч, инновацийн зөвлөх
Я.Бямбасүрэн	Төрийн удирдлага, бодлогын зөвлөх
Х.Бямбасүрэн	Эдийн засаг, статистикийн зөвлөх
Д.Майдри	Туслах судлаач, хуульч

Судалгааг хянасан:

Н.Янжинпагма	“Мирим Консалтант” ХХК-ийн гүйцэтгэх захирал
--------------	--

ГАРЧИГ

УДИРТГАЛ	5
НЭГ. ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТИЙН СОНГОЛТ, ҮНДЭСЛЭЛ	5
Зорилгод хүрэх байдал.....	5
Ойлгомжтой байдал	5
Харилцан уялдаа	6
ХОЁР. ҮР НӨЛӨӨГ НЬ ТООЦОХ ХЭСГЭЭ ХУУЛИЙН ШИНЭЧИЛСЭН НАЙРУУЛГААС СОНГОСОН БАЙДАЛ.....	6
“Зорилгод хүрэх байдал” шалгуур үзүүлэлтийн хүрээнд үр нөлөөг нь тооцох хэсгийг сонгосон байдал	6
ГУРАВ. ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТЭД ТОХИРОХ ШАЛГАХ ХЭРЭГСЛИЙГ СОНГОСОН БАЙДАЛ..	10
ДӨРӨВ. ХУУЛИЙН ШИНЭЧИЛСЭН НАЙРУУЛГЫН ҮР НӨЛӨӨГ ҮНЭЛСЭН БАЙДАЛ.....	11
4.1. “Зорилгод хүрэх байдал” шалгуур үзүүлэлтээр үнэлсэн байдал.....	11
1. “Хуулийн нэр томъёоны тодорхойлолтыг шинэчлэх” агуулга	11
2. “Компьютерийн програмын зохиогчийн эрхийн заалт оруулах” агуулга.....	11
3. “Бүтээл ашиглах онцгой эрхийн зохицуулалт дээр нэмээд бүтээлийн эх хувийг худалдах, түрээслэх, өмчлөх эрхээ бусдад шилжүүлэх замаар нийтэд түгээх эрх, бүтээлийн хувийг олон нийтэд дэлгэх эрх, өргөн нэвтрүүлгийн байгууллага, харилцаа холбооны бусад сүлжээгээр дамжуулах, дахин дамжуулах зэрэг эрхийг зохицуулах, мөн түүнчлэн бүтээлийг нийтэд түгээхтэй холбоотойгоор зохиогч нь бүтээлийн ашиглалт бүрээс төлбөр авах, бүтээлийг нийтэд шууд тоглон үзүүлэх, нийтэд түгээх, өргөн нэвтрүүлгийн байгууллага болон интернетээр дамжуулсны төлөө зохих төлбөр авах эрхийг зохицуулах” агуулга	12
4. “Цахим сүлжээний хэрэгслийг ашиглан бүтээлийн хувийг нийтэд түгээх, технологийн хамгаалалтын арга хэмжээ, эрхийн удирдлагын мэдээллийн эрхийг зохицуулах” агуулга	14
5. “Зохиогчийн эрхийн хамгаалалтын хугацааг уртасгаж зохицуулах” агуулга	15
6. “Мэдээллийн сангийн зохиогчийн эрхийн зохицуулалт хийх” агуулга	16
7. “Хэвлэлийн газартай холбоотой зохиогчийн эрхийн зохицуулалт оруулах” агуулга ...	16
8. “Зохиогчийн эрхэд хамаарах эрх эдлэх гүйцэтгэгч уран бүтээлчийн эрхийн зохицуулалт хийх” агуулга	17
9. “Фоногорам бүтээгч нь фонограмыг хуулбарлах, нийтэд түгээх, эх хувь болон хуулбарыг түрээслүүлэх, зээлдүүлэх, интерактив дамжуулах, ашиглуулснаас зохих төлбөр авах эрхийг тусгах” агуулга	19
10. “Дуу авиа бүхий дүрст бүтээлийн зохиогчийн эрхийн асуудлыг зохицуулах” агуулга	20

11.	“Дуу авиа бүхий дүрст бүтээлийн анхны бичлэгийн продюсерийн эрх” агуулга	22
12.	“Өргөн нэвтрүүлгийн байгууллага нь нэвтрүүлгийн бичлэг хийх, хуулбарлах, дамжуулах, дахин дамжуулах, түгээх эрхийг тусгах” агуулга	23
13.	“Бүтээлийг зохиогч, зохиогчийн эрх эзэмшигчийн эрх, хууль ёсны шиг сонирхлыг хөндөхгүйгээр бүтээлийг нь зөвшөөрөлгүйгээр болон төлбөргүйгээр ашиглах тохиолдлууд буюу зохиогчийн эрх болон зохиогчийн эрхэд хамаарах эрхийг хязгаарлах нөхцлүүдийг нарийвчлан тодорхойлох” агуулга	24
14.	“Хамтын удирдлагын байгууллагын тогтолцоог илүү өргөжүүлэн зохицуулах” агуулга	28
15.	“Зохиогчийн болон хамаарах эрхийн Зөвлөл байгуулан ажиллуулах эрх зүйн үндэслэлийг буй болгох” агуулга	31
16.	“Архив, музей, номын санд хадгалагдаж байгаа бүтээлийг ашиглах онцгой нөхцлийг тусгах” агуулга	33
17.	“Хэвлэн нийтлэгдсэн бүтээлийг хараагүй болон харааны бэрхшээлтэй хүмүүст зориулан тэдний хүртэж болох хэлбэрт шилжүүлэх, уг бүтээлийг хилээр нэвтрүүлэх, хуулбарлах, нийтэд түгээхэд зохиогчийн эрхийг хязгаарлах, чөлөөлөхтэй холбоотой зохицуулалтыг тусгах” агуулга	33
18.	“Зохиогч, зохиогчийн эрх эзэмшигч хүсвэл бүтээл болон бүтээл ашиглах онцгой эрхийг шилжүүлэх, шилжүүлэх гэрээ, хэлцлийг сайн дурын үндсэн дээр бүртгүүлэх, бүртгэлийн журам батлуулах талаар зохицуулах” агуулга	35
19.	“Зохиогчийн эрх, хамаарах эрхийг зөрчих, зөрчигчдөд хүлээлгэх хариуцлагыг тодорхой болгох” агуулга	36
4.2.	“ОЙЛГОМЖТОЙ БАЙДАЛ”-ЫН ҮНЭЛГЭЭ	36
4.3.	“ХАРИЛЦАН УЯЛДАА”-Т БАЙДЛЫН ҮНЭЛГЭЭ	40
4.3.1.	Зөвшөөрөл олгох, журам батлах, төлбөрийн хэмжээ тогтоох зохицуулалт	40
4.3.2.	Хуулийн төсөлд орсон тоон хязгаарлалтууд	41
4.3.3.	Хууль хоорондын уялдаа	41
4.3.4.	Хуулийн төслийн дотоод зүйл, заалтуудын холболт, харилцан уялдаа	43
4.3.6.	Зохиогчийн эрх болон түүнд хамаарах эрхийн тухай хуулийн нийтлэг жишигтэй уялдсан байдлын үнэлгээ	46
4.3.7.	Зохиогчийн эрхийг хамгаалах байгууллагуудын харилцан уялдааны үнэлгээ	50
	Үр нөлөөний үнэлгээний ерөнхий дүгнэлт	55
	Зөвлөмж	57
	Ашигласан бүтээлүүд, материалууд	59

УДИРТГАЛ

Монгол Улсын Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын 3 дугаар хавсралтаар батлагдсан “Хуулийн төслийн үр нөлөө тооцох аргачлал” /цаашид “Аргачлал” гэх/-д заасны дагуу “Зохиогчийн эрх болон түүнд хамаарах эрхийн тухай” хуулийн шинэчилсэн найруулгад үнэлгээ хийлээ. Уг ажлыг дараах үе шаттайгаар гүйцэтгэсэн. Үүнд:

1. Шалгуур үзүүлэлтийг сонгох;
2. Хуулийн төслөөс үр нөлөө тооцох хэсгээ тогтоох;
3. Урьдчилан сонгосон шалгуур үзүүлэлтэд тохирох шалгах хэрэгслийн дагуу үр нөлөөг тооцох;
4. Үр дүнг үнэлэх, зөвлөмж өгөх.

НЭГ. ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТИЙН СОНГОЛТ, ҮНДЭСЛЭЛ

Хуулийн төслийн үр нөлөөний үнэлгээг тооцохдоо хуулийн төслийн зорилт, хамрах хүрээ, зохицуулах асуудалтай уялдуулан, аргачлалд дурдсан дараахь 6 шалгуур үзүүлэлтээс дараах дөрвийг сонгосон. Үүнд:

1. Зорилгод хүрэх байдал
2. Ойлгомжтой байдал
3. Зардал¹
4. Харилцан уялдаа тус тус багтана.

“Практикт хэрэгжих боломж” болон “Хүлээн зөвшөөрөгдөх байдал”-ыг сонголгүй орхисон үндэслэл:

- a. Тус хуулийн шинэчилсэн найруулгад өмнөх хуулийн заалтуудаас хадгалагдан орж буй хэсгийн “Практикт хэрэгжих боломж” болон “Хүлээн зөвшөөрөгдөх байдал” нь “Зохиогчийн эрхийн болон түүнд хамаарах эрхийн тухай” хуулийн хэрэгжилтийн үр дагаварт хийсэн үнэлгээний 2017 оны тайлангаар баталгаажиг харагдсан.
- b. Харин шинэ заалтуудын хувьд хуулийн шинэчилсэн найруулгын үзэл баримтлалд тусгагдсан практик үндэслэл, шаардлагуудаас урган гарч ирсэн хэрэгцээ нь тодорхой тул тэдгээрийн “Практикт хэрэгжих боломж” болон “Хүлээн зөвшөөрөгдөх байдал”-ыг үнэлэх нь бусад шалгуур үзүүлэлтүүдтэй нь харьцуулахад бага ач холбогдолтой хэмээн үзсэнтэй холбоотой болно.

Дөрвөн шалгуур үзүүлэлтүүдийг сонгохдоо дараахь үндэслэлийг харгалзан үзсэн. Үүнд:

Зорилгод хүрэх байдал

Тус хуулийн шинэчилсэн найруулгын зорилт нь өмнөх хуулийнхаас зарчмын ялгаатай томъёологдсон тул түүнийг хэрэгжүүлэхэд уг хуулийн зүйл, заалтуудад тусгасан зохицуулалтууд нь шинэ үзэл баримтлал болон зорилтдоо ямар хэмжээнд хэр нийцтэй байгааг авч үзэх, цогц байдлыг нь эргэн харах шаардлагатай юм.

Ойлгомжтой байдал

¹ “Зардал” гэсэн шалгуур үзүүлэлтийг “Зохиогчийн эрх болон түүнд хамаарах эрхийн тухай” хуулийн төслийн зардлын тооцоо гэсэн хэсэгт тусад нь тооцож, үр нөлөөг нь үнэлсэн болно.

Хуулийн шинэчилсэн найруулгын үзэл баримтлал хийгээд зорилтод:

- Бүтээлийг шинжлэх ухаан, утга зохиол, урлагийн хэмээн бүлэглэн тодруулж тусгасан.
- Зохиогчийн эрх болон хамаарах эрхийг хамгаалахаас гадна түүнийг хэрэгжүүлэх эрх зүйн үндсийг тусгайлан зааж дурдсан.
- Зохиогчийн эрх болон түүнд хамаарах эрхийг зөрчихгүйгээр бүтээлийг зөвшөөрөлгүй болон төлбөргүйгээр ашиглах эрх зүйн үндсийг тогтоон зохицуулахаар шинээр тусгагдсан зэрэг нь хуулийн шинэчилсэн найруулгын ойлгомжтой байдлыг үнэлэх шаардлагтайг зүй ёсоор харуулж байна.

Харилцан уялдаа

Хуулийн шинэчилсэн найруулгад шинээр 36 зүйл нэмэгдэж, заалтуудын дийлэнх нь шинээр томъёологдож, цөөн нь өмнөх хуулийн зарим заалтуудыг шинэчлэн найруулсан эсхүл хэвээр хадгалсан тул тэдгээрийн хоорондох уялдаа хийгээд харилцан холбоог зайлшгүй шинжлэх, үнэлэх хэрэгтэй юм. Мөн түүнчлэн заалтуудын давхардал, зөрчил, хийдэл байгаа эсэхийг магадлах, олон улсын оюуны өмчийн эрх зүйн баримт бичгүүдтэй нийцэх байдал хийгээд харилцан уялдах байдлыг нь тодруулах хэрэгцээ буй.

ХОЁР. ҮР НӨЛӨӨГ НЬ ТООЦОХ ХЭСГЭЭ ХУУЛИЙН ШИНЭЧИЛСЭН НАЙРУУЛГААС СОНГОСОН БАЙДАЛ

Хуулийн шинэчилсэн найруулга нь зорилтоосоо эхлээд ихэнх зүйл, заалтууд нь өмнөх хуулийнхаас зарчмын нилээд ялгаатай тул үр нөлөөг нь үнэлэх хэсэгт юуны өмнө шинэ зүйл, заалтуудыг оруулсан. Энэхүү зүйл заалтуудыг эрэмбэлэхдээ хууль зүйн хувьд шууд үр дагавар үүсгэж байгаа заалтуудыг сонгож авсан.

Түүнчлэн хуулийн төсөл батлагдсанаар тодорхой зохицуулалтын бүтэц, тогтолцоо шаардах, эсхүл тусгай зөвшөөрөл олгох, дагалдах журам батлан хэрэгжүүлэхтэй холбогдох, мөн тодорхой субъектэд үүрэг хүлээлгэсэн, тодорхой байгууллагад шинээр чиг үүрэг оноож байгаа, мөн чиг үүргийг хэрэгжүүлэх, хянах, гомдол маргааныг шийдвэрлүүлэх зэргийг харгалзан үр нөлөөг нь тооцох хэсгээ тогтоосон.

Сонгосон шалгуур үзүүлэлтийн дагуу хуулийн төслөөс үр нөлөөг нь тооцох хэсгээ тогтоосон байдлыг үзүүлэе.

“Зорилгод хүрэх байдал” шалгуур үзүүлэлтийн хүрээнд үр нөлөөг нь тооцох хэсгийг сонгосон байдал

“Зохиогчийн эрх болон түүнд хамаарах эрхийн тухай” хуулийн шинэчилсэн найруулгын төслийн зорилт нь дараах онцлогуудыг өөртөө агуулж байна. Үүнд:

- a) Бүтээлийг шинжлэх ухаан, утга зохиол, урлагийн хэмээн бүлэглэн тодруулж өгсөн.
- b) Зохиогчийн эрх болон түүнд хамаарах эрхийг хэрэгжүүлэх эрх зүйн үндсийг тогтоохоор заасан.
- c) Зохиогчийн эрх болон түүнд хамаарах эрхийг зөрчихгүйгээр бүтээлийг зөвшөөрөлгүй болон төлбөргүйгээр ашиглах эрх зүйн үндсийг зохицуулахаар тусгасан.

Энэ зорилгод хүрэхийн тулд өмнөх хуулийн зүйлтэй харьцуулахад хуулийн шинэчилсэн найруулгын хүрээнд дараах 36 зүйлийг шинээр нэмсэн байна. Үүнд:

1. 15 дугаар зүйл.Бүтээл ашиглах онцгой эрхийг шилжүүлэх
2. 20 дугаар зүйл. Кино урлагийн болон дуу авиа бүхий дүрст бүтээлийн зохиогчийн эрх
3. 21 дүгээр зүйл.Компьютерийн програмын зохиогчийн эрх
4. 22 дугаар зүйл.Мэдээллийн сангийн зохиогчийн эрх
5. 23 дугаар зүйл.Мэдээллийн сан ашиглагч этгээдийн эрх, үүрэг
6. 24 дүгээр зүйл.Хэвлэлийн гэрээ
7. 25 дугаар зүйл.Хэвлэлийн газрын гэрээгээр хүлээх үүрэг
8. 26 дугаар зүйл.Дүрслэх урлагийн бүтээл дэх зохиогчийн эрх

9. 27 дугаар зүйл.Архитектурын бүтээл дэх зохиогчийн эрх
10. 28 дугаар зүйл.Зохиогчийн эрхийн бүтээлийг ашиглах
11. 29 дүгээр зүйл.Лицензийн гэрээ
12. 31 дүгээр зүйл.Зохиогчийн эрхийг хязгаарлах
13. 32 дугаар зүйл.Мэдээллийн зорилгоор бүтээлийг хэсэгчлэн ашиглах
14. 33 дугаар зүйл.Эрдэм шинжилгээ, судалгаа, сургалтын зорилгоор бүтээлийг хэсэгчлэн ашиглах
15. 34 дүгээр зүйл.Хараа болон сонсголын согогтой, бусад хөгжлийн бэрхшээлтэй хүний хэрэгцээнд зориулан ашиглах
16. 35 дугаар зүйл.Архив, музей, номын санд хадгалагдаж байгаа бүтээлээс хэсэгчлэн ашиглах
17. 36 дугаар зүйл.Амины хэрэгцээнд зориулан бүтээлийг ашиглах
18. 37 дугаар зүйл. Бүтээлээс эшлэл авах
19. 38 дугаар зүйл.Олон нийтийн аюулгүй байдлыг хангах зорилгоор бүтээлийг ашиглах
20. 39 дүгээр зүйл.Барилга байгууламж, архитектурын зохиогчийн эрхийг хязгаарлах
21. 40 дүгээр зүйл.Зохиогчийн эрхийг хязгаарлахад тавигдах нөхцөл
22. 42 дугаар зүйл.Хамаарах эрх эзэмшигчийн эдлэх эрх
23. 46 дугаар зүйл.Дуу авиа бүхий дүрст бүтээлийн анхны бичлэгийн продюсерийн эрх
24. 47 дугаар зүйл.Хамаарах эрхийн хугацаа
25. 48 дугаар зүйл.Хамаарах эрхийн объектийг ашиглах
26. 49 дүгээр зүйл.Эрх шилжүүлэх гэрээ болон лицензийн гэрээ
27. 50 дугаар зүйл.Хамаарах эрхийг хязгаарлах
28. 55.Хамтын удирдлагын байгууллагын үйл ажиллагаанд тавих хяналт
29. 56 дугаар зүйл.Гадаад орны зохиогчийн эрх болон хамаарах эрхийн хамтын удирдлагын байгууллагатай харилцах
30. 57 дугаар зүйл. Зохиогчийн болон хамаарах эрхийн зөвлөл
31. 58 дугаар зүйл. Зөвлөлийн чиг үүрэг
32. 59 дүгээр зүйл. Зөвлөлийн хуралдаан, шийдвэр
33. 61 дүгээр зүйл.Технологийн хамгаалалтын арга хэмжээ
34. 62 дугаар зүйл.Эрхийн удирдлагын мэдээлэлтэй холбоотой үүрэг
35. 64 дүгээр зүйл.Зохиогчийн эрх, хамаарах эрхийн хэрэгжилтийг хангах, зохиогчийн эрх, хамаарах эрхийг зөрчих
36. 66 дугаар зүйл.Шилжилтийн зохицуулалт

Мөн түүнчлэн заалтуудын олонхи нь шинээр томъёологдож, цөөн нь өмнөх хуулийн зарим заалтуудыг шинэчлэн найруулж оруулсан эсхүл хэвээр хадгалсан байна.

“Зорилгод хүрэх байдал”-ийн үр нөлөөг нь үнэлэхийн тулд хуулийн шинэчилсэн найруулгын төслөөс зорилтын 19 задаргааг хуулийн үзэл баримтлалтай нь уялдуулан гаргаж, тэдгээрийн үнэлгээнд ашигласан зүйл заалтуудыг дараах хүснэгтэд харуулав.

Хүснэгт 1: “Зорилгод хүрэх байдал”-ийн үр нөлөөг үнэлэх хэсгийн сонголт

№	Зорилтын агуулгын 19 задаргаа	“Зорилгод хүрэх байдал”-г үнэлэхэд хэрэглэгдэх зүйл, заалт
1	Хуулийн нэр томъёоны тодорхойлолтыг шинэчлэх	3 дугаар зүйл. Хуулийн нэр томъёоны тодорхойлолт
2	Компьютерийн програмын зохиогчийн эрхийн заалт оруулах	21 дүгээр зүйл. Компьютерийн програмын зохиогчийн эрх

3	Бүтээл ашиглах онцгой эрхийн зохицуулалт дээр нэмээд бүтээлийн эх хувийг худалдах, түрээслэх, өмчлөх эрхээ бусдад шилжүүлэх замаар нийтэд түгээх эрх, бүтээлийн хувийг олон нийтэд дэлгэх эрх, өргөн нэвтрүүлгийн байгууллага, харилцаа холбооны бусад сүлжээгээр дамжуулах, дахин дамжуулах зэрэг эрхийг зохицуулах, мөн түүнчлэн бүтээлийг нийтэд түгээхтэй холбоотойгоор зохиогч нь бүтээлийн ашиглалт бүрээс төлбөр авах, бүтээлийг нийтэд шууд тоглон үзүүлэх, нийтэд түгээх, өргөн нэвтрүүлгийн байгууллага болон интернетээр дамжуулсны төлөө зохих төлбөр авах эрхийг зохицуулах	15 дугаар зүйл.Бүтээл ашиглах онцгой эрхийг шилжүүлэх 16 дугаар зүйл.Үүсмэл бүтээлийн зохиогчийн эрх 17 дугаар зүйл.Түүвэр зохиол, бусад эмхэтгэл бүтээлийн зохиогчийн эрх 18 дугаар зүйл.Албан үүргийн дагуу туурвисан бүтээлийн зохиогчийн эрх 19 дүгээр зүйл.Захиалгаар бүтээл туурвих 26 дугаар зүйл.Дүрслэх урлагийн бүтээл дэх зохиогчийн эрх 27 дугаар зүйл.Архитектурын бүтээл дэх зохиогчийн эрх 28 дугаар зүйл.Зохиогчийн эрхийн бүтээлийг ашиглах 30 дүгээр зүйл. Эрх шилжүүлэх гэрээ 42 дугаар зүйл.Хамаарах эрх эзэмшигчийн эдлэх эрх
4	Цахим сүлжээний хэрэгслийг ашиглан бүтээлийн хувийг нийтэд түгээх, технологийн хамгаалалтын арга хэмжээ, эрхийн удирдлагын мэдээллийн эрхийг зохицуулах	60 дугаар зүйл.Цахим болон харилцаа холбооны бусад сүлжээнд зохиогчийн эрхийг хамгаалах 61 дүгээр зүйл.Технологийн хамгаалалтын арга хэмжээ 62 дугаар зүйл.Эрхийн удирдлагын мэдээлэлтэй холбоотой үүрэг
5	Зохиогчийн эрхийн хамгаалалтын хугацааг уртасгаж зохицуулах	13 дугаар зүйл.Зохиогчийн эрхийн хамгаалалтын хугацаа 14 дүгээр зүйл.Зохиогчийн эрхийг өвлөх 47 дугаар зүйл.Хамаарах эрхийн хугацаа
6	Мэдээллийн сангийн зохиогчийн эрхийн зохицуулалт хийх	22 дугаар зүйл.Мэдээллийн сангийн зохиогчийн эрх 23 дугаар зүйл.Мэдээллийн сан ашиглагч этгээдийн эрх, үүрэг
7	Хэвлэлийн газартай холбоотой зохиогчийн эрхийн зохицуулалт оруулах	24 дүгээр зүйл.Хэвлэлийн гэрээ 25 дугаар зүйл.Хэвлэлийн газрын гэрээгээр хүлээх үүрэг
8	Зохиогчийн эрхэд хамаарах эрх эдлэх гүйцэтгэгч уран бүтээлчийн эрхийн зохицуулалт хийх	43 дугаар зүйл.Гүйцэтгэгч уран бүтээлчийн эрх 63 дугаар зүйл.Зохиогч болон гүйцэтгэгч уран бүтээлчийн эдийн бус баялгийн эрхийг хамгаалах 42 дугаар зүйл.Хамаарах эрх эзэмшигчийн эдлэх эрх 48 дугаар зүйл.Хамаарах эрхийн объектийг ашиглах 49 дүгээр зүйл.Эрх шилжүүлэх гэрээ болон лицензийн гэрээ 50 дугаар зүйл.Хамаарах эрхийг хязгаарлах 63 дугаар зүйл.Зохиогч болон гүйцэтгэгч уран бүтээлчийн эдийн бус баялгийн эрхийг хамгаалах
9	Фонограм бүтээгч нь фонограмыг хуулбарлах, нийтэд түгээх, эх хувь болон хуулбарыг түрээслүүлэх, зээлдүүлэх, интерактив	44 дүгээр зүйл.Фонограм бүтээгчийн эрх 42 дугаар зүйл.Хамаарах эрх эзэмшигчийн эдлэх эрх 41 дүгээр зүйл.Хамаарах эрх эдлэх этгээд 48 дугаар зүйл.Хамаарах эрхийн объектийг ашиглах 49 дүгээр зүйл.Эрх шилжүүлэх гэрээ болон лицензийн

	дамжуулах, ашиглуулснаас зохих төлбөр авах эрхийг тусгах	гэрээ 50 дугаар зүйл.Хамаарах эрхийг хязгаарлах
10	Дуу авиа бүхий дүрст бүтээлийн зохиогчийн эрхийн асуудлыг зохицуулах	20 дугаар зүйл. Кино урлагийн болон дуу авиа бүхий дүрст бүтээлийн зохиогчийн эрх 42 дугаар зүйл.Хамаарах эрх эзэмшигчийн эдлэх эрх 41 дүгээр зүйл.Хамаарах эрх эдлэх этгээд 48 дугаар зүйл.Хамаарах эрхийн объектийг ашиглах 49 дүгээр зүйл.Эрх шилжүүлэх гэрээ болон лицензийн гэрээ 50 дугаар зүйл.Хамаарах эрхийг хязгаарлах
11	Дуу авиа бүхий дүрст бүтээлийн анхны бичлэгийн продюсерийн эрх	46 дугаар зүйл.Дуу авиа бүхий дүрст бүтээлийн анхны бичлэгийн продюсерийн эрх Заалтууд: 46.1. ба 46.1.1., 46.1.2., 46.1.3., 46.1.4. 42 дугаар зүйл.Хамаарах эрх эзэмшигчийн эдлэх эрх 41 дүгээр зүйл.Хамаарах эрх эдлэх этгээд 48 дугаар зүйл.Хамаарах эрхийн объектийг ашиглах 49 дүгээр зүйл.Эрх шилжүүлэх гэрээ болон лицензийн гэрээ 50 дугаар зүйл.Хамаарах эрхийг хязгаарлах
12	Өргөн нэвтрүүлгийн байгууллага нь нэвтрүүлгийн бичлэг хийх, хуулбарлах, дамжуулах, дахин дамжуулах, түгээх эрхийг тусгах	45 дугаар зүйл.Өргөн нэвтрүүлгийн байгууллагын эрх 42 дугаар зүйл.Хамаарах эрх эзэмшигчийн эдлэх эрх 41 дүгээр зүйл.Хамаарах эрх эдлэх этгээд 48 дугаар зүйл.Хамаарах эрхийн объектийг ашиглах 49 дүгээр зүйл.Эрх шилжүүлэх гэрээ болон лицензийн гэрээ 50 дугаар зүйл.Хамаарах эрхийг хязгаарлах
13	Бүтээлийг зохиогч, зохиогчийн эрх эзэмшигчийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хөндөхгүйгээр бүтээлийг нь зөвшөөрөлгүйгээр болон төлбөргүйгээр ашиглах тохиолдлууд буюу зохиогчийн эрх болон зохиогчийн эрхэд хамаарах эрхийг хязгаарлах нөхцлүүдийг нарийвчлан тодорхойлох	31 дүгээр зүйл.Зохиогчийн эрхийг хязгаарлах 32 дугаар зүйл.Мэдээллийн зорилгоор бүтээлийг хэсэгчлэн ашиглах 33 дугаар зүйл.Эрдэм шинжилгээ, судалгаа, сургалтын зорилгоор бүтээлийг хэсэгчлэн ашиглах 34 дүгээр зүйл.Хараа болон сонсголын согогтой, бусад хөгжлийн бэрхшээлтэй хүний хэрэгцээнд зориулан ашиглах 35 дугаар зүйл.Архив, музей, номын санд хадгалагдаж байгаа бүтээлээс хэсэгчлэн ашиглах 36 дугаар зүйл.Амины хэрэгцээнд зориулан бүтээлийг ашиглах 37 дугаар зүйл. Бүтээлээс эшлэл авах 38 дугаар зүйл.Олон нийтийн аюулгүй байдлыг хангах зорилгоор бүтээлийг ашиглах 39 дүгээр зүйл.Барилга байгууламж, архитектурын зохиогчийн эрхийг хязгаарлах 40 дүгээр зүйл.Зохиогчийн эрхийг хязгаарлахад тавигдах нөхцөл 50 дугаар зүйл.Хамаарах эрхийг хязгаарлах
14	Хамтын удирдлагын байгууллагын тогтолцоог илүү өргөжүүлэн зохицуулах	52 дугаар зүйл.Хамтын удирдлагын байгууллага 53 дугаар зүйл.Хамтын удирдлагын байгууллагын үйл ажиллагаа 54 дүгээр зүйл.Хамтын удирдлагын байгууллагын үүрэг 51 дүгээр зүйл.Оюуны өмчийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага 55 дугаар зүйл. Хамтын удирдлагын байгууллагын үйл ажиллагаанд тавих хяналт 56 дугаар зүйл.Гадаад орны зохиогчийн эрх болон хамаарах эрхийн хамтын удирдлагын байгууллагатай

		харилцах
15	Зохиогчийн болон хамаарах эрхийн Зөвлөл байгуулан ажиллуулах эрх зүйн үндэслэлийг буй болгох	57 дугаар зүйл. Зохиогчийн болон хамаарах эрхийн зөвлөл 58 дугаар зүйл. Зөвлөлийн чиг үүрэг 59 дүгээр зүйл. Зөвлөлийн хуралдаан, шийдвэр 51 дүгээр зүйл. Оюуны өмчийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага
16	Архив, музей, номын санд хадгалагдаж байгаа бүтээлийг ашиглах онцгой нөхцлийг тусгах	35 дугаар зүйл. Архив, музей, номын санд хадгалагдаж байгаа бүтээлээс хэсэгчлэн ашиглах
17	Хэвлэн нийтлэгдсэн бүтээлийг хараагүй болон харааны бэрхшээлтэй хүмүүст зориулан тэдний хүртэж болох хэлбэрт шилжүүлэх, уг бүтээлийг хилээр нэвтрүүлэх, хуулбарлах, нийтэд түгээхэд зохиогчийн эрхийг хязгаарлах, чөлөөлөхтэй холбоотой зохицуулалтыг тусгах	34 дүгээр зүйл. Хараа болон сонсголын согогтой, бусад хөгжлийн бэрхшээлтэй хүний хэрэгцээнд зориулан ашиглах
18	Зохиогч, зохиогчийн эрх эзэмшигч хүсвэл бүтээл болон бүтээл ашиглах онцгой эрхийг шилжүүлэх, шилжүүлэх гэрээ, хэлцлийг сайн дурын үндсэн дээр бүртгүүлэх, бүртгэлийн журам батлуулах талаар зохицуулах	9 дүгээр зүйл. Зохиогчийн эрх үүсэх, баталгаажих 15 дугаар зүйл. Бүтээл ашиглах онцгой эрхийг шилжүүлэх 28 дугаар зүйл. Зохиогчийн эрхийн бүтээлийг ашиглах 29 дүгээр зүйл. Лицензийн гэрээ 30 дүгээр зүйл. Эрх шилжүүлэх гэрээ 51 дүгээр зүйл. Оюуны өмчийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага
19	Зохиогчийн эрх, хамаарах эрхийг зөрчих, зөрчигчдөд хүлээлгэх хариуцлагыг тодорхой болгох	64 дүгээр зүйл. Зохиогчийн эрх, хамаарах эрхийн хэрэгжилтийг хангах, зохиогчийн эрх, хамаарах эрхийг зөрчих 65 дугаар зүйл. Зохиогчийн эрх болон түүнд хамаарах эрхийн хууль тогтоомж зөрчигчдөд хүлээлгэх хариуцлага

ГУРАВ. ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТЭД ТОХИРОХ ШАЛГАХ ХЭРЭГСЛИЙГ СОНГОСОН БАЙДАЛ

3.1. Хуулийн төслийн үр нөлөөг үнэлэх шалгуур үзүүлэлтийн дагуу тэдгээрт тохирох шалгах хэрэгслийг сонгосон байдлыг дараах хүснэгтэнд харуулав:

Хүснэгт 2: Шалгах хэрэгслийг сонгосон байдал

	Шалгуур үзүүлэлтүүд	Тохирох шалгах хэрэгсэл
1	Зорилгод хүрэх байдал	Зорилтод задлан шинжилгээ хийж, түүнд хамаарах зүйл, заалтуудтай нь харьцуулах
2	Ойлгомжтой байдал	Утга, найруулга, логик бүтэц, тогтолцооны ойлгомжтой байдал
3	Харилцан уялдаа	1. <u>Дотоод уялдаа холбоо</u> : Хуулийн зүйл, заалтууд хоорондын шүтэлцээг үнэлэх 2. <u>Гадаад харилцан уялдаа</u> : Өөр хамаарах хуулиудтай уялдах байдал, мөн түүнчлэн Олон улсын гэрээ

	хэлцлийн заалттай нийцэн уялдах байдалд дүн шинжилгээ хийнэ.
--	---

ДӨРӨВ. ХУУЛИЙН ШИНЭЧИЛСЭН НАЙРУУЛГЫН ҮР НӨЛӨӨГ ҮНЭЛСЭН БАЙДАЛ

4.1. “Зорилгод хүрэх байдал” шалгуур үзүүлэлтээр үнэлсэн байдал

Үнэлгээг зорилтын задаргаа тус бүрээр хийж гүйцэтгэв. Үүнд:

1. “Хуулийн нэр томъёоны тодорхойлолтыг шинэчлэх” агуулга-ын хүрээнд дараах 20 нэр томъёог шинээр оруулж тодорхойлсон байна. Үүнд:

1. Бүтээл
2. Дуу авиа бүхий дүрст бүтээлийн продюсер
3. Өргөн нэвтрүүлэг
4. Өргөн нэвтрүүлгийн байгууллага
5. Олон суваг дамжуулагч
6. Мэдээллийн сан
7. Хамаарах эрх
8. Хамаарах эрх эзэмшигч
9. Компьютерийн програм
10. Дамжуулах
11. Дахин дамжуулах
12. Интерактив дамжуулах
13. Түрээслэх
14. Зээлдүүлэх
15. Нийтэд тоглох
16. Нийтэд дэлгэж үзүүлэх
17. Нийтийн хүртээл болгох
18. Нийтээрээ чөлөөтэй ашиглах бүтээл
19. Эшлэл
20. Эрхийн удирдлагын мэдээлэл гэсэн хорин нэр томъёог шинээр тодорхойлсон байна.

Дүгнэлт 1: Хуулийн шинэчилсэн найруулгын зүйл, заалтуудад шинээр хэрэглэгдэх нэр томъёог хангалттай хамруулж зорилтдоо хүрч чаджээ.

2. “Компьютерийн програмын зохиогчийн эрхийн заалт оруулах” агуулга-ын хүрээнд дараах зохицуулалтыг хийсэн байна. Үүнд:

Компьютерийн програмын зохиогчийн эрх гэсэн 21 дүгээр зүйлийг шинээр оруулж ирсэн байна. Ингэхдээ програм нь анх удаа зохиогдсон буюу эх бүтээл бол хуулийн дагуу хамгаалагдах (21.2.), албан үүргийн дагуу зохиосон бол ажил олгогч эрхийг нь эдлэх (21.3.)-ээр заасан. Тухайн бүтээлийг арилжааны буюу бизнесийн зорилгоор бусдад ашиглуулсан бол төлбөрөөс хүртэх (21.4.) эрхтэй бөгөөд энэ хуулийн 21.5-д заасны дагуу авсан мэдээллийг бие даасан програм зохиох болон бусад програмыг хооронд нь нийцүүлэхээс бусад зорилгоор ашиглах, гуравдагч этгээдэд задруулах болон эх програмын үндсэн илэрхийлэлтэй ижил төстэй байдлаар хөгжүүлэх, өөрчлөх, хуулбарлах, арилжаалах зорилгоор ашиглахыг (21.6.) хориглоно гэж заасан байна.

Дүгнэлт 2: Компьютерийн програмын зохиогчийн эрхийг хэн эдлэх, эрхээ бусдад ашиглуулсан бол төлбөр хүртэх, 21.5-д зааснаас бусад тохиолдолд зохиогчийн эрх зөрчигдөхийг тодорхой

зохицуулж зорилтдоо хүрсэн байна.

3. “Бүтээл ашиглах онцгой эрхийн зохицуулалт дээр нэмээд бүтээлийн эх хувийг худалдах, түрээслэх, өмчлөх эрхээ бусдад шилжүүлэх замаар нийтэд түгээх эрх, бүтээлийн хувийг олон нийтэд дэлгэх эрх, өргөн нэвтрүүлгийн байгууллага, харилцаа холбооны бусад сүлжээгээр дамжуулах, дахин дамжуулах зэрэг эрхийг зохицуулах, мөн түүнчлэн бүтээлийг нийтэд түгээхтэй холбоотойгоор зохиогч нь бүтээлийн ашиглалт бүрээс төлбөр авах, бүтээлийг нийтэд шууд тоглон үзүүлэх, нийтэд түгээх, өргөн нэвтрүүлгийн байгууллага болон интернетээр дамжуулсны төлөө зохих төлбөр авах эрхийг зохицуулах” агуулга-ын хүрээнд дараах зүйл заалтуудыг хуулийн төсөлд тусгажээ. Үүнд:

- Бүтээл ашиглах онцгой эрхийг шилжүүлэх тухай 15 дугаар зүйлийн 15.1. заалтаар энэ хуулийн 12.2 дахь хэсэгт заасан эрхийг зөвхөн зохиогчийн зөвшөөрлөөр, бичгээр хийсэн гэрээний үндсэн дээр бусдад шилжүүлж болно гэж үзсэн.
- Үүсмэл бүтээлийн зохиогчийн эрхийн тухай 16 дугаар зүйлийн 16.1-д үүсмэл бүтээлийн зохиогч нь эх бүтээлийн зохиогчоос зөвшөөрөл авсны үндсэн дээр бүтээлээ туурвих эрхтэй бөгөөд зөвшөөрөл нь энэ хуулийн 28.4-т заасан нөхцөл, шаардлагыг хангасан байхыг шинээр заасан бөгөөд 16.3-д үүсмэл бүтээл туурвисан зохиогч нь эх бүтээлийн зохиогчийн эрхийг зөрчөөгүй тохиолдолд үүсмэл бүтээлдээ зохиогчийн эрх эдэлнэ гэж үзсэн. Мөн 16.2-д нэг эх бүтээлд тулгуурласан үүсмэл бүтээл туурвигчид өөр хоорондоо саад болохгүй гэжээ.
- Түүвэр зохиол, бусад эмхэтгэл бүтээлийн зохиогчийн эрхийн тухай 17 дугаар зүйлийн заалтуудыг шинээр найруулж оруулсан бөгөөд 17.1-д энэ хуулийн 7.1.16-д заасан бүтээлийн эмхэтгэгч нь эмхэтгэл болон түүвэр зохиолд орсон эх бүтээл бүрийн зохиогчоос зөвшөөрөл авсны үндсэн дээр түүвэр зохиол, бусад эмхэтгэлийг туурвих эрхтэй бөгөөд зөвшөөрөл нь энэ хуулийн 28.4-т заасан нөхцөл шаардлагыг хангасан байна гэж заасан. Мөн 17.2-д зааснаар эх бүтээлийн зохиогч нь тухайн эмхэтгэлээс үл хамааран өөрийн бүтээлээ чөлөөтэй ашиглах эрхтэй бөгөөд 17.3-д зааснаар түүвэр зохиол, бусад эмхэтгэл бүтээлийн зохиогч нь эмхэтгэлд зохиогчийн эрх эдэлнэ.
- Албан үүргийн дагуу туурвисан бүтээлийн тухай 18 дугаар зүйлд 18.3-18.5 заалтуудыг шинээр оруулсан бөгөөд 18.3-заалтаар албан үүргийн дагуу бүтээл туурвисан болохыг ажилтны ажлын байрны тодорхойлолт, эсхүл гэрээгээр тодорхойлох бөгөөд 18.4-заалтаар ажлын байрны тодорхойлолт, гэрээгээр тодорхойлсон чиг үүрэгт хамаарахгүй, эсхүл тодорхойлоогүй бол бүтээл ашиглах онцгой эрхийг ажилтан эдэлнэ. 18.5-д зааснаар гэрээнд өөрөөр заагаагүй бол энэ хуулийн 18.2-т заасны дагуу ажил олгогч өөрийн үндсэн үйл ажиллагаанаас гадна ашиг олох зорилгоор бүтээлийг бусдад ашиглуулсан бол ажилтан бүтээл ашигласны төлбөрөөс хүртэх эрхтэй байна.
- Захиалгаар бүтээл туурвих тухай 19 дүгээр зүйлд 19.1. болон 19.4 заалтууд шинээр орж ирсэн. 19.1. заалтаар захиалгаар бүтээл туурвисан зохиогч бүтээлийнхээ хувьд эдийн бус баялгийн эрх эдлэх эрхтэй, харин 19.4 заалтаар захиалагч бүтээл ашиглах онцгой эрх эдлэхээс бичгээр татгалзсан бол зохиогч онцгой эрх эдэлнэ.
- Дүрслэх урлагийн бүтээл дэх зохиогчийн эрхийн тухай 26 дугаар зүйлийг бүхэлд нь шинээр оруулж ирсэн. 26.1 заалтаар дүрслэх урлагийн бүтээлийн зохиогч, зохиогчийн эрх эзэмшигч нь бүтээлийг хуулбарлах болон нийтэд дэлгэж үзүүлэх эрхийг шилжүүлээгүй бол бүтээл ашиглагч, эсхүл эзэмшигч нь зохиогч, зохиогчийн эрх эзэмшигчээс бүтээлийг хуулбарлах, нийтэд дэлгэж үзүүлэх зөвшөөрөл авах үүрэгтэй. 26.2 заалтаар дүрслэх урлагийн бүтээл ашиглагч, эсхүл эзэмшигч нь бүтээлийг бусдад үнэ төлбөргүйгээр шилжүүлэхээс өмнө зохиогчид буцаан өгөхөөр санал болгох үүрэгтэй. 26.3 заалтаар дүрслэх урлагийн бүтээлийг худалдан авсан этгээд дахин худалдах тохиолдолд уг бүтээлийн зохиогчид худалдсан үнийн дүнгийн 5-аас багагүй хувийг төлөх үүрэгтэй.

- Архитектурын бүтээл дэх зохиогчийн эрхийн асуудлаар 27 дугаар зүйлийг шинээр оруулсан. 27.1 заалтаар хууль, эсхүл гэрээнд өөрөөр заагаагүй бол барилга байгууламжийн зураг төсөл хийх, барилгын ажил гүйцэтгэх, үнэлгээ хийх зэргээр архитектурын бүтээлийг бүрэн, эсхүл хэсэгчлэн ашиглах тохиолдолд зохиогчоос зөвшөөрөл авах үүрэгтэй. 27.2 заалтаар гэрээнд өөрөөр заагаагүй бол архитектурын бүтээл эзэмшигч нь барилга байгууламжийн бүтээлийг ашиглах техникийн шалтгаанаар зохиогчийн зөвшөөрөлгүйгээр бүтээлд өөрчлөлт оруулж болно. 27.3 заалтаар архитектурын бүтээлийн зохиогч нь барилга байгууламжийн бүтээлийн зургийг авах буюу загварын хуулбарыг авах эрхтэй.
- Зохиогчийн эрхийн бүтээлийг ашиглах тухай 28 дугаар зүйлийг шинээр оруулсан. 28.1 заалтаар зохиогч, зохиогчийн эрх эзэмшигч нь бүтээлийг бусад этгээдэд дараахь үндэслэлээр ашиглуулна. Үүнд: 28.1.1 заалтаар бүтээл ашиглах онцгой эрхийг шилжүүлэх; 28.1.2 заалтаар бүтээл ашиглах онцгой эрхийг ашиглах эрх олгох. 28.2 заалтаар энэ хуулийн 28.1-д заасны дагуу бүтээл ашиглалтыг бүтээл ашиглах тухайлсан эрх, зорилго, хугацаа, нутаг дэвсгэр, хамрах хүрээ, арга хэлбэр зэргээр хязгаарлаж болно. 28.3 заалтаар бүтээл ашиглагчид энэ хуулийн 28.1.2-т заасны дагуу олгосон бүтээл ашиглах эрхийг гагцхүү зохиогч, эсхүл зохиогчийн эрх эзэмшигчийн зөвшөөрлөөр гуравдагч этгээдэд дамжуулан ашиглуулж болно. 28.4 заалтаар энэ хуулийн 28.1-д заасны дагуу бүтээлийг ашиглуулахад талууд гэрээг бичгээр байгуулах бөгөөд гэрээнд дараахь нөхцөлийг тусгасан байна. Үүнд: 28.4.1 заалтаар бүтээлийн нэр, тодорхойлолт; 28.4.2 заалтаар бүтээл ашиглах онцгой эрхийг шилжүүлэх, эсхүл ашиглуулах эрх олгох эсэхийг тодорхойлох; 28.4.3 заалтаар бүтээл ашиглах онцгой эрхийг шилжүүлэх тохиолдолд шилжүүлж байгаа эрхүүд; 28.4.4 заалтаар бүтээлийг ашиглах онцгой эрхийг ашиглах эрх олгох тохиолдолд олгож байгаа эрхүүд, лицензийн гэрээний төрөл, эрх дамжуулах эсэх; 28.4.5 заалтаар бүтээл ашиглах хугацаа, нөхцөл, хамрагдах нутаг дэвсгэрийн хүрээ; 28.4.6 заалтаар бүтээл ашигласны төлбөрийн хэмжээ, төлбөр төлөх нөхцөл; 28.3.7 заалтаар талуудын эрх, үүрэг; 28.4.8 заалтаар гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүйн улмаас хүлээлгэх хариуцлага; 28.3.9 заалтаар маргаан шийдвэрлэх журамыг тус тус тусгасан байна. 28.5 заалтаар гэрээнд өөрөөр заагаагүй бол зохиогч бусдад бүтээлийн эх хувь эсхүл хуулбарын өмчлөх эрхийг шилжүүлсэн нь зохиогчийн тус бүтээл дэх бүтээл ашиглах онцгой эрхийг шилжүүлсэнд тооцохгүй.
- Эрх шилжүүлэх гэрээний тухай 30 дугаар зүйлийг шинээр оруулсан. 30.1 заалтаар бүтээл ашиглах онцгой эрхийг гэрээний үндсэн дээр бүрэн, эсхүл хэсэгчлэн бусад этгээдэд шилжүүлж болно. 30.2 заалтаар эрх шилжүүлэх гэрээнд зохиогч хойшид тухайн сэдвээр буюу тухайн салбарт бүтээл туурвихыг хязгаарласан заалт оруулахыг хориглоно. 30.3 заалтаар зохиогчийн бүтээл ашиглах онцгой эрхийг гэрээний дагуу шилжүүлэн авсан этгээд гэрээгээр хүлээсэн үүргээ хангалтгүй хэрэгжүүлсний улмаас зохиогчийн эрх зөрчигдсөн бол зохиогч уг эрхээ сэргээхийг шаардах эрхтэй. 30.4 заалтаар эрх шилжүүлэх гэрээнд тусгайлан заагаагүй бусад бүтээл ашиглах онцгой эрх нь зохиогч, зохиогчийн эрх эзэмшигчид хэвээр хадгалагдана.
- Хамаарах эрх эзэмшигчийн эдлэх эрхийн талаарх 42 дугаар зүйлийг шинээр тусгасан. 42.1 эрхээр хамаарах эрхэд дараахь эрхийн хамааруулна гэжээ. Үүнд: 42.1.1 заалтаар гүйцэтгэгч уран бүтээлчийн эдийн бус баялгийн эрх болон хамаарах эрхийн объект ашиглах онцгой эрх; 42.1.2 заалтаар фонограм, дуу авиа бүхий дүрст бичлэг бүтээгчийн хамаарах эрхийн объект ашиглах онцгой эрх; 42.1.3 заалтаар өргөн нэвтрүүлгийн байгууллагын хамаарах эрхийн объект ашиглах онцгой эрх тус тус багтана.

Дүгнэлт 3

Бүтээл ашиглах онцгой эрхийн зохицуулалтын хүрээнд :

а. Бүтээл ашиглах онцгой эрхийг энэ хуулийн 12-р зүйлийн 2 заалтаар тодруулан ойлгож, эрхийг зөвхөн зохиогчийн зөвшөөрлөөр, бичгээр хийсэн гэрээний үндсэн дээр бусдад шилжүүлж болохыг 15.1 заалтаар зохицуулж өгчээ.

b. Зохиогч, зохиогчийн эрх эзэмшигчээс авах зөвшөөрлийг энэ хуулийн 28.4-т заасан нөхцөл шаардлагуудыг хангасан байхаар ойлгохыг 16-17-р зүйлүүдэд давтан тусгасан байна.

c. Хамаарах эрх эзэмшигчийн эдлэх эрхийг 42-р зүйлийн заалтуудаар бүрэн тодорхойлохдоо гүйцэтгэгч уран бүтээлч, фонограм болон дуу авиа бүхий дүрст бичлэг, өргөн нэвтрүүлгийн байгууллага гэсэн гурван үндсэн бүлгээр тодруулж ангилжээ.

d. Эрх шилжүүлэх гэрээнд оруулахыг хориглосон заалтыг 30.2-оор, шилжүүлсэн эрхээ сэргээх боломжийг 30.3-аар, ялгаатай эрхүүдийг хооронд нь холихгүй байхыг 30.4-өөр, эрхийг бүрэн, эсхүл хэсэгчлэн шилжүүлэх боломжийг 30.1-ээр тус тус зааж тодотгосон.

e. Зохиогчийн эрхийн бүтээлийг ашиглах нөхцлийг нарийвчилсан 14 заалтаар 28 дугаар зүйлд оруулж зохицуулжээ.

f. Архитектурын бүтээл дэх зохиогчийн эрхийн асуудлыг 27 дугаар зүйлд 4 заалтаар нарийвчлан тодотгож өгчээ.

g. Дүрслэх урлагийн бүтээл дэх зохиогчийн эрхийг 26 дугаар зүйлээр хамгаалж, уг бүтээлийг ашиглахдаа зохиогч, зохиогчийн эрх эзэмшигчээс нь зөвшөөрөл, бүтээлийг нь худалдан аваад цааш дахин худалдах тохиолдолд уг бүтээлийн зохиогчид худалдсан үнийн дүнгийн 5-аас багагүй хувийг төлөх үүргийг оруулжээ.

h. Захиалгаар бүтээл туурвисан бол 19 дүгээр зүйлээр, албан үүргийн дагуу туурвисан бол 18 дугаар зүйлээр онцлогуудыг нь зааж, зохиогчийн эрхийг хэн эзэмших талаар тусгаж зохицуулсан байна.

i. Түүвэр зохиол, бусад эмхэтгэл бүтээлийн зохиогчийн эрхийг 17 дугаар зүйлд, үүсмэл бүтээлийн зохиогчийн эрхийг 16 дугаар зүйлүүдэд тусгаж, тэдгээр бүтээлүүдийн зохиогчийн эрхийг эх бүтээлийн зохиогчийн эрхтэй уялдуулан зохицуулсан байна.

Ийнхүү зохицуулалтууд зорилтдоо хүрч чаджээ.

4. “Цахим сүлжээний хэрэгслийг ашиглан бүтээлийн хувийг нийтэд түгээх, технологийн хамгаалалтын арга хэмжээ, эрхийн удирдлагын мэдээллийн эрхийг зохицуулах” агуулга-ын хүрээнд:

- Цахим болон харилцаа холбооны бусад сүлжээнд зохиогчийн эрхийн тухай 60 дугаар зүйлд 60.4-60.7 заалтуудыг шинээр оруулсан. Ингэхдээ 60.4 заалтаар оюуны өмчийн улсын байцаагч зохиогч, эрх эзэмшигчийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах нэн яаралтай арга хэмжээ авах үүднээс энэ хуулийн 58.2-т заасан зөрчилтэй үйлдлийг зохиогч, эрх эзэмшигчийн хүсэлтээр зогсоох, түдгэлзүүлэх арга хэмжээг нэн даруй авах эрхтэй. 60.5 заалтаар энэ хуулийн 60.1, 60.2-т заасны дагуу зөрчилтэй бүтээл, хамаарах эрхийн объект ашиглахыг зогсоосон, хаасантай холбоотой маргааныг шүүх шийдвэрлэнэ. 60.6 заалтаар тус улсын нутаг дэвсгэр дээр бүтээл ашиглах онцгой эрхийг авсан этгээд зохиогчийн эрхийн зөрчлийг арилгуулах арга хэмжээг авахыг шаардах эрхтэй. 60.7 заалтаар энэ хуулийн 60.6-д заасан шаардах эрхийг гэрээгээр олгосон нөхцөлд хэрэгжүүлнэ.

- Технологийн хамгаалалтын арга хэмжээний тухай 61 дүгээр зүйлийг шинээр оруулж ирсэн. 61.1 заалтаар зохиогчийн эрхийн зөрчил гаргахаас урьдчилан сэргийлэх зорилгоор зохиогч, эрх эзэмшигч нь нэвтрэх эрхийг хянах, хамгаалах, хяналт тавих зэргээр технологийн үр дүнтэй арга хэмжээг авч хэрэгжүүлнэ. 61.2 заалтаар зохиогч, зохиогчийн эрх эзэмшигч технологийн хамгаалалтын арга хэмжээг нэвтрэх эрхийг хянах, хамгаалах, хяналт тавих үйл ажиллагааг хэрэгжүүлэх замаар хэрэгжүүлнэ. 61.3 заалтаар энэ хуулийн 61.1-д заасан технологийн хамгаалалтын арга хэмжээг Засгийн газраас баталсан журмын дагуу авч хэрэгжүүлнэ.

- Эрхийн удирдлагын мэдээлэлтэй холбоотой үүргийн талаарх 62 дугаар зүйлийг шинээр оруулсан. 62.1 заалтаар энэ хуулиар хамгаалагдсан аливаа эрхийг зөрчихөд хүргэх, зөрчих боломж олгох, зөрчихөд туслах, зөрчлийг нуун дарагдуулах үйлдлийг мэдсээр байж, эсхүл мэдэх боломжтой байж санаатайгаар үйлдсэн, эсхүл үйлдэж байгаа аливаа этгээдийн эсрэг эрх зүйн хамгаалалтын зохистой, үр дүнтэй арга хэмжээ авах боломжоор хангах ба үүнд дараахь үйлдэл хамаарна гэжээ. Үүнд: 62.1.1 заалтаар эрхийн удирдлагын талаарх аливаа цахим мэдээллийг зөвшөөрөлгүйгээр устгах, эсхүл өөрчлөх; 62.1.2 заалтаар эрхийн удирдлагын тухай цахим мэдээллийг зөвшөөрөлгүйгээр устгасан, эсхүл өөрчилсөн гэдгийг мэдсэн хэрнээ бүтээл, эсхүл бүтээлийн хуулбарыг зөвшөөрөлгүйгээр түгээх, түгээх

зорилгоор импортлох, өргөн нэвтрүүлгээр дамжуулах, мэдээлэх, эсхүл нийтийн хүртээл болгох тус тус багтана.

Дүгнэлт 4

Цахим болон харилцаа холбооны бусад сүлжээнд зохиогчийн эрхийг хамгаалах зохицуулалтын хүрээнд 58.2-т заасан зөрчилтэй үйлдлийг зохиогч, эрх эзэмшигчийн хүсэлтээр зогсоох, түдгэлзүүлэх арга хэмжээг нэн даруй авах эрхийг 60-р зүйлд баталгаажуулсан ба зохиогчийн эрхийн зөрчлийг арилгуулах арга хэмжээг авахыг шаардах нь гэрээний нөхцлөөр хэрэгжих боломжтойг заасан. Мөн технологийн хамгаалалтын арга хэмжээг Засгийн газраас баталсан журмын дагуу авах эрхийг 61 дүгээр зүйлээр олгож, эрхийн удирдлагын тухай цахим мэдээллийн зөрчил гаргасан аливаа этгээдийн эсрэг эрх зүйн хамгаалалтын зохистой, үр дүнтэй арга хэмжээг 62 дугаар зүйлд 2 ангилан зохицуулсан байна. Иймд зохицуулалтууд зорилтдоо хүрч чаджээ.

5. “Зохиогчийн эрхийн хамгаалалтын хугацааг уртасгаж зохицуулах” агуулга-ын хүрээнд:

- Зохиогчийн эрхийн хамгаалалтын хугацааны тухай 13 дугаар зүйлийн 13.2 заалтаар зохиогчийн бүтээл ашиглах онцгой эрх нь зохиогчийн насан туршид болон нас барсны дараа жилийн 1 дүгээр сарын 1-нээс эхлэн 70 жилийн хугацаанд хүчин төгөлдөр байна. 13.3 заалтаар зохиогчийн эдийн бус баялгийн эрхийг хугацаа хязгаарлахгүй хамгаална. 13.4 заалтаар зохиогч бүтээлээ зохиомол, нууц нэрээр, эсхүл нэргүйгээр нийтэлсэн тохиолдолд уг зохиогчийн бүтээл ашиглах онцгой эрх нь бүтээлийг анх нийтийн хүртээл болсны дараа жилийн 1 дүгээр сарын 1-нээс эхлэн 75 жилийн хугацаанд хүчин төгөлдөр байна. 13.5 заалтаар энэ хуулийн 13.4-т заасан бүтээлийн зохиогч нь тодорхой болсон тохиолдолд зохиогчийн эрхийн хугацааг энэ хуулийн 13.2-т зааснаар тооцно. 13.6 заалтаар хамтын бүтээлийн зохиогчийн эрх нь зохиогчдын насан туршид болон сүүлчийн зохиогч нас барсны дараа жилийн 1 дүгээр сарын 1-нээс эхлэн 70 жилийн хугацаанд хамгаалагдана. 13.7 заалтаар эрх эзэмшигчийн эзэмшиж байгаа бүтээлийн зохиогчийн эрхийн хамгаалалтын хугацаа нь бүтээлийн зохиогчийн эдлэх эрхийн хугацаатай ижил байна. 13.8 заалтаар энэ хуулийн 13.1-д заасан бүтээл туурвисан өдрийг зохиогчийн эх бүтээл дэх хугацаагаар тогтооно.
- Зохиогчийн эрхийг өвлөх тухай 14 дүгээр зүйлийн 14.1 заалтаар зохиогчийн бүтээл ашиглах онцгой эрхийг Монгол Улсын Иргэний хуульд заасан журмын дагуу өв залгамжилна. 14.2 заалтаар хамтын бүтээл бүтээсэн зохиогчдын бүтээл ашиглах онцгой эрхийн өв залгамжлал сүүлчийн зохиогч нас барсан өдрөөс эхлэн үүснэ. 14.3 заалтаар өв залгамжлагчийн бүтээл ашиглах онцгой эрхийн хугацаа зохиогч нас барсны дараа жилийн 1 дүгээр сарын 1-нээс эхлэн 70 жилийн хугацаанд үйлчилнэ. 14.4 заалтаар зохиогчийн эдийн бус баялгийн эрх өвлөгдөхгүй. 14.5 заалтаар өв залгамжлагч нь тодорхойгүй, эсхүл өвлөгч нь өв залгамжлалаас татгалзсан тохиолдолд бүтээл ашиглах онцгой эрхийг оюуны өмчийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага эдэлнэ.
- Хамаарах эрхийн хугацааны тухай 47 дугаар зүйлийн 47.1 заалтаар энэ хуулийн 41.1-д заасан хамаарах эрх эдлэх этгээд болон хамаарах эрх эзэмшигчийн хамаарах эрхийн объектыг хамгаалах хугацаа нь хамаарах эрхийн объектийг туурвисан, эсхүл гүйцэтгэсэний дараа жилийн 1 дүгээр сарын 1-нээс эхлэн 50 жилийн хугацаанд хүчин төгөлдөр байна.

Дүгнэлт 5

Зохиогчийн эрхийн хамгаалалтын хугацааг 13 дугаар зүйлийн хүрээнд зохиогчдын насан туршид болон сүүлчийн зохиогч нас барсны дараа жилийн 1 дүгээр сарын 1-нээс эхлэн 70 жилийн хугацаагаар, зохиомол, нууц нэрээр, эсхүл нэргүйгээр нийтэлсэн бүтээлийн зохиогчийн ашиглах онцгой эрхийг 75 жилээр, 47 дугаар зүйлд хамаарах эрхийн объектыг

хамгаалах хугацааг 50 жилээр тус тус тогтоожээ. Харин өв залгамжлагчийн бүтээл ашиглах онцгой эрхийн хугацаа нь зохиогч нас барсны дараа 70 жил байхаар тогтоосон байна. Ийнхүү зохицуулалтууд зорилтдоо хүрч чаджээ.

6. “Мэдээллийн сангийн зохиогчийн эрхийн зохицуулалт хийх” агуулга-ын хүрээнд:

- Мэдээллийн сангийн зохиогчийн эрхийн тухай 22 дугаар зүйлийн 22.1 заалтаар бүтээл болон мэдээллийг цахим орчин болон бусад сүлжээнийн орчинд бие даан нэвтрэх боломжтой байдлаар системтэйгээр зохион байгуулж, санхүүжүүлж, мэдээллийн сан үүсгэсэн этгээд доор дурдсан үйлдлийг хориглох болон зөвшөөрөх эрхтэй гэжээ. Үүнд: 22.1.1 заалтаар мэдээллийн сангийн мэдээллийг бүрэн, эсхүл хэсэгчлэн, байнга болон түр өөр хэлбэрт шилжүүлэн татаж авах; 22.1.2 заалтаар мэдээллийн сангийн мэдээллийг цахим сүлжээгээр болон дамжуулах аливаа бусад арга хэлбэрээр бүрэн, эсхүл хэсэгчлэн түгээх, түрээслэх болон дамжуулах эрхтэй. 22.2 заалтаар мэдээллийн сан үүсгэсэн этгээд нь энэ зүйлийн 22.1-д заасан эрхийг гэрээний үндсэн дээр бусад этгээдэд бүрэн, эсхүл хэсэгчлэн шилжүүлэх, эсхүл ашиглах эрх олгож болно. 22.3 заалтаар мэдээллийн сан үүсгэсэн этгээд мэдээллийн санд оруулсан бүтээлийн зохиогчийн эрх болон хамаарах эрхийг зөрчихгүй. 22.4 заалтаар мэдээллийн сан үүсгэсэн этгээд, эсхүл эрх эзэмшигч нь энэ хуулийн 22.2-т заасны дагуу эрхээ шилжүүлсэн тохиолдолд мэдээллийн сангийн хуулбарыг түгээх эрхээ алдана.
- Мэдээллийн сан ашиглагч этгээдийн эрх, үүрэгийн тухай 23 дугаар зүйлийн 23.1 заалтаар мэдээллийн сан үүсгэсэн этгээд мэдээллийн санг хууль ёсоор нийтэд түгээсэн бол хууль ёсоор ашиглагч нь мэдээллийн сангийн мэдээллийг аливаа зорилгоор хэсэгчлэн татан авах, түгээх, түрээслэх болон дамжуулах эрхтэй. 23.2 заалтаар хууль ёсоор ашиглагч нь мэдээллийн санг ашиглахдаа мэдээллийн сан дахь бүтээлийн зохиогчийн эрх болон хамаарах эрхийг зөрчихгүй. 23.3 заалтаар хууль ёсоор ашиглагч нь мэдээллийн сангийн хэвийн ашиглалт болон мэдээллийн сан үүсгэсэн этгээдийн хууль ёсны ашиг сонирхлыг хөндөхгүй байх үүрэгтэй. 23.4 заалтаар хууль ёсоор ашиглагч нь мэдээллийн сангийн тодорхой хэсгийг ашиглах эрх авсан бол зөвхөн тухайн хэсгийг ашиглах эрхтэй. 23.5 заалтаар мэдээллийн санг нийтийн аюулгүй байдлыг хангах, төрийн байгууллагын болон шүүх, арбитрын үйл ажиллагаанд ашиглах зорилгоор ашигласан, хөгжүүлсэн бол бүтээл ашиглах онцгой эрх зөрчсөнд тооцохгүй. 23.6 заалтаар мэдээллийн сангийн мэдээллийн зарим хэсгийг дахин давтсан, системтэйгээр байршуулах, эсхүл хөгжүүлэхэд мэдээллийн сан үүсгэсэн этгээдийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг зөрчихийг хориглоно.

Дүгнэлт 6

Мэдээллийн сан үүсгэсэн этгээдийн хориглох болон зөвшөөрөх эрхийг 22-р зүйлд зааснаар татаж авах, түгээх, түрээслэх болон дамжуулах хэлбэрүүдтэй уялдуулан тодорхойлж өгсөн бол 23-р зүйлд мэдээллийн санг хууль ёсоор ашиглагч нь сан үүсгэсэн этгээдийн хууль ёсны ашиг сонирхлыг хөндөхгүй байх заалтууд орсноос гадна мэдээллийн санг нийтийн аюулгүй байдлыг хангах, төрийн байгууллагын болон шүүх, арбитрын үйл ажиллагаанд ашиглах зорилгоор ашигласан, хөгжүүлсэн бол бүтээл ашиглах онцгой эрх зөрчсөнд тооцохгүй байхаар зохицуулжээ. Иймд зохицуулалтууд зорилтдоо хүрч чаджээ.

7. “Хэвлэлийн газартай холбоотой зохиогчийн эрхийн зохицуулалт оруулах” агуулга-ын хүрээнд:

- Хэвлэлийн гэрээний тухай 24 дүгээр зүйлийн 24.1 заалтаар хэвлэлийн газар нь зохиогч, эсхүл эрх эзэмшигчээс бүтээлийг хуулбарлах, түгээх эрхийг шилжүүлэх, эсхүл ашиглах эрх авах замаар хэвлэлийн гэрээний үндсэн дээр бүтээлийг хэвлэн нийтлэх эрхтэй. 24.2 заалтаар

гэрээнд өөрөөр заагаагүй бол бүтээлийн эх хувь, түүний эх хуулбарын өмчлөх эрх нь зохиогчид хадгалагдана. 24.3 заалтаар хэвлэлийн гэрээнд энэ хуулийн 28 дугаар зүйлд заасан шаардлагаас гадна бүтээлийн зохиогчийн нэр, зохиомол нэр, эсхүл нууц нэр, хэвлэлийн тоо ширхэг, бүтээл нийтлэх эрхийн хамрах хүрээ, зохиогчийн эрхийг хязгаарлах, хэвлэлд бэлтгэх, хэвлэх, нэмэлт засвар оруулах, дахин хэвлэх, нийтлэх, худалдаалах, орчуулах, цахим хэлбэрт оруулах, хэвлэлийн хэл, хэвлэлийн загвар, чимэглэл, дизайн, хэвлэлийн улсын бүртгэлийн дугаар зэрэг асуудлыг тусгайлан тодорхойлно. 24.4 заалтаар хэвлэлийн гэрээний хугацаа болон нөхцөл нь өмнө байгуулсан лицензийн гэрээ, эсхүл эрх шилжүүлэх гэрээгээр тодорхойлсон нөхцөл журамтай нийцсэн байна.

- Хэвлэлийн газрын гэрээгээр хүлээх үүргийн тухай 25 дугаар зүйлийн 25.1 заалтаар хэвлэлийн гэрээний дагуу хэвлэлийн газар нь дараахь үүргийг хүлээнэ гэжээ. Үүнд: 25.1.1 заалтаар гэрээгээр тохиролцсон загвар, хэлбэрээр тогтоосон хугацаанд хэвлэх, хэвлэлийн хувь бүрт зохиогчийн нэр, зохиомол нэр, эсхүл нууц нэрийг дурдах, зохиогчийн талаарх бусад шаардлагатай мэдээллийг оруулах; 25.1.2 заалтаар гэрээнд өөрөөр заагаагүй бол хэвлэлийн эх нооргийг зохиогчоор хянуулах; 25.1.3 заалтын дагуу гэрээгээр тохиролцсон бол тогтоосон хугацаанд түгээх, худалдаалах; 25.1.4 заалтын дагуу гэрээгээр тогтоосон хугацаа, нөхцөлийн дагуу төлбөрийн хэмжээг тогтоох, төлөх; 25.1.5 заалтаар хуулбарлан хэвлэсэн бүтээлийн эх хувийг зохиогчид буцаан олгох; 25.1.6 заалтын дагуу гэрээгээр тохиролцсон бол худалдсанаас олсон орлого, төлбөрийн тооцооллын талаар мэдээллээр хангах. 25.2 заалтаар хэвлэлийн газар нь хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр гэрээнд заасан хугацаанд хэвлэн нийтлээгүй бол зохиогч гэрээг цуцалж, учирсан хохирлыг нөхөн төлөхийг шаардах эрхтэй.

Дүгнэлт 7

24 дүгээр зүйлээр хэвлэлийн газар нь зохиогчоос эрх авах замаар гэрээний үндсэн дээр бүтээлийг хэвлэн нийтлэх эрхийг, гэрээнд тавигдах шаардлагыг тодорхойлон заасан бол 25-р зүйлд хэвлэлийн газрын гэрээгээр хүлээх үүргийг нарийвчлан зохицуулж өгчээ. Иймд зохицуулалтууд зорилтдоо хүрчээ.

8. “Зохиогчийн эрхэд хамаарах эрх эдлэх гүйцэтгэгч уран бүтээлчийн эрхийн зохицуулалт хийх” агуулга-ын хүрээнд:

- Гүйцэтгэгч уран бүтээлчийн эрхийн тухай 43 дугаар зүйлийн нэгээс бусад заалтуудыг шинээр оруулж ирсэн. 43.1 заалтаар гүйцэтгэгч уран бүтээлч нь өөрийн тоглолтын хувьд дараахь эдийн бус баялгийн эрх эдэлнэ гэж заасан. Үүнд: 43.1.1 заалтаар тоглолтондоо нэрээ дурдуулах; 43.1.2 заалтаар тайзны нэр ашиглах; 43.1.3 заалтаар тоглолтыг гүйцэтгэгч уран бүтээлчийн зөвшөөрөлгүйгээр эсхүл нэр хүндэд нь хохирол учруулахуйц байдлаар аливаа арга, хэлбэрээр хувиргах, өөрчлөх, гажуудуулахыг хориглох тус тус багтана. Мөн түүнчлэн 43.2 заалтаар гүйцэтгэгч уран бүтээлч нь өөрийн тоглолтын хувьд дараахь үйл ажиллагааг зөвшөөрөх болон хориглох онцгой эрхтэй гэж заасан. Үүнд: 43.2.1 заалтаар тоглолтондоо бичлэг хийх; 43.2.2 заалтаар тоглолтыг шууд өргөн нэвтрүүлэх (зөвхөн тайзны амьд тоглолтын хувьд); 43.2.3 заалтаар тоглолтыг нийтэд тоглох (өргөн нэвтрүүлэх хамаарахгүй); 43.2.4 заалтаар тоглолтыг нийтэд түгээх; 43.2.5 заалтаар тоглолтын бичлэгийг интерактив дамжуулах; 43.2.6 заалтаар тоглолтын бичлэгийг түрээслэх, зээлдүүлэх тус тус хамаарна. 43.3. Албан үүргийн дагуу тоглосон тоглолтыг ашиглах онцгой эрхийг эдлэх этгээдийг талууд гэрээнд өөрөөр заагаагүй бол ажил олгогч эдэлнэ. 43.4 заалтаар хоёр, эсхүл түүнээс дээш гүйцэтгэгч уран бүтээлч хамтран тоглодог найрал дуу, чуулга, концерт, жүжиг зэрэг тоглолтын хувьд гүйцэтгэгч уран бүтээлчийн онцгой эрхийг найруулагч, эсхүл тоглолтыг удирдан зохион байгуулсан бусад этгээд хэрэгжүүлнэ. 43.5 заалтаар энэ хуулийн 43.4-т заасан тоглолтын

гүйцэтгэгч уран бүтээлчийн онцгой эрхийг ашиглахад тоглолтын гоцлол дуучин, гоцлол хөгжимчнөөс зөвшөөрөл авна. 43.6 заалтаар гэрээнд өөрөөр заагаагүй бол өргөн нэвтрүүлгийн байгууллага нь гүйцэтгэгч уран бүтээлчийн тоглолтыг дамжуулах, эсхүл өргөн нэвтрүүлэх бол гүйцэтгэгч уран бүтээлчид зохих төлбөр төлнө. 43.7 заалтаар гэрээнд өөрөөр заагаагүй бол интернетийн үйлчилгээ түгээгч, олон сувгийн дамжуулагч, агрегатор, цахим хуудас эрхлэгч, харилцаа холбооны үйлчилгээ үзүүлэгч нь гүйцэтгэгч уран бүтээлчийн тоглолт болон тоглолтын бичлэгийг хуулбарлах, дамжуулах, дахин дамжуулах, интерактив дамжуулах, түгээх бол гүйцэтгэгч уран бүтээлчид зохих төлбөр төлнө. 43.8 заалтаар гэрээнд өөрөөр заагаагүй бол аливаа этгээд нийтэд тоглохдоо гүйцэтгэгч уран бүтээлчийн тоглолт болон тоглолтын бичлэгийг ашигласан бол гүйцэтгэгч уран бүтээлчид зохих төлбөр төлнө. 43.9 заалтаар гэрээнд өөрөөр заагаагүй бол гүйцэтгэгч уран бүтээлч нь тоглолтын бичлэг болон түүний хуулбарыг түрээсээр ашиглуулсны зохих төлбөр авах эрхтэй. 43.10 заалтаар гүйцэтгэгч уран бүтээлч нь энэ хуулийн 43.2-т заасан эрхээ хэрэгжүүлэхдээ зохиогчийн эрхийг зөрчихгүй.

- Зохиогч болон гүйцэтгэгч уран бүтээлчийн эдийн бус баялгийн эрхийг хамгаалах тухай 63 дугаар зүйлийн 63.1 заалтаар бүтээлийн халдашгүй байдал болон зохиогч болон гүйцэтгэгч уран бүтээлчийн эдийн бус баялгийн эрхийг зөрчсөн тохиолдолд зохиогч болон гүйцэтгэгч уран бүтээлч, нас барсан тохиолдолд түүний хууль ёсоор буюу гэрээслэлээр өвлөгч болон эрх залгамжлагч, өвлөгч нь өв залгамжлалаас татгалзсан бол оюуны өмчийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага нь зөрчигдсөн эрхийг зохих журмын дагуу сэргээн тогтоохыг уг эрхийг зөрчсөн этгээдээс шаардах, шүүхэд гомдлоо гаргаж шийдвэрлүүлэх эрхтэй.
- Хамаарах эрх эзэмшигчийн эдлэх эрхийн тухай 42 дугаар зүйлийн 42.1 заалтаар хамаарах эрхэд дараахь эрхийн хамааруулна гэжээ. Үүнд: 42.1.1 заалтаар гүйцэтгэгч уран бүтээлчийн эдийн бус баялгийн эрх болон хамаарах эрхийн объект ашиглах онцгой эрх; 42.1.2 заалтаар фонограм, дуу авиа бүхий дүрст бичлэг бүтээгчийн хамаарах эрхийн объект ашиглах онцгой эрх; 42.1.3 заалтаар өргөн нэвтрүүлгийн байгууллагын хамаарах эрхийн объект ашиглах онцгой эрх тус тус багтана.
- Хамтын удирдлагын байгууллагын үйл ажиллагаанд тавих хяналтын тухай 55 дугаар зүйлийн 55.1 заалтаар хамтын удирдлагын байгууллагын үйл ажиллагаанд оюуны өмчийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага хяналт тавина. 55.2 заалтаар хамтын удирдлагын байгууллага энэ хуулийг зөрчиж үйл ажиллагаа явуулсан бол зөрчлийг арилгах хугацаатай үүрэг даалгавар өгч, биелэлтийг хангуулна. 55.3 заалтаар оюуны өмчийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага дараахь тохиолдолд хамтын удирдлагын байгууллагын үйл ажиллагаа явуулах зөвшөөрлийг 3 сар хүртэл хугацаагаар түдгэлзүүлнэ хэмээн заасан. Үүнд: 55.3.1 заалтаар батлагдсан тарифаас илүү хэмжээгээр төлбөр хураан авсан; 55.3.2 заалтаар батлагдсан тариф дээр нэмэлт төлбөр ногдуулж авсан; 55.3.3 заалтаар энэ хуулийн 53.6, 53.7-д заасан тайлан, мэдээг ирүүлээгүй; 55.3.4 заалтаар энэ хуулийн 55.2-т заасны дагуу өгсөн үүрэг даалгаврыг биелүүлээгүй. 55.4 заалтаар оюуны өмчийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага дараахь тохиолдолд хамтын удирдлагын байгууллагатай байгуулсан хамтран ажиллах гэрээг цуцалж, үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг хүчингүй болгоно гэж үзсэн. Үүнд: 55.4.1 заалтаар энэ хууль болон хамтран ажиллах гэрээнд заасан үүргээ удаа дараа биелүүлээгүй, эсхүл зохиогчийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг ноцтой зөрчиж үйл ажиллагаа явуулсан; 55.4.2 заалтаар хууран мэхэлж, эсхүл хууль бус аргаар зөвшөөрөл авсан нь нотлогдсон; 55.4.3 заалтаар энэ хуульд заасантайлан, мэдээг худал мэдүүлсэн нь нотлогдсон; 55.4.4 заалтаар үйл ажиллагаагаа ашгийн төлөө болгож өөрчилсөн; 55.4.5 заалтаар үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг түдгэлзүүлэх шийдвэрийг үл харгалзан үйл ажиллагаа үргэлжлүүлэн явуулсан; 55.4.6 заалтаар үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл олгосноос хойш 1 жилийн дотор үйл ажиллагаа эрхлээгүй, эсхүл 1 жилээс дээш хугацаагаар үйл ажиллагаа явуулаагүй гэх тохиолдлуудыг хамарна. 55.5. заалтаар энэ хуулийн 55.3, 55.4-т заасны дагуу гаргасан шийдвэрийг оюуны өмчийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага нийтэд мэдээлнэ. 55.6 заалтаар энэ хуулийн 55.3, 55.4-т заасан оюуны өмчийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын шийдвэрийг хамтын удирдлагын байгууллага үндэслэлгүй гэж үзвэл Захиргааны ерөнхий хуульд заасан журмын дагуу гомдол гаргаж болно. 55.7 заалтаар хамтын удирдлагын байгууллагыг татан буулгах тохиолдолд оюуны өмчийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагаас зөвшөөрөл авна.

- Гадаад орны зохиогчийн эрх болон хамаарах эрхийн хамтын удирдлагын байгууллагатай харилцах тухай 56 дугаар зүйлийн 56.1 заалтаар Монгол Улсын нутаг дэвсгэр дээр

ашиглагдаж байгаа гадаадын иргэдийн шинжлэх ухаан, утга зохиол, урлагийн бүтээлийн зохиогчийн эрх, хамаарах эрхийг тухайн орны ижил төрлийн хамтын удирдлагын байгууллагатай байгуулсан хоёр талын гэрээ болон олон талын гэрээний дагуу хэрэгжүүлнэ. 56.2 заалтаар гадаад орны бүтээл ашиглагч нь тухайн орны хамтын удирдлагын байгууллагатай байгуулсан гэрээний дагуу бүтээл ашиглана.

Дүгнэлт 14

Хамтын удирдлагын байгууллага (ХУБ)-ыг зохиогч болон хамаарах эрх эзэмшигчдийн санаачлагаар байгуулах ба ХУБ нь зохиогчийн эрхийг хэрэгжүүлэх болон хамгаалах үйл ажиллагаа явуулахдаа оюуны өмчийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага (ОӨАЭТЗБ)-аас зөвшөөрөл авч, хамтран ажиллах гэрээ байгуулан ажиллахаар 52 дугаар зүйлд тусгасан бөгөөд гэрээний загварыг оюуны өмчийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн, бүтээл ашиглалтын төлбөрийн хэмжээг Зохиогчийн болон хамаарах эрхийн зөвлөл тус тус батална. ХУБ-ын зохиогчийн эрх болон хамаарах эрх эзэмшигчийн бүтээл ашиглах онцгой эрхийг төлөөлөн хэрэгжүүлэх болон үйл ажиллагаанд баримтлах журам, мөн ХУБ-д зөвшөөрөл олгох, байгууллагын үйл ажиллагаанд хяналт тавих, үнэлэх журмыг оюуны өмчийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална. ХУБ нь зохиогчийн эрх болон хамаарах эрх эзэмшигчдийг төлөөлж, тэдний нэрийн өмнөөс, тэднээс олгосон бүрэн эрхийн хүрээнд энэ хуульд заасан үйл ажиллагаа явуулна. ХУБ-ын үүргийг 54 дүгээр зүйлд дөрвөн чиглэлээр тоочин тусгасан бөгөөд үйл ажиллагааны зардал нь бүтээл ашиглалтын нийт төлбөрийн дүнгийн 20 хувиас ихгүй байхаар хязгаарласан. ОӨАЭТЗБ болон түүний гүйцэтгэх 13 чиг үүргийн талаар 51 дүгээр зүйлд заасан. 51.2 заалтаар хараагүй болон харааны бэрхшээлтэй, хэвлэмэл бүтээл ашиглах хязгаарлагдмал чадамжтай хүний хэрэгцээнд зориулан зохиогч, эрх эзэмшигчийн зөвшөөрөлгүйгээр бүтээлийг ашиглуулах зорилгоор хилээр нэвтрүүлэх зөвшөөрөл олгох эрх бүхий этгээдийг оюуны өмчийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага тогтооно. 51.3 заалтаар ОӨАЭТЗБ нь үйл ажиллагааныхаа орлогоор санхүүжих бөгөөд үйлчилгээний хөлсний хэмжээг оюуны өмчийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн тогтооно. ХУБ-ын үйл ажиллагаанд ОӨАЭТЗБ-ын зүгээс тавих хяналтыг 55 дугаар зүйлээр зохицуулж өгсөн. Гадаад орны зохиогчийн эрх болон хамаарах эрхийн хамтын удирдлагын байгууллагатай харилцах харилцааг 56 дугаар зүйлээр зохицуулсан. Иймд зохицуулалтууд зорилтдоо хүрч чаджээ.

15. “Зохиогчийн болон хамаарах эрхийн Зөвлөл байгуулан ажиллуулах эрх зүйн үндэслэлийг буй болгох” агуулга-ын хүрээнд:

- Зохиогчийн болон хамаарах эрхийн зөвлөлийн тухай 57 дугаар зүйлийн 57.1 заалтаар зохиогчийн болон хамаарах эрхийн зөвлөл /цаашид “Зөвлөл” гэх/ нь зохиогчийн эрхийн хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах чиглэлээр оюуны өмчийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад зөвлөх, хянах, гомдлыг урьдчилан шийдвэрлэх чиг үүрэг бүхий орон тооны бус зөвлөл байна. 57.2 заалтаар Зөвлөл нь дарга, 14 гишүүнээс бүрдэнэ. 57.3 заалтаар Зөвлөлийн ажлын албаны чиг үүргийг оюуны өмчийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага хэрэгжүүлнэ. 57.4 заалтаар Зөвлөлийн даргад оюуны өмчийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, гишүүдэд оюуны өмчийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага нэр дэвшүүлнэ. 57.5 заалтаар Зөвлөлийн бүрэлдэхүүнд оюуны өмчийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, оюуны өмчийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага, соёлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага, хамтын удирдлагын байгууллага, бүтээл ашиглагч болон оюуны өмчийн судлаач, шинжээч нарын төлөөллөөс бүрдсэн байна. 57.6 заалтаар Зөвлөлийн дарга болон гишүүдийг

оюуны өмчийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний шийдвэрээр 4 жилийн хугацаатайгаар томилж, чөлөөлнө. 57.7 заалтаар Зөвлөлийн дарга болон гишүүнээр хууль, оюуны өмчийн эрх зүй, эдийн засаг, бизнес, соёл урлагийн чиглэлээр мэргэжил эзэмшсэн, ажлын дадлага туршлагатай Монгол Улсын иргэнийг томилно. 57.8 заалтаар Зөвлөлийн бүрэлдэхүүн, үйл ажиллагааны дүрмийг оюуны өмчийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

- Зөвлөлийн чиг үүргийн тухай 58 дугаар зүйлийн 58.1 заалтаар Зөвлөл нь доор дурдсан чиг үүргийг хэрэгжүүлнэ хэмээн заасан. Үүнд: 58.1.1 заалтаар зохиогчийн эрх, хамаарах эрхийг хэрэгжүүлэх, хамгаалахтай холбоотой асуудлаар зөвлөмж, дүгнэлт гаргах; 58.1.2 заалтаар хамтын удирдлагын байгууллагаас санал болгож байгаа бүтээл ашиглалтын тарифыг хянан батлах, төлбөртэй холбоотой маргааныг урьдчилан хянан шийдвэрлэх; 58.1.3 заалтаар хамтын удирдлагын байгууллага болон бүтээл ашиглагчдын хооронд үүссэн маргааныг урьдчилан хянан шийдвэрлэх; 58.1.4 заалтаар хамтын удирдлагын байгууллага болон гишүүдийн хооронд үүссэн маргааныг урьдчилан хянан шийдвэрлэх; 58.1.5 заалтаар хууль тогтоомжид заасан болон оюуны өмчийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас даалгасан бусад чиг үүрэг тус тус хамаарна. 58.2 заалтаар Зөвлөл нь хамтын удирдлагын байгууллагаас санал болгож байгаа бүтээл ашиглалтын тарифын нөхцөл нь зах зээлийн үнэлгээнээс хэт өндөр, бүтээлийн хэвийн ашиглалт болон зохиогч, хамаарах эрх эзэмшигчийн эрх, хууль ёсны ашиг сонирхолд сөрөг нөлөө үзүүлэх магадлалтай гэж үзвэл энэ талаарх саналаа оюуны өмчийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад хүргүүлнэ. 58.3 заалтаар Зөвлөлийн маргаан шийдвэрлэх, зуучлах, бүтээл ашиглалтын тариф батлах болон бусад үйл ажиллагаанд баримтлах журмыг оюуны өмчийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална. 58.4 заалтаар Зөвлөлийн гишүүдийн ажлын хөлс, захиргааны зардлыг үйл ажиллагааны орлогоос санхүүжүүлнэ.

- Зөвлөлийн хуралдаан, шийдвэрийн тухай 59 дүгээр зүйлийн 59.1 заалтаар Зөвлөлийн үйл ажиллагааны үндсэн хэлбэр хуралдаан байна. 59.2 заалтаар Зөвлөлийг бүх гишүүдийн гуравны хоёроос доошгүй гишүүний ирцтэйгээр хуралдуулж, хуралдаанд оролцсон гишүүдийн олонхийн саналаар асуудлыг шийдвэрлэнэ. 59.3 заалтаар Зөвлөлийн шийдвэр нь тогтоол хэлбэртэй байх бөгөөд Зөвлөлийн дарга гарын үсэг зурж баталгаажуулсан байна. 59.4 заалтаар Зөвлөл нь зохиогчийн эрхийн хууль тогтоомж зөрчигдөхөөс урьдчилан сэргийлэх, маргаан үүссэн шалтгаан, түүний нөхцөлийг арилгуулах зорилгоор зөвлөмж, дүгнэлт гаргах эрхтэй.

- ОӨАЭТЗБ болон түүний гүйцэтгэх 13 чиг үүргийн талаар 51 дүгээр зүйлд заасан. 51.1.5 заалтаар хамтын удирдлагын байгууллага, бүтээл ашиглагчдын ашгийн бус байгууллага болон төрийн байгууллагыг зохиогчийн эрхийн талаар мэдээллээр хангах, зөвлөгөө өгөх, мэргэжил арга зүйн удирдлагаар хангана. 51.1.13-р заалтаар хамтын удирдлагын байгууллагад зөвшөөрөл олгох, гэрээ байгуулах, үйл ажиллагаанд нь хяналт тавих, үр дүнг тооцох чиг үүргийг заасан.

Дүгнэлт 15

57 дугаар зүйлд зааснаар зохиогчийн болон хамаарах эрхийн зөвлөл /цаашид “Зөвлөл” гэх/ нь зохиогчийн эрхийн хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах чиглэлээр оюуны өмчийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад зөвлөх, хянах, гомдлыг урьдчилан шийдвэрлэх чиг үүрэг бүхий орон тооны бус зөвлөл байна. 57.2 заалтаар Зөвлөл нь дарга, 14 гишүүнээс бүрдэнэ. Зөвлөлийн ажлын албаны чиг үүргийг оюуны өмчийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага хэрэгжүүлнэ. Зөвлөлийн бүрэлдэхүүнд оюуны өмчийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, оюуны өмчийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага, соёлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага, хамтын удирдлагын байгууллага, бүтээл ашиглагч болон оюуны өмчийн судлаач, шинжээч нарын

төлөөллөөс бүрдсэн байна. Зөвлөлийн бүрэлдэхүүн, үйл ажиллагааны дүрмийг оюуны өмчийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална. Зөвлөлийн чиг үүргийг 58 дугаар зүйлд заасан. Зөвлөлийн маргаан шийдвэрлэх, зуучлах, бүтээл ашиглалтын тариф батлах болон бусад үйл ажиллагаанд баримтлах журмыг оюуны өмчийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална. Зөвлөлийн гишүүдийн ажлын хөлс, захиргааны зардлыг үйл ажиллагааны орлогоос санхүүжүүлнэ. Зөвлөлийн хуралдаан, шийдвэрийн тухай 59 дүгээр зүйлд зааснаар Зөвлөлийн үйл ажиллагааны үндсэн хэлбэр хуралдаан байна. Зөвлөлийн шийдвэр нь тогтоол хэлбэртэй байх бөгөөд Зөвлөлийн дарга гарын үсэг зурж баталгаажуулсан байна. Зөвлөл нь зохиогчийн эрхийн хууль тогтоомж зөрчигдөхөөс урьдчилан сэргийлэх, маргаан үүссэн шалтгаан, түүний нөхцөлийг арилгуулах зорилгоор зөвлөмж, дүгнэлт гаргах эрхтэй. ОӨАЭТЗБ нь 51.1.13-р заалтын дагуу хамтын удирдлагын байгууллагад зөвшөөрөл олгох, гэрээ байгуулах, үйл ажиллагаанд нь хяналт тавих, үр дүнг тооцох чиг үүргийг заасан. Иймд зохицуулалтууд зорилтдоо хүрч чаджээ.

16. “Архив, музей, номын санд хадгалагдаж байгаа бүтээлийг ашиглах онцгой нөхцлийг тусгах” агуулга-ын хүрээнд:

- Архив, музей, номын санд хадгалагдаж байгаа бүтээлээс хэсэгчлэн ашиглах тухай 35 дугаар зүйлийн 35.1 заалтаар архив, музей, номын санд хадгалагдаж байгаа бүтээлийг доор дурдсан хэлбэрээр зохиогчийн зөвшөөрөлгүйгээр, төлбөргүйгээр хэсэгчлэн ашиглахыг зөвшөөрнө гэж үзсэн. Үүнд: 35.1.1 заалтаар архив, музей, номын санд ашиглагдаж байгаа бүтээлээс сургалт, судалгаа, эрдэм шинжилгээний бүтээл туурвих зорилгоор хэсэгчлэн хуулбарлах; 35.1.2 заалтаар архив, музей, номын санд хадгалагдаж байгаа бүтээлийг хадгалж хамгаалах зорилгоор гэмтсэн, элэгдэлд орсон, үрэгдэж алга болсон, хулгайд алдагдсан бүтээлийн хувийг нөхөн бүрдүүлэх боломжгүй гэж үзвэл нийтлэгдсэн бүтээлийг хуулбарлах, цахим хэлбэрт оруулах, тусгай форматад хөрвүүлэх замаар хуулбарлах; 35.1.3 заалтаар архив, музей, номын санд хадгалагдаж байгаа бүтээл устаж алга болсон, гэмтсэн, ашиглах боломжгүй болсон, алдагдсан бол тухайн бүтээлийн хуулбарыг хүлээн зөвшөөрөгдсөн бусад аргаар олж авах боломжгүй бол орлуулах зорилгоор адил төрлийн архив, номын сан, музейд хадгалагдаж байгаа бүтээлээс хэсэгчлэн хуулбарлах; 35.1.4 заалтаар хараа болон сонсголын согогтой, хөгжлийн бэрхшээлтэй хүний хэрэгцээнд зориулан архив, музей, номын санд хадгалагдаж байгаа бүтээлийг аливаа аргаар номын сангийн үйлчилгээний хүрээнд хэвлэмэл болон хэвлэмэл бус хэвлэлийн бүтээгдэхүүнийг гэрээр олгох, хүртээмжтэй форматад буулгах; 35.1.5 заалтаар номын сангийн сан хөмрөгт байгаа бүтээлд дүн шинжилгээ, хайлт хийх зорилгоор цахим мэдээллийн сан бүрдүүлэхийг хамруулжээ.

Дүгнэлт 16

35 дугаар зүйлд архив, музей, номын санд хадгалагдаж байгаа бүтээлээс тодорхой заасан хэлбэрээр зохиогчийн зөвшөөрөлгүйгээр, төлбөргүйгээр хэсэгчлэн ашиглахыг зөвшөөрнө гэж үзсэн. Иймд зохицуулалтууд зорилтдоо хүрч чаджээ.

17. “Хэвлэн нийтлэгдсэн бүтээлийг хараагүй болон харааны бэрхшээлтэй хүмүүст зориулан тэдний хүртэж болох хэлбэрт шилжүүлэх, уг бүтээлийг хилээр нэвтрүүлэх, хуулбарлах, нийтэд түгээхэд зохиогчийн эрхийг хязгаарлах, чөлөөлөхтэй холбоотой зохицуулалтыг тусгах” агуулга-ын хүрээнд:

- Хараа болон сонсголын согогтой, бусад хөгжлийн бэрхшээлтэй хүний хэрэгцээнд зориулан ашиглах тухай 34 дүгээр зүйлийн 34.1 заалтаар хараа болон сонсголын согогтой, бусад

хөгжлийн бэрхшээлтэй хүний хэрэгцээнд зориулан тэдний мэдээлэл олж авах, сурч боловсрох эрхийг хангах үүднээс доор дурдсан тохиолдолд зохиогчийн эрхийн зөвшөөрөлгүйгээр, төлбөргүйгээр ашиглаж болно гэжээ. Үүнд: 34.1.1 заалтаар хараа болон сонсголын согогтой, хөгжлийн бэрхшээлтэй хүнд боловсрол олгох, багшлах, сургалт, судалгаа хийх зорилгоор нийтлэгдсэн бүтээлээс хуулбарлах, түгээх, нийтийн хүртээл болгох; 34.1.2 заалтаар хүртээмжтэй хэлбэрт хувиргах; 34.1.3 заалтаар нийтэд дэлгэж үзүүлэх тус тус орно. 34.2 заалтаар хүртээмжтэй хэлбэр бүхий хуулбар гэдэгт аливаа бүтээлийг харааны бэрхшээлгүй, эсхүл хэвлэмэл бүтээл унших бэрхшээлгүй хүний адилаар чөлөөтэй хүлээн авахад нь зориулан бүтээсэн сонгох боломжтой төрөл, эсхүл хэлбэрт байх хуулбарыг ойлгоно. 34.3 заалтаар хүртээмжтэй хэлбэр бүхий хуулбарыг үр шим хүртэгч хүн тусгайлан ашиглах бөгөөд бүтээлийг үр шим хүртэгч хүний хэрэгцээнд зориулан хүртэх болон сонгох боломжтой хэлбэрт хөрвүүлэхдээ эх бүтээлийн халдашгүй байдлыг хүндэтгэн үзнэ. 34.4 заалтаар эрх бүхий байгууллага нь энэ хуулийн 34.7-д заасан шаардлагыг хангасан тохиолдолд зохиогчийн эрх эзэмшигчийн зөвшөөрөлгүйгээр аливаа бүтээлийг хүртээмжтэй хэлбэрт оруулан хуулбарлах, бусад эрх бүхий байгууллагаас уг хуулбарыг олж авах, үр шим хүртэгч хүнд ашгийн бус зорилгоор түрээслэх, эсхүл утастай болон утасгүй холбооны хэрэгслээр дамжуулан түгээх эрх эдэлнэ. 34.5 заалтаар эрх бүхий байгууллага гэдэгт үр шим хүртэгч хүнд зориулсан боловсрол, мэргэшсэн сургалт, номын сан, мэдээллээр хангах чиглэлээр үйл ажиллагаа эрхэлдэг Засгийн газраас эрх олгосон ашгийн төлөө бус байгууллагыг хэлнэ. 34.6 заалтаар эрх бүхий байгууллага нь доор дурьдсан үйл ажиллагааг эрхэлнэ гээд түүнд 34.6.1 ззаалтаар үр шим хүртэгч хүнд зориулан дагнасан үйлчилгээ үзүүлэх; 34.6.2 заалтаар үр шим хүртэгч хүн, эсхүл эрх бүхий байгууллагын хүртээмжтэй хэлбэр бүхий хуулбарыг түгээх, нийтийн хүртээл болгоход хязгаар тогтоох; 34.6.3 заалтаар зөрчилтэй хуулбарыг хуулбарлах, тараах болон нийтийн хүртээл болгох явдлыг хориглох, урьдчилан сэргийлэхийг хамааруулжээ. 34.7 заалтаар эрх бүхий байгууллага доор дурдсан шаардлагыг ханган ажиллана гээд 34.7.1 заалтаар тухайн бүтээл, эсхүл түүний хуулбарыг ашиглах хууль ёсны эрхтэй байх; 34.7.2 заалтаар аливаа бүтээлийг хүртээмжтэй хэлбэрт хөрвүүлэхдээ шаардагдах мэдээллийн дагуу хүртэж болох боломжтой хэлбэрт оруулж болох бөгөөд ингэхдээ тухайн бүтээлийг үр шим хүртэгч хүнд хүргэхэд зайлшгүй шаардагдах өөрчлөлтөөс бусад өөрчлөлтийг оруулахгүй байх; 34.7.3 заалтаар хүртээмжтэй хэлбэр бүхий хуулбарыг үр шим хүртэгч хүний хэрэгцээнд тусгайлан нийцүүлсэн байх; 34.7.4 заалтаар ашгийн бус зорилготой байхыг тус тус хамруулжээ. 34.9 заалтаар харааны болон сонсголын согогтой, бусад хөгжлийн бэрхшээлтэй хүнд үйлчилгээ үзүүлдэг төрийн болон ашгийн төлөө бус хуулийн этгээд, эсхүл эдгээрийн албан тушаалтан нь бүтээлийг энэхүү хүмүүст хүртээмжтэй хэлбэрт буулгах, гаднаас авах, тэдэнд түгээх, боловсролыг дэмжих зорилгоор мэдээллийн технологийн хэрэгслээр дамжуулан номын сангийн материалыг хүртээмжтэй болгож сургалтад ашиглах, бүтээлийг хичээлийн танхимд ашиглуулах, дэлгэж үзүүлэх, бүтээлийг зайны сургалтад зориулан хэсэгчлэн ашиглахыг зөвшөөрнө.

Дүгнэлт 17

34 дүгээр зүйлийн заалтуудаар хараа болон сонсголын согогтой, бусад хөгжлийн бэрхшээлтэй хүний хэрэгцээнд зориулан тэдний мэдээлэл олж авах, сурч боловсрох эрхийг хангах үүднээс доор дурдсан тохиолдолд зохиогчийн эрхийн зөвшөөрөлгүйгээр, төлбөргүйгээр ашиглаж болно гэжээ. Эрх бүхий байгууллага нь энэ хуулийн 34.7-д заасан шаардлагыг хангасан тохиолдолд зохиогчийн эрх эзэмшигчийн зөвшөөрөлгүйгээр аливаа бүтээлийг хүртээмжтэй хэлбэрт оруулан хуулбарлах, бусад эрх бүхий байгууллагаас уг хуулбарыг олж авах, үр шим хүртэгч хүнд ашгийн бус зорилгоор түрээслэх, эсхүл утастай болон утасгүй холбооны хэрэгслээр дамжуулан түгээх эрх эдэлнэ. Иймд зохицуулалтууд зорилтдоо хүрч чаджээ.

18. “Зохиогч, зохиогчийн эрх эзэмшигч хүсвэл бүтээл болон бүтээл ашиглах онцгой эрхийг шилжүүлэх, шилжүүлэх гэрээ, хэлцлийг сайн дурын үндсэн дээр бүртгүүлэх, бүртгэлийн журам батлуулах талаар зохицуулах” агуулга-ын хүрээнд:

- Бүтээл ашиглах онцгой эрхийг шилжүүлэх тухай 15 дугаар зүйлийн 15.1 заалтаар энэ хуулийн 12.2 дахь хэсэгт заасан эрхийг зөвхөн зохиогчийн зөвшөөрлөөр, бичгээр хийсэн гэрээний үндсэн дээр бусдад шилжүүлж болно.
- Зохиогчийн эрх үүсэх, баталгаажих тухай 9 дүгээр зүйлийн 9.1 заалтаар шинжлэх ухаан, утга зохиол, урлагийн бүтээлийн зохиогчийн эрх нь тухайн бүтээлийг бодитойгоор туурвиж, бодит хэлбэрт орсон үеэс үүснэ. 9.2 заалтаар зохиогчийн эрх үүсэх болон түүнийг хэрэгжүүлэхэд баталгаажуулалт шаардахгүй. 9.3 заалтаар бүтээл ашиглах онцгой эрх эзэмшигч нь эрхээ нийтэд таниулах зорилгоор зохиогчийн эрх хамгаалагдсаныг илэрхийлэх таних тэмдэг хэрэглэх эрхтэй. 9.4 заалтаар зохиогч болохыг нотлох баримтгүй тохиолдолд эх бүтээл болон бүтээлийн хувь дээр бичигдсэн нэрийг зохиогч гэж тооцно. 9.5 заалтаар зохиогч, зохиогчийн эрх эзэмшигч хүсвэл бүтээл болон бүтээл ашиглах онцгой эрхийг шилжүүлэх гэрээ, хэлцлийг оюуны өмчийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад сайн дурын үндсэн дээр бүртгүүлж болно. 9.6 заалтаар энэ хуулийн 9.5-д заасан бүртгэл хийх журмыг оюуны өмчийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална. 9.7 заалтаар энэ хуулийн 9.3-т заасан таних тэмдгийг дараахь байдлаар илэрхийлж болно. Үүнд: 9.7.1. дугуй хүрээ бүхий латин “С” үсэг буюу ©; 9.7.2. бүтээл ашиглах онцгой эрх эзэмшигчийн нэр; 9.7.3. бүтээлийг анх нийтийн хүртээл болгосон огноо тус тус багтана.
- Зохиогчийн эрхийн бүтээлийг ашиглах тухай 28 дугаар зүйлийн 28.1.1 заалтаар бүтээл ашиглах онцгой эрхийг шилжүүлнэ. 28.1-д заасны дагуу бүтээлийг ашиглуулахад талууд гэрээг бичгээр байгуулах бөгөөд гэрээнд 28.4.2 заалтаар бүтээл ашиглах онцгой эрхийг шилжүүлэх, эсхүл ашиглуулах эрх олгох эсэхийг тодорхойлох; 28.4.3 заалтаар бүтээл ашиглах онцгой эрхийг шилжүүлэх тохиолдолд шилжүүлж байгаа эрхүүд; 28.4.4 заалтаар бүтээлийг ашиглах онцгой эрхийг ашиглах эрх олгох тохиолдолд олгож байгаа эрхүүд, лицензийн гэрээний төрөл, эрх дамжуулах эсэх зэрэг нөхцөлийг тусгасан байна. 28.5 заалтаар гэрээнд өөрөөр заагаагүй бол зохиогч бусдад бүтээлийн эх хувь эсхүл хуулбарын өмчлөх эрхийг шилжүүлсэн нь зохиогчийн тус бүтээл дэх бүтээл ашиглах онцгой эрхийг шилжүүлсэнд тооцохгүй.
- Эрх шилжүүлэх гэрээний тухай 30 дугаар зүйлийн 30.1 заалтын дагуу бүтээл ашиглах онцгой эрхийг гэрээний үндсэн дээр бүрэн, эсхүл хэсэгчлэн бусад этгээдэд шилжүүлж болно. 30.2 заалтаар эрх шилжүүлэх гэрээнд зохиогч хойшид тухайн сэдвээр буюу тухайн салбарт бүтээл туурвихыг хязгаарласан заалт оруулахыг хориглоно. 30.3 заалтаар зохиогчийн бүтээл ашиглах онцгой эрхийг гэрээний дагуу шилжүүлэн авсан этгээд гэрээгээр хүлээсэн үүргээ хангалтгүй хэрэгжүүлсний улмаас зохиогчийн эрх зөрчигдсөн бол зохиогч уг эрхээ сэргээхийг шаардах эрхтэй. 30.4 заалтаар эрх шилжүүлэх гэрээнд тусгайлан заагаагүй бусад бүтээл ашиглах онцгой эрх нь зохиогч, зохиогчийн эрх эзэмшигчид хэвээр хадгалагдана.
- Лицензийн гэрээний тухай 29 дүгээр зүйлийн 29.1 заалтын дагуу энэ хуулийн 28.1.2 заалтаар бүтээл ашиглах онцгой эрхийг дараахь төрлийн лицензийн гэрээгээр ашиглах эрх олгоно. Үүнд: 29.1.1 заалтаар зохиогч, зохиогчийн эрх эзэмшигч бүтээлийг лиценз авагчаас өөр бусад этгээдэд давхар ашиглуулах эрхээ хадгалан бүтээл ашиглах эрх олгож байгаа энгийн лиценз; 29.1.2 заалтаар зохиогч, зохиогчийн эрх эзэмшигч бүтээлийг лиценз авагчаас өөр бусад этгээдэд ашиглуулахгүйгээр зөвхөн тухайн этгээдэд олгож байгаа бүтээл ашиглах эрх олгож байгаа онцгой лиценз тус тус хамрагдана. 29.2 заалтаар энгийн лиценз олгож байгаа зохиогч, зохиогчийн эрх эзэмшигч нь лиценз авагчийн хүсэлтээр бусад этгээдэд олгосон лицензийн мэдээллийг өгч болно. 29.3 заалтын дагуу онцгой лицензээр зохиогч, зохиогчийн эрх эзэмшигч нь бүтээлийг зөвхөн лицензийн гэрээнд тусгайлан заасан нөхцөлийн

дагуу зөвхөн лиценз авагчид ашиглуулж, бусад этгээдэд давхар ашиглуулахгүй байх нөхцөлийг олгоно. 29.4 заалтаар онцгой лицензийн гэрээнд бүтээл ашиглах нутаг дэвсгэрийн хязгаар, ашиглах хугацаа, олгож байгаа эрхийг нарийвчилан тодорхойлсон байна. 29.5 заалтаар энгийн болон онцгой лицензийн гэрээнд тусгайлан заагаагүй бусад бүтээл ашиглах онцгой эрх нь зохиогч, зохиогчийн эрх эзэмшигчид хэвээр хадгалагдана. 29.6 заалтаар бүтээл ашигласны төлбөрийн хэмжээг тухайн бүтээлийн шинж чанар, онцлог, ач холбогдол, бүтээлийг ашиглах хэлбэр, хэмжээ, хугацаа зэргээс хамааран хоёр талын хэлэлцэн тогтоосон нэгж үнийн дүнгээр эсхүл нийт үнийн дүнгээр тодорхойлж болно. 29.7 заалтаар энэ хуулийн 29.6-д заасны дагуу бүтээлийн төлбөрийн хэмжээг нэгж үнийн дүнгээр тодорхойлсон бол зохиогч, зохиогчийн эрх эзэмшигч нь лиценз авагчаас олсон орлого, борлуулалтын талаарх мэдээллийг шаардах эрхтэй.

Иймд зохицуулалтууд зорилтдоо хүрч чаджээ.

19. “Зохиогчийн эрх, хамаарах эрхийг зөрчих, зөрчигчдөд хүлээлгэх хариуцлагыг тодорхой болгох” агуулга-ын хүрээнд:

- Зохиогчийн эрх, хамаарах эрхийн хэрэгжилтийг хангах, зохиогчийн эрх, хамаарах эрхийг зөрчих тухай 64 дүгээр зүйлийн 64.1 заалтаар зохиогчийн эрх болон хамаарах эрхээр хамгаалах бүтээлийн зохиогчийн эрх, хамаарах эрхийг дараахь тохиолдолд зөрчсөнд тооцно. Үүнд: 64.1.1. зохиогчийн эрх, хамаарах эрхийн бүтээлийг зохиогч эрх болон хамаарах эрх эзэмшигчийн зөвшөөрөлгүйгээр, гэрээ байгуулалгүйгээр ашиглах, гэрээний нөхцөл, журмыг зөрчих; 64.1.2. зохиогчийн эрх, хамаарах эрхийн зөрчилтэй бараа бүтээгдэхүүнийг ашгийн зорилгоор үйлдвэрлэх, импортлох, экспортлох, түгээх, тээвэрлэх; 64.1.3. энэ хууль болон гэрээнд заасан төлбөрийг төлөхөөс татгалзах; 64.1.4. зохиогч болон гүйцэтгэгч уран бүтээлчийн эдийн бус баялгийн эрхийг зөрчих; 64.1.5. интернетийн /цахим/ холбоос хийх, олон нийтийн сүлжээнд зөвшөөрөлгүйгээр байршуулах, хөгжүүлэлт хийх тус тус багтана.
- Зохиогчийн эрх болон түүнд хамаарах эрхийн хууль тогтоомж зөрчигчдөд хүлээлгэх хариуцлагын тухай 65 дугаар зүйлийн 65.1 заалтаар зохиогчийн эрх болон түүнд хамаарах эрхийн тухай хууль тогтоомж зөрчсөн этгээдэд Эрүүгийн хууль, эсхүл Зөрчлийн тухай хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ. 65.2 заалтаар бүтээл ашиглах онцгой эрхийг зөрчсөнөөс учирсан эд хөрөнгийн хохирлыг нөхөн төлүүлэх асуудлыг Монгол Улсын Иргэний хуулийн дагуу шийдвэрлэнэ. 65.3 заалтаар эрх нь зөрчигдсөн зохиогчийн эрх болон хамаарах эрх эзэмшигч хүсэлт гаргасан тохиолдолд түүнд зөрчилтэй бүтээгдэхүүнийг хохирлынх нь төлбөрт тооцон шилжүүлэх, хүсэлт гаргаагүй бол зөрчилтэй бараа, бүтээгдэхүүнийг устгах арга хэмжээг авна. 65.4 заалтаар энэ хуулийг зөрчиж, зохиогчийн эрхийн бүтээл болон хамаарах эрхийн бүтээлийг ашиглах болон хуулбарлахад ашигласан эд зүйл, техник хэрэгслийг хураан авч, улсын орлого болгоно.
- Хамтын удирдлагын байгууллагын үйл ажиллагаанд тавих хяналтын тухай 55 зүйлийн 55.3 заалтаар Оюуны өмчийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага тодорхой зөрчлийн 4 тохиолдолд хамтын удирдлагын байгууллагын үйл ажиллагаа явуулах зөвшөөрлийг 3 сар хүртэл хугацаагаар түдгэлзүүлнэ. 55.4 заалтаар оюуны өмчийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага тодорхой тохиолдлуудад хамтын удирдлагын байгууллагатай байгуулсан хамтран ажиллах гэрээг цуцалж, үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг хүчингүй болгоно. Иймд зохицуулалтууд зорилтдоо хүрч чаджээ.

4.2. “ОЙЛГОМЖТОЙ БАЙДАЛ”-ЫН ҮНЭЛГЭЭ

4.2.1. Зохиогчийн эрх болон түүнд хамаарах эрхийг хэрэгжүүлэх эрх зүйн харилцааны цогц байдал, логик бүтцийн ойлгомжтой байдлыг дараах бүтцээр шинжилж үнэлэв. Үүнд:

1. Хууль тогтоомжийн харилцан уялдаат байдал

а. Зохиогчийн эрх болон түүнд хамаарах эрхийн хууль тогтоомжийн тухай 2 дугаар зүйлийн 2.1 заалтын дагуу зохиогчийн эрх болон түүнд хамаарах эрхийн хууль тогтоомж нь Монгол Улсын Үндсэн хууль, Иргэний хууль, энэ хууль болон тэдгээртэй нийцүүлэн гаргасан хууль тогтоомжоос бүрдэнэ гэж заасан.

2. Зохиогчийн эрх эдлэх этгээд ба төлбөр авах эрх

а. Зохиогчийн эрх эдлэх этгээдийг 4 дүгээр зүйлийн заалтуудаар тодорхойлж өгсөн.

б. Хамаарах эрх эдлэх этгээдийг 41 дүгээр зүйлийн заалтуудад тодорхойлж өгсөн.

с. Зохиогчийн эрх эдлэх этгээдийн тухай 4 дүгээр зүйлийн 4.4. заалтаар зохиогчийн бүтээл ашиглах онцгой эрхийг эзэмшиж байгаа хувь хүн, хуулийн этгээд, төрийн байгууллага нь бүтээлийг ашиглуулснаас зохих төлбөр авах эрхтэй бөгөөд хууль, эсхүл гэрээнд өөрөөр заагаагүй бол төлбөрөөс бүтээлийн зохиогчид зохих төлбөр төлөх үүрэгтэй.

3. Зохиогчийн эрхээр хамгаалах ба үл хамгаалах бүтээл болон түүнд хамаарах эрхтэй холбогдох объект

а. Зохиогчийн эрхээр хамгаалах бүтээлийг 7 дугаар зүйлийн заалтуудаар тогтоож өгсөн. Зохиогчийн эрхийн бүтээлийн тухай 6 дугаар зүйлийн 6.1 заалтаар зохиогчийн эрхийн бүтээлд агуулга, зориулалт, үнэ цэнэ, ач холбогдол, илэрхийллийн аргаасаа үл шалтгаалан зохиогчийн оюуны бүтээлч үйл ажиллагааны үр дүнд бий болсон шинжлэх ухаан, утга зохиол, урлагийн эх бүтээлийг тооцно гэж заасан. 6.2 заалтаар зохиогчийн эрхийн бүтээлийг нийтийн хүртэл болсон эсэхээс үл хамааран бичмэл, аман, зурмал болон бусад бодит хэлбэрээр туурвисан байна.

б. Зохиогчийн эрхээр үл хамгаалах бүтээлийг 8 дугаар зүйлийн заалтуудаар тогтоож өгсөн.

с. Хамаарах эрхийн объектийг 6 дугаар бүлгийн 42.1 заалтаар: гүйцэтгэгч уран бүтээлчийн хамаарах эрхийн объект, фонограм, дуу авиа бүхий дүрст бичлэг бүтээгчийн хамаарах эрхийн объект, өргөн нэвтрүүлгийн байгууллагын хамаарах эрхийн объект гэж ангилан зааж өгсөн.

4. Зохиогчийн эрхийг баталгаажуулах, хамгаалах, өвлөх, хязгаарлах

а. Зохиогчийн эрх үүсэх, баталгаажих тухай 9 дүгээр зүйлийн 9.1 заалтаар шинжлэх ухаан, утга зохиол, урлагийн бүтээлийн зохиогчийн эрх нь тухайн бүтээлийг бодитойгоор туурвиж, бодит хэлбэрт орсон үеэс үүснэ. 9.2 заалтаар зохиогчийн эрх үүсэх болон түүнийг хэрэгжүүлэхэд баталгаажуулалт шаардахгүй. 9.3 заалтаар бүтээл ашиглах онцгой эрх эзэмшигч нь эрхээ нийтэд таниулах зорилгоор зохиогчийн эрх хамгаалагдсаныг илэрхийлэх таних тэмдэг хэрэглэх эрхтэй.

б. Зохиогчийн эдлэх эрхийн тухай 10 дугаар зүйлийн 10.1 заалтын дагуу зохиогч бүтээлийнхээ хувьд эдийн бус баялгийн эрх болон бүтээл ашиглах онцгой эрх эдэлнэ.

с. Хамаарах эрх эзэмшигчийн эдлэх эрхийн тухай 42 дугаар зүйлийн 42.1.1 заалтын дагуу гүйцэтгэгч уран бүтээлчийн эдийн бус баялгийн эрх болон хамаарах эрхийн объект ашиглах онцгой эрх; 42.1.2 заалтын дагуу фонограм, дуу авиа бүхий дүрст бичлэг бүтээгчийн хамаарах эрхийн объект ашиглах онцгой эрх; 42.1.3 заалтын дагуу өргөн нэвтрүүлгийн байгууллагын хамаарах эрхийн объект ашиглах онцгой эрхүүд тус тус баталгаажсан.

d. Зохиогчийн эрхийг өвлөх тухай 14 зүйлийн 14.1 заалтын дагуу зохиогчийн бүтээл ашиглах онцгой эрхийг Монгол Улсын Иргэний хуульд заасан журмын дагуу өв залгамжилна. 14.4 заалтын дагуу зохиогчийн эдийн бус баялгийн эрх өвлөгдөхгүй.

Зохиогчийн эрхийг хязгаарлах тухай 31 дүгээр зүйлийн 31.1 заалтын дагуу бүтээлийг зохиогч, зохиогчийн эрх эзэмшигчийн зүй ёсны ашиглалттай зөрчилдөхгүйгээр, эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хөндөлгүйгээр 31.1.1-31.1.11 заалтуудын дагуу ашигласан тохиолдолд зохиогчийн эрхийн зөрчилд тооцохгүй хэмээн үзсэн. Ингэхдээ 31.2 заалтын дагуу 31.1-д зааснаар бүтээлийг ашиглах тохиолдолд эх сурвалжыг заавал дурдана.

е. 50 дугаар зүйл. Хамаарах эрхийг хязгаарлах тухай 50 дугаар зүйлийн 50.1 заалтын дагуу энэ хуулийн 41.1-д заасан хамаарах эрх эдлэх этгээд болон хамаарах эрх эзэмшигчийн зүй ёсны ашиглалттай зөрчилдөхгүйгээр, эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хөндөлгүйгээр хамаарах эрхийн объектыг энэ хуулийн 31-40 дүгээр зүйлд заасан үндэслэл, нөхцөлийн дагуу зөвшөөрөлгүйгээр, үнэ төлбөргүйгээр ашиглаж болно. Ингэхдээ 50.2 заалтын дагуу энэ хуулийн 50.1-д зааснаар хамаарах эрхийн объектыг ашиглах тохиолдолд эх сурвалжыг заавал дурдана.

5. Зохиогчийн эрхийг хязгаарлахад тавигдах нөхцөл

а. Зохиогчийн эрхийг хязгаарлахад тавигдах нөхцлийн тухай 40 дүгээр зүйлийн 40.1 заалтын дагуу энэ хуулийн 31 дүгээр зүйлд заасан тохиолдлыг тодорхойлохдоо дараахь нөхцөлийг харгалзан үзнэ. Үүнд: 40.1.1. ашиг олох зорилгогүй байх; 40.1.2. бүтээл ашиглалт нь шударга ашиглалттай нийцэж, ашигласан цар хүрээ нь зорилгоосоо хэтрээгүй байх. 40.2. энэ хуулийн 31 дүгээр зүйлд зааснаар бүтээлийг ашиглахдаа зохиогчийн нэр, эх сурвалжийг заавал дурдана.

6. Зохиогчийн эрхийг ашиглах ба ашиглуулах

а. Бүтээл ашиглах онцгой эрхийн тухай 12 зүйлийн 12.1 заалтын дагуу зохиогч нь өөрийн бүтээлийг бүхий л арга, хэлбэрээр ашиглах онцгой эрх эдэлнэ.

б. Бүтээл ашиглах онцгой эрхийг шилжүүлэх тухай 15 дугаар зүйлийн 15.1 заалтын дагуу энэ хуулийн 12.2 дахь хэсэгт заасан эрхийг зөвхөн зохиогчийн зөвшөөрлөөр, бичгээр хийсэн гэрээний үндсэн дээр бусдад шилжүүлж болно. Зөвшөөрөл нь энэ хуулийн 28.4-т заасан нөхцөл, шаардлагыг хангасан байхыг үүсмэл бүтээлийн зохиогчийн эрхийн тухай 16 дугаар зүйл, түүвэр зохиол, бусад эмхэтгэл бүтээлийн зохиогчийн эрхийн тухай 17 дугаар зүйлд тус тус заасан байна.

Зохиогчийн эрхийн бүтээлийг ашиглах тухай 28 дугаар зүйлийн 28.1 заалтын дагуу зохиогч, зохиогчийн эрх эзэмшигч нь бүтээлийг бусад этгээдэд дараахь үндэслэлээр ашиглуулна хэмээн заасан. Үүнд: 28.1.1. бүтээл ашиглах онцгой эрхийг шилжүүлэх; 28.1.2. бүтээл ашиглах онцгой эрхийг ашиглах эрх олгох тус тус хамаарна. Лицензийн гэрээний тухай 29 дүгээр зүйлийн 29.1 заалтын дагуу энэ хуулийн 28.1.2-т заасны дагуу бүтээл ашиглах онцгой эрхийг лицензийн гэрээгээр ашиглах эрх олгоно.

с. Бүтээл ашиглах онцгой эрхийн тухай 12 дугаар зүйлийн 12.2 заалтын дагуу зохиогчийн бүтээл ашиглах онцгой эрхэд зохиогч дараахь үйл ажиллагааг зөвшөөрөх болон хориглох онцгой эрхийг хамааруулна. Үүнд: 12.2.1. хуулбарлах; 12.2.2. түгээх; 12.2.3. дамжуулах; 12.2.4. нийтлэх; 12.2.5. орчуулах, эсхүл өөр хэлбэрээр үүсмэл бүтээл болгон өөрчлөх; 12.2.6. түрээслэх, зээлдүүлэх; 12.2.7. нийтэд дэлгэж үзүүлэх тус тус багтана.

7. Бүтээлийг хэсэгчлэн ашиглах ба эшлэл авах

а. Мэдээллийн зорилгоор бүтээлийг хэсэгчлэн ашиглаж болох 4 чиглэлийг 32 дугаар зүйлд зааж зохицуулсан. Эрдэм шинжилгээ, судалгаа, сургалтын зорилгоор бүтээлийг хоёр чиглэлээр хэсэгчлэн ашиглаж болохыг 33 дугаар зүйлд оруулсан байгаа ч ашигласан хэмжээ нь 5 хувиас хэтрэхгүй байхаар тогтоосон.

b. Архив, музей, номын санд хадгалагдаж байгаа бүтээлээс зохиогчийн зөвшөөрөлгүйгээр, төлбөргүйгээр үндсэн таван хэлбэрээр хэсэгчлэн ашиглах боломжийг 35 дугаар зүйлд зааж оруулсан. Амины хэрэгцээнд зориулан бүтээлийг хоёр үндсэн хэлбэрээр ашиглах боломжийг 36 дугаар зүйлд заасан бөгөөд тэдгээр хэлбэрүүд нь барилга байгууламж, архитектурын бүтээл, компьютерийн програм, мэдээллийн санг хамрахгүй байхаар заасан.

c. Барилга байгууламж, архитектурыг ашиглахдаа зохиогчийн нэр, эх сурвалжийг дурдсан ашиг олох зорилгогүй, ашигласан цар хүрээ нь зорилгоосоо хэтрээгүй бол зохиогчийн зөвшөөрөлгүйгээр, төлбөргүйгээр үндсэн хоёр хэлбэрээр бүтээл ашиглаж болохыг 39 дүгээр зүйлээр хуульчилж өгсөн. Зохиогчийн эрхийг хязгаарлахад тавигдах хоёр үндсэн нөхцлийг 40 дүгээр зүйлд зааж оруулсан бөгөөд нөхцлөөс зохиогчийн нэр, эх сурвалжийг заавал дурдана гэжээ.

d. Эшлэх зорилгоос хэтрэлгүйгээр тухайн бүтээлийн зохиогч, зохиогчийн эрх эзэмшигчийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хөндөлгүйгээр бүтээлээс эшлэл авах боломжийг 37 дугаар зүйл зүйлд тусгаж өгсөн.

8. Бүтээлийг зохиогч, зохиогчийн эрх эзэмшигчийн эрх, хууль ёсны шиг сонирхлыг хөндөхгүйгээр бүтээлийг нь зөвшөөрөлгүйгээр болон төлбөргүйгээр ашиглах

a. Хараа болон сонсголын согогтой, бусад хөгжлийн бэрхшээлтэй хүний хэрэгцээнд зориулан зохиогчийн эрхийн зөвшөөрөлгүйгээр, төлбөргүйгээр ашиглаж болох гурван чиглэлийг 34 дүгээр зүйлд оруулсан бөгөөд үндсэн дөрвөн нөхцлийг хангасан эрх бүхий байгууллага бүтээлийн үйлчилгээ үзүүлэх эрх авах боломжийг заасан. Мөн 51.2 заалтаар хараагүй болон харааны бэрхшээлтэй, хэвлэмэл бүтээл ашиглах хязгаарлагдмал чадамжтай хүний хэрэгцээнд зориулан зохиогч, эрх эзэмшигчийн зөвшөөрөлгүйгээр бүтээлийг ашиглуулах зорилгоор хилээр нэвтрүүлэх зөвшөөрөл олгох эрх бүхий этгээдийг оюуны өмчийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага тогтооно.

9. Зохиогчийн эрхийн хамгаалалтын хугацаа

a. Зохиогчийн эрхийн хамгаалалтын хугацааны тухай 13 дугаар зүйлийн 13.2 заалтаар зохиогчийн бүтээл ашиглах онцгой эрх нь зохиогчийн насан туршид болон нас барсны дараа жилийн 1 дүгээр сарын 1-нээс эхлэн 70 жилийн хугацаанд хүчин төгөлдөр байна.

b. 13.3 заалтын дагуу зохиогчийн эдийн бус баялгийн эрхийг хугацаа хязгаарлахгүй хамгаална.

c. 13.4 заалтын дагуу зохиогч бүтээлээ зохиомол, нууц нэрээр, эсхүл нэргүйгээр нийтэлсэн тохиолдолд уг зохиогчийн бүтээл ашиглах онцгой эрх нь бүтээлийг анх нийтийн хүртээл болсны дараа жилийн 1 дүгээр сарын 1-нээс эхлэн 75 жилийн хугацаанд хүчин төгөлдөр байна.

d. 13.6 заалтаар хамтын бүтээлийн зохиогчийн эрх нь зохиогчдын насан туршид болон сүүлчийн зохиогч нас барсны дараа жилийн 1 дүгээр сарын 1-нээс эхлэн 70 жилийн хугацаанд хамгаалагдана.

e. Хамаарах эрхийн хугацааны тухай 47 дугаар зүйлийн 47.1 заалтын дагуу энэ хуулийн 41.1-д заасан хамаарах эрх эдлэх этгээд болон хамаарах эрх эзэмшигчийн хамаарах эрхийн объектыг хамгаалах хугацаа нь хамаарах эрхийн объектийг туурвисан, эсхүл гүйцэтгэсэний дараа жилийн 1 дүгээр сарын 1-нээс эхлэн 50 жилийн хугацаанд хүчин төгөлдөр байна.

f. 13.7 заалтын дагуу эрх эзэмшигчийн эзэмшиж байгаа бүтээлийн зохиогчийн эрхийн хамгаалалтын хугацаа нь бүтээлийн зохиогчийн эдлэх эрхийн хугацаатай ижил байна.

g. 14.3 заалтаар өв залгамжлагчийн бүтээл ашиглах онцгой эрхийн хугацаа зохиогч нас барсны дараа жилийн 1 дүгээр сарын 1-нээс эхлэн 70 жилийн хугацаанд үйлчилнэ.

“Ойлгомжтой байдлын үнэлгээ”-ний ерөнхий дүгнэлт

Зохиогчийн эрх болон түүнд хамаарах хуулийн шинэчилсэн найруулгын эхээс эрх зүйн зохицуулалтын зүйл заалтуудыг хуулийн үзэл баримтлалын хүрээний цогц байдал, логик бүтцийн дагуу хуваариалан авч үзэхэд ойлгомжтой байгаа нь илт байна.

4.3. “ХАРИЛЦАН УЯЛДАА”-Т БАЙДЛЫН ҮНЭЛГЭЭ

4.3.1. Зөвшөөрөл олгох, журам батлах, төлбөрийн хэмжээ тогтоох зохицуулалт

Энэ хуулийн хүрээнд оюуны өмчийн холбогдолтой байгууллагууд хоорондын эрх зүйн харилцаат байдал, зохицуулах журмын хүрээний асуудлыг дараах байдлаар уялдуулан харах боломжтой байна. Үүнд:

1. Зохиогчийн эрх эдлэх этгээдийн тухай 4 дүгээр зүйлийн 4.7 заалтаар энэ хуулийн 4.6-д заасан бүтээл ашигласан төлбөрийг нөхөж олгохтой холбоотой журмыг Засгийн газар батална.
2. Зохиогчийн эрх үүсэх, баталгаажих тухай 9 дүгээр зүйлийн 9.6 заалтаар энэ хуулийн 9.5-д заасан бүртгэл хийх журмыг оюуны өмчийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.
3. Зохиогчийн эрхийг өвлөх тухай 14 дүгээр зүйлийн 14.1 заалтаар зохиогчийн бүтээл ашиглах онцгой эрхийг Монгол Улсын Иргэний хуульд заасан журмын дагуу өв залгамжилна.
4. Энэ хуулийн 51 дүгээр зүйлийн 51.2 заалтын дагуу хараагүй болон харааны бэрхшээлтэй, хэвлэмэл бүтээл ашиглах хязгаарлагдмал чадамжтай хүний хэрэгцээнд зориулан зохиогч, эрх эзэмшигчийн зөвшөөрөлгүйгээр бүтээлийг ашиглуулах зорилгоор хилээр нэвтрүүлэх зөвшөөрөл олгох эрх бүхий этгээдийг оюуны өмчийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага тогтооно. 51.3 заалтын дагуу оюуны өмчийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага үйл ажиллагааныхаа орлогоор санхүүжих бөгөөд үйлчилгээний хөлсний хэмжээг оюуны өмчийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн тогтооно.
5. Энэ хуулийн 52 дугаар зүйлийн 52.4 заалтын дагуу энэ хуулийн 52.8-д заасан шаардлага хангасан хамтын удирдлагын байгууллага нь зохиогчийн эрхийг хэрэгжүүлэх болон хамгаалах үйл ажиллагаа явуулахдаа оюуны өмчийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагаас зөвшөөрөл авч, хамтран ажиллах гэрээ байгуулан ажиллана. 52.6 заалтаар хамтран ажиллах гэрээний загварыг оюуны өмчийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.
6. 52.8 заалтын дагуу энэ хуулийн 52.5, 52.7-д заасан шаардлагыг хангаагүй, бүрдэл дутуу, хуурамчаар бүрдүүлсэн, эсхүл санал болгож байгаа бүтээл ашиглалтын төлбөрийн хэмжээг Зохиогчийн болон хамаарах эрхийн зөвлөл үндэслэлгүй гэж үзсэн бол оюуны өмчийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага зөвшөөрөл олгохоос татгалзана.
7. 52.9 заалтаар энэ хуулийн 52.5.4-т заасан бүтээл ашиглалтын төлбөрийн хэмжээг Зохиогчийн болон хамаарах эрхийн зөвлөл батална.
8. Хамтын удирдлагын байгууллагын үйл ажиллагааны тухай 53 дугаар зүйлийн 53.3 заалтын дагуу хамтын удирдлагын байгууллагын зохиогчийн эрх болон хамаарах эрх эзэмшигчийн бүтээл ашиглах онцгой эрхийг төлөөлөн хэрэгжүүлэх болон үйл ажиллагаанд баримтлах журмыг оюуны өмчийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.
9. 53.4 заалтын дагуу хамтын удирдлагын байгууллагад зөвшөөрөл олгох, байгууллагын үйл ажиллагаанд хяналт тавих, үнэлэх журмыг оюуны өмчийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.
10. Хамтын удирдлагын байгууллагын үйл ажиллагаанд тавих хяналтын тухай 55 дугаар зүйлийн 55.1 заалтаар хамтын удирдлагын байгууллагын үйл ажиллагаанд оюуны өмчийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага хяналт тавина.

11. 55.7 заалттын дагуу хамтын удирдлагын байгууллагыг татан буулгах тохиолдолд оюуны өмчийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагаас зөвшөөрөл авна.
12. Зохиогчийн болон хамаарах эрхийн зөвлөлийн тухай 57 дугаар зүйлийн 57.3 заалтын дагуу Зөвлөлийн ажлын албаны чиг үүргийг оюуны өмчийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага хэрэгжүүлнэ.
13. 57.6 заалтаар Зөвлөлийн дарга болон гишүүдийг оюуны өмчийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний шийдвэрээр 4 жилийн хугацаатайгаар томилж, чөлөөлнө.
14. 57.8 заалтын дагуу Зөвлөлийн бүрэлдэхүүн, үйл ажиллагааны дүрмийг оюуны өмчийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.
15. Зөвлөлийн чиг үүргийн тухай 58 дугаар зүйлийн 58.3 заалтын дагуу Зөвлөлийн маргаан шийдвэрлэх, зуучлах, бүтээл ашиглалтын тариф батлах болон бусад үйл ажиллагаанд баримтлах журмыг оюуны өмчийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.
16. 66.3 заалттын дагуу зохиогчийн эрхийн хамгаалалтын хугацаа дууссан бүтээлийн зохиогчийн нэр, нэр төр, алдар хүндийг оюуны өмчийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага хамгаална. Шилжилтийн зохицуулалтын тухай 66 дугаар зүйлийн 66.1 заалтын дагуу 1993 оны 09 дүгээр сарын 01-ний өдрөөс өмнө туурвисан бүтээлийн зохиогчийн эрх болон хамаарах эрхийг энэ хуулийн дагуу хамгаална.
17. 66.2 заалтын дагуу 1993 оны 09 дүгээр сарын 01-ний өдрөөс өмнө үүссэн зохиогчийн эрхийн бүтээл болон хамаарах эрхийн объектын ашиглалттай холбоотой харилцаанд энэ хууль буцаан үйлчлэхгүй.

4.3.2. Хуулийн төсөлд орсон тоон хязгаарлалтууд

1. Хамтын удирдлагын байгууллагын үүргийн тухай 54 дүгээр зүйлийн 54.4 заалтын дагуу хамтын удирдлагын байгууллагын үйл ажиллагааны зардал нь бүтээл ашиглалтын нийт төлбөрийн дүнгийн 20 хувиас ихгүй байна.
2. Дүрслэх урлагийн бүтээл дэх зохиогчийн эрхийн тухай 26 дугаар зүйлийн 26.3 заалтаар дүрслэх урлагийн бүтээлийг худалдан авсан этгээд дахин худалдах тохиолдолд уг бүтээлийн зохиогчид худалдсан үнийн дүнгийн 5-аас багагүй хувийг төлөх үүрэгтэй.
3. Эрдэм шинжилгээ, судалгаа, сургалтын зорилгоор бүтээлийг хэсэгчлэн ашиглах тухай 33 дугаар зүйлийн 33.2 заалтаар энэ зүйлийн 33.1-д заасан зорилгоор бүтээлийг ашиглахад бүтээлийн 5 хувиас хэтрэхгүй байна.
4. Хамтын удирдлагын байгууллагын тухай 52 дугаар зүйлийн 52.7.5 заалтын дагуу гүйцэтгэх удирдлага болон ажилтнууд нь холбогдох зохиогчийн эрх болон хамаарах эрхийн талаар 40 хүртэлх цагийн сургалтанд хамрагдсан байх.
5. Зохиогчийн болон хамаарах эрхийн зөвлөлийн тухай 57 дугаар зүйлийн 57.2 заалтын дагуу Зохиогчийн болон хамаарах эрхийн Зөвлөл нь дарга, 14 гишүүнээс бүрдэнэ.
6. 57.6 заалтын дагуу Зөвлөлийн дарга болон гишүүдийг оюуны өмчийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний шийдвэрээр 4 жилийн хугацаатайгаар томилж, чөлөөлнө.

Дүгнэлт:

“Зохиогчийн эрх болон түүнд хамаарах эрхийн тухай” хуулийн шинэчилсэн найруулгын төслийн хүрээнд холбогдох журам батлах, шийдвэр гаргах, зөвшөөрөл олгох, хяналт тавих, үйл ажиллагааны санхүүжилт, бүтэц бүрэлдэхүүнийг нь тоон хязгаарлалтаар зохицуулах зэргээр байгууллагууд хоорондын уялдаа, хамаарлыг тодорхой зааж өгч чадсан байна.

4.3.3. Хууль хоорондын уялдаа

Энэ хууль болон бусад хууль хоорондын харилцан уялдаа нь дараах байдлаар Зохиогчийн эрх болон түүнд хамаарах эрхийн хуулийн шинэчилсэн найруулгад тусгагджээ.

1. Зохиогчийн эрх болон түүнд хамаарах эрхийн хууль тогтоомжийн тухай 2 дугаар зүйлийн 2.1 заалтад зохиогчийн эрх болон түүнд хамаарах эрхийн хууль тогтоомж нь Монгол Улсын Үндсэн хууль, Иргэний хууль, энэ хууль болон тэдгээртэй нийцүүлэн гаргасан хууль тогтоомжоос бүрдэнэ хэмээн згаасан. 2.2 заалтад Монгол Улсын олон улсын гэрээнд энэ хуульд зааснаас өөрөөр заасан бол олон улсын гэрээний заалтыг дагаж мөрдөнө гэж заасан.
2. Зохиогчийн эрх эдлэх этгээдийн тухай 4 дүгээр зүйлийн 4.1.5 заалтад зохиогчийн эрх болон хамаарах эрхийг хамгаалах талаар Монгол Улсын нэгдэн орсон олон улсын гэрээний гишүүн улс, эсхүл Монгол Улстай уг асуудлаар хоёрт талт олон улсын гэрээ байгуулсан улсын зохиогч, эрх эзэмшигч нь зохиогчийн эрхийг энэ хуулийн дагуу эдэлнэ.
3. Зохиогчийн эрхийг өвлөх тухай 14 дүгээр зүйлийн 14.1 заалтаар зохиогчийн бүтээл ашиглах онцгой эрхийг Монгол Улсын Иргэний хуульд заасан журмын дагуу өв залгамжилна.
4. Хамаарах эрх эдлэх этгээдийн тухай 1 дүгээр зүйлийн 4.1.6 заалтаар хамаарах эрхийг хамгаалах талаар Монгол Улсын нэгдсэн орсон олон улсын гэрээний гишүүн улс, эсхүл Монгол Улстай уг асуудлаар хоёрт талт олон улсын гэрээ байгуулсан улсын хамаарах эрх эзэмшигч хамаарах эрхийг эдэлнэ.
5. 51 зүгээр зүйлийн 51.2 заалтаар хараагүй болон харааны бэрхшээлтэй, хэвлэмэл бүтээл ашиглах хязгаарлагдмал чадамжтай хүний хэрэгцээнд зориулан зохиогч, эрх эзэмшигчийн зөвшөөрөлгүйгээр ашиглуулах бүтээлийг хилээр нэвтрүүлэх зөвшөөрөл олгох тухай заасан.
6. Хамтын удирдлагын байгууллагын үйл ажиллагаанд тавих хяналтын тухай 55 дугаар зүйлийн 55.6 заалтаар энэ хуулийн 55.3, 55.4-т заасан оюуны өмчийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын шийдвэрийг хамтын удирдлагын байгууллага үндэслэлгүй гэж үзвэл Захиргааны ерөнхий хуульд заасан журмын дагуу гомдол гаргаж болно.
7. Гадаад орны зохиогчийн эрх болон хамаарах эрхийн хамтын удирдлагын байгууллагатай харилцах тухай 56 дугаар зүйлийн 56.1 заалтын дагуу Монгол Улсын нутаг дэвсгэр дээр ашиглагдаж байгаа гадаадын иргэдийн шинжлэх ухаан, утга зохиол, урлагийн бүтээлийн зохиогчийн эрх, хамаарах эрхийг тухайн орны ижил төрлийн хамтын удирдлагын байгууллагатай байгуулсан хоёр талын гэрээ болон олон талын гэрээний дагуу хэрэгжүүлнэ. Мөн түүнчлэн хамтын удирдлагын байгууллагын үйл ажиллагааны тухай 53 дугаар зүйлийн 53.2.6 заалтаар гадаад орны ижил төрлийн хамтын удирдлагын байгууллагатай хамтран ажиллах, харилцан төлөөллийн гэрээ байгуулах үйл ажиллагааг зааж өгсөн. 56.2 заалтаар гадаад орны бүтээл ашиглагч нь тухайн орны хамтын удирдлагын байгууллагатай байгуулсан гэрээний дагуу бүтээл ашиглана.
8. Цахим болон харилцаа холбооны бусад сүлжээнд зохиогчийн эрхийг хамгаалах тухай 60 дугаар зүйлийн 60.3 заалтын дагуу энэ зүйлийн 60.1, 60.2-т заасан үүргээ биелүүлээгүй этгээд оюуны өмчийн улсын байцаагч Зөрчлийн тухай хуульд заасан хариуцлага оногдуулна.
9. Зохиогчийн эрх болон түүнд хамаарах эрхийн хууль тогтоомж зөрчигчдөд хүлээлгэх хариуцлагын тухай 65 дугаар зүйлийн 65.1 заалтын дагуу зохиогчийн эрх болон түүнд хамаарах эрхийн тухай хууль тогтоомж зөрчсөн этгээдэд Эрүүгийн хууль, эсхүл Зөрчлийн тухай хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ. Мөн түүнчлэн 65.2 заалтаар бүтээл ашиглах онцгой эрхийг зөрчсөнөөс учирсан эд хөрөнгийн хохирлыг нөхөн төлүүлэх асуудлыг Монгол Улсын Иргэний хуулийн дагуу шийдвэрлэнэ.
10. Оюуны өмчийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын тухай 51 дүгээр зүйлийн 51.1.3 заалтаар Монгол Улсын хууль тогтоомжийг зохиогчийн эрх болон хамаарах эрхийн хамгаалалтын талаар Монгол Улсын нэгдэн орсон олон улсын гэрээ, конвенцид нийцүүлэх, нэмэлт, өөрчлөлт оруулах талаар санал боловсруулах чиг үүргийг тусгасан.

Дүгнэлт:

“Зохиогчийн эрх болон түүнд хамаарах эрхийн тухай” хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд түүнтэй хамаарал бүхий хуулиудтай уялдуулсан заалтууд хангалттай орж, уялдаа холбоо нь тодорхой, давхардсан, зөрчилдсөн, хийдэгдэл гарсан зүйлгүй харагдаж байна.

4.3.4. Хуулийн төслийн дотоод зүйл, заалтуудын холболт, харилцан уялдаа

4.6.Энэ зүйлийн 4.5-д заасан зохиогч болон эрх эзэмшигч нь тодорхой болсны дараа бүтээлийг төлбөртэй ашиглуулсан бол оюуны өмчийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага зохиогч болон эрх эзэмшигчид зохих хувийг нөхөж олгоно.
4.7.Энэ хуулийн 4.6-д заасан бүтээл ашигласан төлбөрийг нөхөж олгохтой холбоотой журмыг Засгийн газар батална.
7.2.Энэ хуулийн 7.1.15-7.1.17-д заасан бүтээлийн зохиогч нь үндсэн бүтээлийн зохиогчийн эрхийг зөрчихгүй байх үүрэгтэй.
8.1.4.энэ хуулийн 8.1.1-8.1.3-т заасан баримт бичгийн албан орчуулга;
9.6.Энэ хуулийн 9.5-д заасан бүртгэл хийх журмыг оюуны өмчийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.
9.7.Энэ хуулийн 9.3-т заасан таних тэмдгийг дараахь байдлаар илэрхийлж болно: 9.7.1.дугуй хүрээ бүхий латин “С” үсэг буюу ©; 9.7.2.бүтээл ашиглах онцгой эрх эзэмшигчийн нэр; 9.7.3.бүтээлийг анх нийтийн хүртээл болгосон огноо.
13.5.Энэ хуулийн 13.4-т заасан бүтээлийн зохиогч нь тодорхой болсон тохиолдолд зохиогчийн эрхийн хугацааг энэ хуулийн 13.2-т зааснаар тооцно.
13.8.Энэ хуулийн 13.1-д заасан бүтээл туурвисан өдрийг зохиогчийн эх бүтээл дэх хугацаагаар тогтооно.
15.1.Энэ хуулийн 12.2 дахь хэсэгт заасан эрхийг зөвхөн зохиогчийн зөвшөөрлөөр, бичгээр хийсэн гэрээний үндсэн дээр бусдад шилжүүлж болно.
16.1.Үүсмэл бүтээлийн зохиогч нь эх бүтээлийн зохиогчоос зөвшөөрөл авсны үндсэн дээр үүсмэл бүтээл туурвих эрхтэй бөгөөд зөвшөөрөл нь энэ хуулийн 28.4-т заасан нөхцөл, шаардлагыг хангасан байна.
17.1.Энэ хуулийн 7.1.16-д заасан бүтээлийн эмхэтгэгч нь эмхэтгэл болон түүвэр зохиолд орсон эх бүтээл бүрийн зохиогчоос зөвшөөрөл авсны үндсэн дээр түүвэр зохиол, бусад эмхэтгэлийг туурвих эрхтэй бөгөөд зөвшөөрөл нь энэ хуулийн 28.4-т заасан нөхцөл шаардлагыг хангасан байна.
18.5.Гэрээнд өөрөөр заагаагүй бол энэ хуулийн 18.2-т заасны дагуу ажил олгогч өөрийн үндсэн үйл ажиллагаанаас гадна ашиг олох зорилгоор бүтээлийг бусдад ашиглуулсан бол ажилтан бүтээл ашигласны төлбөрөөс хүртэх эрхтэй.
20.5.Кино урлагийн болон дуу авиа бүхий дүрст бүтээлийн зохиогчид төлөх төлбөрийн нөхцөлийг энэ хуулийн 20.2-т заасан гэрээнд тодорхойлсон байна.
21.4.Компьютерийн програмын зохиогч нь энэ хуулийн 21.3-т заасны дагуу тухайн бүтээлийг арилжааны буюу бизнесийн зорилгоор бусдад ашиглуулсан төлбөрөөс хүртэх эрхтэй.
21.6.Энэ хуулийн 21.5-д заасны дагуу авсан мэдээллийг бие даасан програм зохиох болон бусад програмыг хооронд нь нийцүүлэхээс бусад зорилгоор ашиглах, гуравдагч этгээдэд задруулах болон эх програмын үндсэн илэрхийлэлтэй ижил төстэй байдлаар хөгжүүлэх, өөрчлөх, хуулбарлах, арилжаалах зорилгоор ашиглахыг хориглоно.
22.2.Мэдээллийн сан үүсгэсэн этгээд нь энэ зүйлийн 22.1-д заасан эрхийг гэрээний үндсэн дээр бусад этгээдэд бүрэн, эсхүл хэсэгчлэн шилжүүлэх, эсхүл ашиглах эрх олгож болно.
24.3.Хэвлэлийн гэрээнд энэ хуулийн 28 дугаар зүйлд заасан шаардлагаас гадна бүтээлийн зохиогчийн нэр, зохиомол нэр, эсхүл нууц нэр, хэвлэлийн тоо ширхэг, бүтээл нийтлэх эрхийн хамрах хүрээ, зохиогчийн эрхийг хязгаарлах, хэвлэлд бэлтгэх, хэвлэх, нэмэлт засвар оруулах, дахин хэвлэх, нийтлэх, худалдаалах, орчуулах, цахим хэлбэрт оруулах, хэвлэлийн хэл, хэвлэлийн загвар, чимэглэл, дизайн, хэвлэлийн улсын бүртгэлийн дугаар зэрэг асуудлыг тусгайлан тодорхойлно.
28.2.Энэ хуулийн 28.1-д заасны дагуу бүтээл ашиглалтыг бүтээл ашиглах тухайлсан эрх, зорилго, хугацаа, нутаг дэвсгэр, хамрах хүрээ, арга хэлбэр зэргээр хязгаарлаж болно.

28.3.Бүтээл ашиглагчид энэ хуулийн 28.1.2-т заасны дагуу олгосон бүтээл ашиглах эрхийг гагцхүү зохиогч, эсхүл зохиогчийн эрх эзэмшигчийн зөвшөөрлөөр гуравдагч этгээдэд дамжуулан ашиглуулж болно.
28.4.Энэ хуулийн 28.1-д заасны дагуу бүтээлийг ашиглуулахад талууд гэрээг бичгээр байгуулах бөгөөд гэрээнд дараахь нөхцөлийг тусгасан байна:
29.1.Энэ хуулийн 28.1.2-т заасны дагуу бүтээл ашиглах онцгой эрхийг дараахь төрлийн лицензийн гэрээгээр ашиглах эрх олгоно:
29.7.Энэ хуулийн 29.6-д заасны дагуу бүтээлийн төлбөрийн хэмжээг нэгж үнийн дүнгээр тодорхойлсон бол зохиогч, зохиогчийн эрх эзэмшигч нь лиценз авагчаас олсон орлого, борлуулалтын талаарх мэдээллийг шаардах эрхтэй.
31.2.Энэ зүйлийн 31.1-д зааснаар бүтээлийг ашиглах тохиолдолд эх сурвалжыг заавал дурдана.
33.2.Энэ зүйлийн 33.1-д заасан зорилгоор бүтээлийг ашиглахад бүтээлийн 5 хувиас хэтрэхгүй байна.
34.4.Эрх бүхий байгууллага нь энэ хуулийн 34.7-д заасан шаардлагыг хангасан тохиолдолд зохиогчийн эрх эзэмшигчийн зөвшөөрөлгүйгээр аливаа бүтээлийг хүртээмжтэй хэлбэрт оруулан хуулбарлах, бусад эрх бүхий байгууллагаас уг хуулбарыг олж авах, үр шим хүртэгч хүнд ашгийн бус зорилгоор түрээслэх, эсхүл утастай болон утасгүй холбооны хэрэгслээр дамжуулан түгээх эрх эдэлнэ.
36.2.Энэ зүйлийн 36.1-д заасан нөхцөл дараахь бүтээлүүдийг хуулбарлахад хамаарахгүй:
39.2.Энэ хуулийн 39.1.2 дэх заалт нь архитектурын бүтээлийг барилга болон барилга байгууламж хэлбэрээр бүхэлд нь хуулбарлах эрхийг олгохгүй.
40.1.Энэ хуулийн 31 дүгээр зүйлд заасан тохиолдлыг тодорхойлохдоо дараахь нөхцөлийг харгалзан үзнэ: 40.1.1.ашиг олох зорилгогүй байх; 40.1.2.бүтээл ашиглалт нь шударга ашиглалттай нийцэж, ашигласан цар хүрээ нь зорилгоосоо хэтрээгүй байх.
40.2.энэ хуулийн 31 дүгээр зүйлд зааснаар бүтээлийг ашиглахдаа зохиогчийн нэр, эх сурвалжийг заавал дурдана.
43.5.Энэ хуулийн 43.4-т заасан тоглолтын гүйцэтгэгч уран бүтээлчийн онцгой эрхийг ашиглахад тоглолтын гоцлол дуучин, гоцлол хөгжимчнөөс зөвшөөрөл авна.
43.10.Гүйцэтгэгч уран бүтээлч нь энэ хуулийн 43.2-т заасан эрхээ хэрэгжүүлэхдээ зохиогчийн эрхийг зөрчихгүй.
44.6.Фонограм бүтээгч нь энэ хуулийн 44.1-д заасан эрхээ хэрэгжүүлэхдээ зохиогчийн эрхийг зөрчихгүй.
45.2.Олон сувгийн дамжуулагчид энэ хуулийн 45.1-д заасан эрх хамаарахгүй.
45.3.Өргөн нэвтрүүлгийн байгууллага нь энэ хуулийн 45.1-д заасан эрхээ хэрэгжүүлэхдээ зохиогчийн эрхийг зөрчихгүй.
47.1.Энэ хуулийн 41.1-д заасан хамаарах эрх эдлэх этгээд болон хамаарах эрх эзэмшигчийн хамаарах эрхийн объектыг хамгаалах хугацаа нь хамаарах эрхийн объектыг туурвисан, эсхүл гүйцэтгэсний дараа жилийн 1 дүгээр сарын 1-нээс эхлэн 50 жилийн хугацаанд хүчин төгөлдөр байна.
48.1.Энэ хуулийн 41.1-д заасан хамаарах эрх эдлэх этгээд болон хамаарах эрх эзэмшигчийн хамаарах эрхийн объектыг эрх шилжүүлэх гэрээ эсхүл лицензийн гэрээний дагуу ашиглуулж болох бөгөөд энэ хуулийн 28 дугаар зүйлийг баримтална.
49.1.Гүйцэтгэгч уран бүтээлчийн онцгой эрхийг гэрээний үндсэн дээр бүрэн, эсхүл хэсэгчлэн бусад этгээдэд шилжүүлж болно. Эрх шилжүүлэх гэрээнд энэ хуулийн 28, 30 дугаар зүйлийг баримтална.
49.2.Гүйцэтгэгч уран бүтээлчийн онцгой эрхийг лицензийн гэрээний үндсэн дээр бүрэн эсхүл хэсэгчлэн бусад этгээдэд ашиглуулж болно. Лицензийн гэрээнд энэ хуулийн 28, 29 дугаар зүйлийг баримтална.
50.1.Энэ хуулийн 41.1-д заасан хамаарах эрх эдлэх этгээд болон хамаарах эрх эзэмшигчийн зүй ёсны ашиглалттай зөрчилдөхгүйгээр, эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хөндөлгүйгээр хамаарах эрхийн объектыг энэ хуулийн 31-40 дүгээр зүйлд заасан үндэслэл, нөхцөлийн дагуу зөвшөөрөлгүйгээр, үнэ төлбөргүйгээр ашиглаж болно.
50.2.Энэ хуулийн 50.1-д зааснаар хамаарах эрхийн объектыг ашиглах тохиолдолд эх сурвалжыг заавал дурдана.
51.1.8.энэ хуулийн 52 дугаар зүйлд заасан хамтын удирдлагын байгууллагуудыг мэргэжил, арга зүйн удирдлагаар хангах, хамтран ажиллах;
52.4.Энэ хуулийн 52.8-д заасан шаардлага хангасан хамтын удирдлагын байгууллага нь зохиогчийн эрхийг хэрэгжүүлэх болон хамгаалах үйл ажиллагаа явуулахдаа оюуны өмчийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагаас зөвшөөрөл авч, хамтран ажиллах гэрээ байгуулан ажиллана.

52.7.Хамтын удирдлагын байгууллага нь энэ хуулийн 52.4-т заасан зөвшөөрлийг авахад дараахь шаардлагыг хангасан байна:
52.8.Энэ хуулийн 52.5, 52.7-д заасан шаардлагыг хангаагүй, бүрдэл дутуу, хуурамчаар бүрдүүлсэн, эсхүл санал болгож байгаа бүтээл ашиглалтын төлбөрийн хэмжээг Зохиогчийн болон хамаарах эрхийн зөвлөл үндэслэлгүй гэж үзсэн бол оюуны өмчийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага зөвшөөрөл олгохоос татгалзана.
52.9.Энэ хуулийн 52.5.4-т заасан бүтээл ашиглалтын төлбөрийн хэмжээг Зохиогчийн болон хамаарах эрхийн зөвлөл батална.
55.3.Оюуны өмчийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага дараахь тохиолдолд хамтын удирдлагын байгууллагын үйл ажиллагаа явуулах зөвшөөрлийг 3 сар хүртэл хугацаагаар түдгэлзүүлнэ: 55.3.1.батлагдсан тарифаас илүү хэмжээгээр төлбөр хураан авсан; 55.3.2.батлагдсан тариф дээр нэмэлт төлбөр ногдуулж авсан; 55.3.3.энэ хуулийн 53.6, 53.7-д заасан тайлан, мэдээг ирүүлээгүй; 55.3.4.энэ хуулийн 55.2-т заасны дагуу өгсөн үүрэг даалгаврыг биелүүлээгүй.
55.5.Энэ хуулийн 55.3, 55.4-т заасны дагуу гаргасан шийдвэрийг оюуны өмчийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага нийтэд мэдээлнэ.
55.6.Энэ хуулийн 55.3, 55.4-т заасан оюуны өмчийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын шийдвэрийг хамтын удирдлагын байгууллага
60.2.Энэ хуулийн 60.1-д заасан этгээд нь зохиогч болон хамаарах эрх эзэмшигчийн эрх зөрчигдөж байгаа тухай мэдээллийг хүлээн авах нөхцөлийг бүрдүүлэх, зөрчлийн тухай мэдэгдсэн даруй тухайн зөрчилтэй бүтээл, хамаарах эрхийн объект ашиглалтыг зогсоох, хаах үүрэг хүлээнэ.
60.3.Энэ зүйлийн 60.1, 60.2-т заасан үүргээ биелүүлээгүй этгээд оюуны өмчийн улсын байцаагч Зөрчлийн тухай хуульд заасан хариуцлага оногдуулна.
60.4.Оюуны өмчийн улсын байцаагч зохиогч, эрх эзэмшигчийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах нэн яаралтай арга хэмжээ авах үүднээс энэ хуулийн 58.2-т заасан зөрчилтэй үйлдлийг зохиогч, эрх эзэмшигчийн хүсэлтээр зогсоох, түдгэлзүүлэх арга хэмжээг нэн даруй авах эрхтэй.
60.5.Энэ хуулийн 60.1, 60.2-т заасны дагуу зөрчилтэй бүтээл, хамаарах эрхийн объект ашиглахыг зогсоосон, хаасантай холбоотой маргааныг шүүх шийдвэрлэнэ.
60.7.Энэ хуулийн 60.6-д заасан шаардах эрхийг гэрээгээр олгосон нөхцөлд хэрэгжүүлнэ.
61.3.Энэ хуулийн 61.1-д заасан технологийн хамгаалалтын арга хэмжээг Засгийн газраас баталсан журмын дагуу авч хэрэгжүүлнэ.

Дүгнэлт:

Хуулийн төслийн дотоод зүйл, заалтуудын холболт, харилцан уялдааны шинжилгээнээс үзэхэд уг хуулийн зүйл заалтууд нь тодорхой хэмжээнд хоёр, гурваараа шүтэлцээтэй, зарим нэг заалт нь дэд заалтууд үүсгэн задар бас нэгдэн учлдаж байгаа нь илт байна.

4.3.5. Зохиогчийн эрхийн тухай Дэлхийн оюуны өмчийн байгууллагын конвенц, олон улсын гэрээ хэлэлцээртэй харилцан уялдсан байдлын үнэлгээ

Энэ талын үнэлгээг Тоглолт болон дуу авианы бичлэгийн тухай Дэлхийн оюуны өмчийн байгууллагын гэрээ (2002 оны 5 дугаар сарын 20) болон Утга зохиол, урлагийн бүтээлийг хамгаалах тухай Бернийн конвенц (1979 оны 9 дүгээр сарын 28)-ын зарим зүйл заалтуудтай “Зохиогчийн эрх болон түүнд хамаарах эрхийн тухай” хуулийн шинэчилсэн найруулгын зарим зүйл заалтуудыг доорх хүснэгтээр харьцуулан жиших аргаар хийлээ.

Монгол улсын “Зохиогчийн эрх болон түүнд хамаарах эрхийн тухай” хуулийн шинэчилсэн найруулга	Тоглолт болон дуу авианы бичлэгийн тухай Дэлхийн оюуны өмчийн байгууллагын гэрээ (2002 оны 5 дугаар сарын 20).	Утга зохиол, урлагийн бүтээлийг хамгаалах тухай Бернийн конвенц (1979 оны 9 дүгээр сарын 28)
Жишээ: Нэр томъёоны тодорхойлолт: 3.1.20.“хуулбарлах”	Жишээ: 2 дугаар зүйл: Нэр томъёоны тодорхойлолт	Жишээ: 2 дугаар зүйл. Тодорхой бүтээлийн хамгаалалтыг хязгаарлаж болох

3.1.21.“түгээх” 3.1.22.“дамжуулах” 3.1.26.“түрээслэх” 3.1.28.“нийтэд тоглох” 3.1.30.“нийтийн хүртээл болгох” 12.2.Зохиогчийн бүтээл ашиглах онцгой эрхэд зохиогч дараахь үйл ажиллагааг зөвшөөрөх болон хориглох онцгой эрхийг хамааруулна: 12.2.1.хуулбарлах; 12.2.2.түгээх; 12.2.3.дамжуулах; 12.2.4.нийтлэх; 12.2.5.орчуулах, үүсмэл бүтээл болгон өөрчлөх; 12.2.6.түрээслэх, зээлдүүлэх; 12.2.7.нийтэд дэлгэж үзүүлэх. 31.1.Бүтээлийг зохиогч, зохиогчийн эрх эзэмшигчийн зүй ёсны ашиглалттай зөрчилдөхгүйгээр, эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хөндөлгүйгээр ашигласан дараахь тохиолдлыг зохиогчийн эрхийн зөрчилд тооцохгүй:	(f) “нэвтрүүлэх” гэж дуу авиа буюу тэдгээрийн дүрслэлийг шугаман бус холбоогоор нийтийн хүртээл болгон дамжуулахыг; (g) тоглолт буюу дуу авианы бичлэгийг “нийтийн хүртээл болгох” гэж тоглолтын бичлэгт бичигдсэн дуу авиа буюу түүний дүрслэлийг нэвтрүүлэхээс бусад аливаа хэрэгслээр олон нийтэд дамжуулахыг хэлнэ. 7 дугаар зүйл: хуулбарлах эрх 8 дугаар зүйл: Түгээх эрх 9 дүгээр зүйл: Түрээслэх эрх 10 дугаар зүйл: Бичигдсэн тоглолтыг нийтийн хүртээл болгох эрх	тухай. 9 дүгээр зүйл. Хуулбарлах эрх: Дууны болон дүрс бичлэг бүтээлийг хэвийн ашиглахад хохиролгүйгээр, мөн зохиогчийн хууль ёсны ашиг сонирхлыг үндэслэлгүйгээр хохироохгүйгээр зарим онцгой тохиолдолд хуулбарлахыг зөвшөөрсөн заалт хууль тогтоомжоороо тогтоох эрхтэй. 10 дугаар зүйл: Бүтээлийг чөлөөтэй ашиглах тодорхой тохиолдол: эх сурвалж, зохиогчийн нэрийг заах 10 дугаар зүйл: Бүтээлийг чөлөөтэй ашиглаж болох бусад тохиолдол. 11 дүгээр зүйл: Эфирт дамжуулах ба үүнтэй холбогдсон эрх; 14 дүгээр зүйл: Кино найруулга ба түүнд хамаарах эрх. 19 дүгээр зүйл: Холбооны гишүүн аль нэг орон илүү өргөн хүрээтэй хамгаалалтыг хууль тогтоомжоороо тогтооход энэхүү конвенцийн заалт саад болохгүй.
--	--	---

Дүгнэлт: “Зохиогчийн эрх болон түүнд хамаарах эрхийн тухай” хуулийн шинэчилсэн найруулга нь Дэлхийн оюуны өмчийн байгууллагын гэрээ (2002 оны 5 дугаар сарын 20) болон Утга зохиол, урлагийн бүтээлийг хамгаалах тухай Бернийн конвенц (1979 оны 9 дүгээр сарын 28)-той агуулгаараа нийцтэй байгаа нь тодорхой байна.

4.3.6. Зохиогчийн эрх болон түүнд хамаарах эрхийн тухай хуулийн нийтлэг жишигтэй уялдсан байдлын үнэлгээ

АНУ болон Английн зохиогчийн эрх болон түүнд хамаарах эрхийн холбогдолтой хуулиудын ерөнхий агуулгуудын зарим хэсэгтэй харьцуулж дараах гурван жишээнээс дүгнэлт хийхэд уг харилцан уялдааны талаар тодорхой дүр зураг бууж байна.

“Зохиогчийн эрх болон түүнд хамаарах эрхийн тухай” хуулийн үзэл санааны нийтлэг талыг
жишин харуулсан байдал: **Жишээ 1**

- 6 дугаар зүйл. Зохиогчийн эрхийн бүтээл
- 7 дугаар зүйл. Зохиогчийн эрхээр хамгаалах бүтээл
- 8 дугаар зүйл. Зохиогчийн эрхээр үл хамгаалах бүтээл
- 9 дүгээр зүйл. Зохиогчийн эрх үүсэх, баталгаажих
- 10 дугаар зүйл. Зохиогчийн эдлэх эрх
- 11 дүгээр зүйл. Зохиогчийн эдийн бус баялгийн эрх
- 12 дугаар зүйл. Бүтээл ашиглах онцгой эрх
- 13 дугаар зүйл. Зохиогчийн эрхийн хамгаалалтын хугацаа
- 14 дүгээр зүйл. Зохиогчийн эрхийг өвлөх
- 15 дугаар зүйл. Бүтээл ашиглах онцгой эрхийг шилжүүлэх
- 16 дугаар зүйл. Үүсмэл бүтээлийн зохиогчийн эрх
- 17 дугаар зүйл. Түүвэр зохиол, бусад эмхэтгэл бүтээлийн зохиогчийн эрх
- 18 дугаар зүйл. Албан үүргийн дагуу туурвисан бүтээлийн зохиогчийн эрх
- 19 дүгээр зүйл. Захиалгаар бүтээл туурвих
- 20 дугаар зүйл. Кино урлагийн болон дуу авиа бүхий дүрст бүтээлийн зохиогчийн эрх
- 21 дүгээр зүйл. Компьютерийн програмын зохиогчийн эрх
- 22 дугаар зүйл. Мэдээллийн сангийн зохиогчийн эрх
- 23 дугаар зүйл. Мэдээллийн сан ашиглагч этгээдийн эрх, үүрэг
- 24 дүгээр зүйл. Хэвлэлийн гэрээ
- 25 дугаар зүйл. Хэвлэлийн газрын гэрээгээр хүлээх үүрэг
- 26 дугаар зүйл. Дүрслэх урлагийн бүтээл дэх зохиогчийн эрх
- 27 дугаар зүйл. Архитектурын бүтээл дэх зохиогчийн эрх
- 28 дугаар зүйл. Зохиогчийн эрхийн бүтээлийг ашиглах
- 29 дүгээр зүйл. Лицензийн гэрээ
- 30 дугаар зүйл. Эрх шилжүүлэх гэрээ
- 31 дүгээр зүйл. Зохиогчийн эрхийг хязгаарлах
- 32 дугаар зүйл. Мэдээллийн зорилгоор бүтээлийг хэсэгчлэн ашиглах
- 33 дугаар зүйл. Эрдэм шинжилгээ, судалгаа, сургалтын зорилгоор
бүтээлийг хэсэгчлэн ашиглах
- 34 дүгээр зүйл. Хараа болон сонсголын согогтой, бусад хөгжлийн бэрхшээлтэй хүний хэрэгцээнд зориулан
ашиглах
- 35 дугаар зүйл. Архив, музей, номын санд хадгалагдаж байгаа бүтээлээс хэсэгчлэн ашиглах
- 36 дугаар зүйл. Амины хэрэгцээнд зориулан бүтээлийг ашиглах
- 37 дугаар зүйл. Бүтээлээс эшлэл авах
- 38 дугаар зүйл. Олон нийтийн аюулгүй байдлыг хангах зорилгоор бүтээлийг ашиглах
- 39 дүгээр зүйл. Барилга байгууламж, архитектурын зохиогчийн эрхийг хязгаарлах
- 40 дүгээр зүйл. Зохиогчийн эрхийг хязгаарлахад тавигдах нөхцөл
- 41 дүгээр зүйл. Хамаарах эрх эдлэх этгээд
- 42 дугаар зүйл. Хамаарах эрх эзэмшигчийн эдлэх эрх
- 43 дугаар зүйл. Гүйцэтгэгч уран бүтээлчийн эрх
- 44 дүгээр зүйл. Фонограм бүтээгчийн эрх
- 45 дугаар зүйл. Өргөн нэвтрүүлгийн байгууллагын эрх
- 46 дугаар зүйл. Дуу авиа бүхий дүрст бүтээлийн анхны бичлэгийн продюсерийн эрх
- 47 дугаар зүйл. Хамаарах эрхийн хугацаа
- 48 дугаар зүйл. Хамаарах эрхийн объектийг ашиглах
- 49 дүгээр зүйл. Эрх шилжүүлэх гэрээ болон лицензийн гэрээ
- 50 дугаар зүйл. Хамаарах эрхийг хязгаарлах
- 51 дүгээр зүйл. Оюуны өмчийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага
- 52 дугаар зүйл. Хамтын удирдлагын байгууллага
- 53 дугаар зүйл. Хамтын удирдлагын байгууллагын үйл ажиллагаа
- 54 дүгээр зүйл. Хамтын удирдлагын байгууллагын үүрэг
- 55 Хамтын удирдлагын байгууллагын үйл ажиллагаанд тавих хяналт
- 56 дугаар зүйл. Гадаад орны зохиогчийн эрх болон хамаарах эрхийн хамтын удирдлагын байгууллагатай
харилцах
- 57 дугаар зүйл. Зохиогчийн болон хамаарах эрхийн зөвлөл
- 58 Зөвлөлийн чиг үүрэг
- 59 Зөвлөлийн хуралдаан, шийдвэр
- 60 дугаар зүйл. Цахим болон харилцаа холбооны бусад сүлжээнд зохиогчийн эрхийг хамгаалах
- 61 дүгээр зүйл. Технологийн хамгаалалтын арга хэмжээ
- 62 дугаар зүйл. Эрхийн удирдлагын мэдээлэлтэй холбоотой үүрэг
- 63 дугаар зүйл. Зохиогч болон гүйцэтгэгч уран бүтээлчийн эдийн бус баялгийн эрхийг хамгаалах

**Copyright Law of the United States and
Related Laws Contained in Title 17 of the United States Code, December 2016
Subject Matter and Scope of Copyright**

- 101 Definitions
- 102 Subject matter of copyright: In general
- 103 Subject matter of copyright: Compilations and derivative works
- 104 Subject matter of copyright: National origin
- 104a Copyright in restored works
- 105 Subject matter of copyright: United States Government works
- 106 Exclusive rights in copyrighted works
- 106a Rights of certain authors to attribution and integrity
- 107 Limitations on exclusive rights: Fair use
- 108 Limitations on exclusive rights: Reproduction by libraries and archives
- 109 Limitations on exclusive rights: Effect of transfer of particular copy or phonorecord
- 110 Limitations on exclusive rights: Exemption of certain performances and displays
- 111 Limitations on exclusive rights: Secondary transmissions of broadcast programming by cable
- 112 Limitations on exclusive rights: Ephemeral recordings
- 113 Scope of exclusive rights in pictorial, graphic, and sculptural works
- 114 Scope of exclusive rights in sound recordings
- 115 Scope of exclusive rights in nondramatic musical works:
Compulsory license for making and distributing phonorecords
- 116 Negotiated licenses for public performances by means of coin-operated phonorecord players
- 117 Limitations on exclusive rights: Computer programs
- 118 Scope of exclusive rights: Use of certain works in connection with noncommercial broadcasting
- 119 Limitations on exclusive rights: Secondary transmissions of distant television programming by
satellite
- 120 Scope of exclusive rights in architectural works
- 121 Limitations on exclusive rights: Reproduction for blind or other people with disabilities
- 122 Limitations on exclusive rights: Secondary transmissions of local television programming by
satellite

“Зохиогчийн эрх болон түүнд хамаарах эрхийн тухай” хуулийн үзэл санааны
нийтлэг талыг жишин харуулсан байдал: [Жишээ 3](#)



Copyright, Designs and Patents Act 1988

Chapter II Rights of Copyright Owner

The acts restricted by copyright

16. The acts restricted by copyright in a work.
17. Infringement of copyright by copying.
18. Infringement by issue of copies to the public.
- 18A. Infringement by rental or lending of work to the public.
19. Infringement by performance, showing or playing of work in public.
20. Infringement by communication to the public
21. Infringement by making adaptation or act done in relation to adaptation.

Secondary infringement of copyright

22. Secondary infringement: importing infringing copy.
23. Secondary infringement: possessing or dealing with infringing copy.
24. Secondary infringement: providing means for making infringing copies.
25. Secondary infringement: permitting use of premises for infringing performance.
26. Secondary infringement: provision of apparatus for infringing performance, &c.

Infringing copies

27. Meaning of “infringing copy”.

Chapter III Acts Permitted in relation to Copyright Works

Introductory

28. Introductory provisions.

General

- 28A. Making of temporary copies
- 28B. Personal copies for private use
29. Research and private study.
- 29A. Copies for text and data analysis for non-commercial research
30. Criticism, review, quotation and news reporting.
- 30A. Caricature, parody or pastiche
31. Incidental inclusion of copyright material.

Disability

- 31A. Disabled persons: copies of works for personal use
- 31B. Making and supply of accessible copies by authorised bodies
- 31BA. Making and supply of intermediate copies by authorised bodies
- 31BB. Accessible and intermediate copies: records and notification

Дүгнэлт:

“Зохиогчийн эрх болон түүнд хамаарах эрхийн тухай” хуулийн шинэчилсэн найруулгын төслийн нэг чухал онцлог нь оюуны өмчийн олон улсын жишиг рүү дөхүүлж, Дэлхийн оюуны өмчийн байгууллагийн нийтлэг чухал үзэл санаа, ойлголтуудыг тусгаж өгсөнд оршино. Үүнийг уг хуулийн төслийн давуу тал хэмээн үзэж болно. Тухайлбал, дээрх гурван жишээнээс харьцуулж харахад юуны өмнө гурван бүлэг үзэл баримтлалыг шинэ найруулга өөртөө агуулсныг харж болно. Үүнд:

1. Зохиогчийн эрх болон түүнд хамаарах эрхүүдийг цогцоор нь буюу
 - a. Зохиогчийн эдийн бус баялгийн эрх
 - b. Бүтээл ашиглах онцгой эрх
 - c. Хамаарах эрх эзэмшигчийн эдлэх эрх
 - d. Зохиогч болон гүйцэтгэгч уран бүтээлчийн эдийн бус баялгийн эрхийг хамгаалах асуудлыг дэлгэрэнгүй авч үзсэн байна.
2. Зохиогчийн эрх болон түүнд хамаарах эрхүүдийг хязгаарлах буюу
 - a. Зохиогчийн эрхийг хязгаарлах
 - b. Хамаарах эрхийг хязгаарлах
 - c. Барилга байгууламж, архитектурын зохиогчийн эрхийг хязгаарлах
 - d. Зохиогчийн эрхийг хязгаарлахад тавигдах нөхцөлзэргийг мөн цогцоор нь төсөлд тусгажээ.
3. Бүтээлийг хэсэгчлэн ашиглах буюу
 - a. Мэдээллийн зорилгоор бүтээлийг хэсэгчлэн ашиглах
 - b. Эрдэм шинжилгээ, судалгаа, сургалтын зорилгоор бүтээлийг хэсэгчлэн ашиглах
 - c. Хараа болон сонсголын согогтой, бусад хөгжлийн бэрхшээлтэй хүний хэрэгцээнд зориулан ашиглах
 - d. Архив, музей, номын санд хадгалагдаж байгаа бүтээлээс хэсэгчлэн ашиглах
 - e. Амины хэрэгцээнд зориулан бүтээлийг ашиглах
 - f. Олон нийтийн аюулгүй байдлыг хангах зорилгоор бүтээлийг ашиглахзэрэг асуудлыг мөн иж бүрнээр нь төсөлд тусгасан байна.

4.3.7. Зохиогчийн эрхийг хамгаалах байгууллагуудын харилцан уялдааны үнэлгээ

Зохиогчийн эрхийг хамгаалах байгууллагуудад энэ хуулийн долдугаар бүлэгт шууд дурдагдсан байгууллагууд буюу оюуны өмчийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага (ОӨАЭТЗБ), хамтын удирдлагын байгууллага (ХУБ), зохиогчийн болон хамаарах эрхийн зөвлөл (Зөвлөл) тус тус хамаарна.

Эдгээр байгууллагуудын энэ хуулийн зүйл заалтуудад дурдагдсан үйл ажиллагааны чиг үүрэг, статус, хамтын ажиллагаа хийгээд харилцан уялдааг дараах хүснэгтээр харьцуулан харуулж шинжилсэн болно.

Мөн түүнчлэн ХУБ-аас гурван байгууллагын удирдлагуудтай утсаар холбогдож зарим санал, тэдэнд практик дээр тулгардаг асуудлуудтай нь товч танилцсан болно.

		ОӨЭТЗБайгууллага	ХУБайгууллага	Зөвлөл
1	Чиг үүрэг	Зохиогчийн эрхийг хамгаалах, эдийн бус баялгийн эрхийг хамгаалах; төрийн бодлогыг хэрэгжүүлэх, улсын хяналтыг хэрэгжүүлэх	Зохиогчийн эрхийг хэрэгжүүлэх болон хамгаалах үйл ажиллагаа	ОАЭТЗБайгууллагад зөвлөх, хянах, гомдлыг урьдчилан шийдвэрлэх
2	Дээд шатны удирдлага буюу Зөвшөөрөл	Үйлчилгээний хөлсний хэмжээг оюуны өмчийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн тогтооно.	- ХУБ-г татан буулгах зөвшөөрлийг оюуны өмчийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагаас авна. - Хамтран ажиллах гэрээний загварыг ОӨАЭЗГГишүүн батална. - Бүтээл ашиглалтын төлбөрийн хэмжээг Зөвлөл батална. - ХУБ-ын үйл ажиллагаанд баримтлах журмыг ОӨАЭЗГГишүүн батална. - ХУБ-д зөвшөөрөл олгох, байгууллагын үйл ажиллагаанд хяналт тавих, үнэлэх журмыг ОӨАЭЗГГишүүн батална.	- Зөвлөлийн даргад оюуны өмчийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нэр дэвшүүлнэ. - Гишүүдэд оюуны өмчийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага нэр дэвшүүлнэ. - Зөвлөлийн дарга болон гишүүдийг ОӨАЭЗГГишүүний шийдвэрээр батална. - Зөвлөлийн бүрэлдэхүүн, үйл ажиллагааны дүрмийг ОӨАЭЗГГишүүн батална. - Бүтээл ашиглалтын тарифын талаарх саналаа ОӨАЭТЗБайгууллагад хүргүүлнэ. - Зөвлөлийн маргаан шийдвэрлэх, зуучлах, бүтээл ашиглалтын тариф батлах болон бусад үйл ажиллагаанд баримтлах журмыг ОӨАЭЗГГишүүн батална.
3	Хамтын ажиллагаа	- Бүтээлийн сан байгуулах; - ХУБ-г мэдээлэл, мэргэжил, арга зүйн удирдлагаар хангах, хамтран ажиллах; - Оюуны өмчийн эрх зүйн мэдлэгийг дээшлүүлэх - Гадаад орны төрийн байгууллагатай хамтран ажиллах, - Хууль тогтоомжийг сурталчлах, боловсронгуй болгох;	- Тухайн орны ижил төрлийн хамтын удирдлагын байгууллагатай байгуулсан хоёр талын гэрээ болон олон талын гэрээний дагуу хэрэгжүүлнэ, - Оюуны өмчийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагаас зөвшөөрөл авч, хамтран ажиллах гэрээ байгуулан ажиллана.	
4	Статус	Төрийн байгууллага	Ашгийн төлөө бус хуулийн этгээд	Орон тооны бус зөвлөл
5	Хариуцах асуудал	- Маргааныг шийдвэрлэхэд лавлагаа гаргаж өгөх; - Оюуны өмчийн улсын байцаагч ажиллуулах; - Олон улсын гэрээ, конвенцид нийцүүлэх, нэмэлт, өөрчлөлт оруулах талаар санал боловсруулах;	- Эрхийн хууль бус ашиглалтын гомдол, эрх эзэмшигчдийн эрхийг шүүх болон бусад төрийн байгууллагад төлөөлөн эрхийг хамгаалах; - Бүтээл хууль бусаар ашигласан тухай оюуны өмчийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад санал тавьж шийдвэрлүүлэх - Оюуны өмчийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад тайлан мэдээллийг ирүүлнэ.	- Эрхийг хэрэгжүүлэх, хамгаалахтай холбоотой асуудлаар зөвлөмж, дүгнэлт гаргах; - Бүтээл ашиглалтын тарифыг хянан батлах - Төлбөртэй холбоотой маргааныг урьдчилан хянан шийдвэрлэх; - Хамтын удирдлагын байгууллага болон бүтээл ашиглагчид, гишүүдийн хооронд үүссэн маргааныг урьдчилан хянан шийдвэрлэх;
6	Эрх мэдэл	Хараагүй болон харааны бэрхшээлтэй, хэвлэмэл	Хамтын удирдлагын байгууллагын үйл ажиллагаанд оюуны өмчийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага хяналт тавина. зөвшөөрлийг 3 сар хүртэл хугацаагаар түдгэлзүүлнэ. гэрээг	

		бүтээл хилээр нэвтрүүлэх зөвшөөрөл олгох эрх бүхий этгээдийг тогтоох • ХУБ-д зөвшөөрөл олгох, гэрээ байгуулах, үйл ажиллагаанд хяналт тавих, үр дүнг тооцож, тайлагнах.	цуцалж, үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг хүчингүй болгоно. • Шийдвэрийг оюуны өмчийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага нийтэд мэдээлнэ.	
7	Цар хүрээ	• Хууль тогтоомжийг хэрэгжүүлэх ажлыг улсын хэмжээнд зохион байгуулах	• Эрх эзэмшигчдээс олгосон бүрэн эрхийн хүрээнд үйлчилнэ.	
8	Бүтэц	• Зөвлөл нь дарга, 14 гишүүнээс бүрдэнэ. Зөвлөлийн үйл ажиллагааны үндсэн хэлбэр хуралдаан байна. • Зөвлөлийн бүрэлдэхүүнд оюуны өмчийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, оюуны өмчийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага, соёлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага, хамтын удирдлагын байгууллага, бүтээл ашиглагч болон оюуны өмчийн судлаач, шинжээч нарын төлөөллөөс бүрдсэн байна.		
9	Санхүүжилт	• Үйл ажиллагааныхаа орлогоор санхүүжинэ.	• Хамтын удирдлагын байгууллагын үйл ажиллагааны зардал нь бүтээл ашиглалтын нийт төлбөрийн дүнгийн 20 хувиас ихгүй байна.	• Зөвлөлийн гишүүдийн ажлын хөлс, захиргааны зардлыг үйл ажиллагааны орлогоос санхүүжүүлнэ.
10	Харилцагч	• Эрх эзэмшигчийн төлөөлөх эрх олгох зөвшөөрлийг бичгээр авсан байх • Лиценз авсан этгээдээс төлбөр хураах • Эрх эзэмшигчид орлого хуваарилан олгох; • Санхүүгийн тайландаа аудит хийлгэсэн байна.		• Зөвлөлийн ажлын албаны чиг үүргийг оюуны өмчийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага хэрэгжүүлнэ.

Дээрх хүснэгтээс дараахь дүгнэлтүүдийг хийж болохоор байна. Үүнд:

1. Гурван байгууллага бүгд үйл ажиллагааныхаа орлогоор санхүүжинэ гэсэн нь харагдаж байна.
2. Статусын хувьд ОӨАЭТЗБ нь төрийн захиргааны байгууллага, ХУБ нь ашгийн төлөө бус хуулийн этгээд, Зөвлөл нь орон тооны бус статустай байна.
3. Чиг үүргийн хувьд ОӨАЭТЗБ нь Зохиогчийн эрхийг хамгаалах төрийн бодлогыг хэрэгжүүлэх, улсын хяналтыг хэрэгжүүлэх бол ХУБ нь Зохиогчийн эрхийг хэрэгжүүлэх болон хамгаалах үйл ажиллагаа явуулах, харин Зөвлөл нь ОАЭТЗБайгууллагад зөвлөх, хянах, гомдлыг урьдчилан шийдвэрлэх чиг үүрэгтэй байна.
4. Дээд шатны удирдлагын хамаарлын хувьд бол эдгээр гурван байгууллагын хувьд оюуны өмчийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн чухал үүрэгтэй байна.
5. Энэ хуулинд шинээр орж ирсэн Зөвлөлийн хувьд зохиогчийн эрх эзэмшигчдийн эрхийг хамгаалах хүрээнд ХУБ-ын гишүүд, бүтээл ашиглагчид, ХУБ гэсэн талуудын хоорондох маргааныг урьдчиоан хянан шийдвэрлэх гол үүрэгтэй нь харагдана.

Гурван ХУБ-н удирдлагуудтай утсаар холбогдон ярилцахад дараах асуудлуудын тухай ярьж байсан. Үүнд:

1. ХУБ-ын гишүүдийнхээ эрх ашгийг хамгаалах, эрхийн хамгаалалттай бүтээлээ ашиглуулан төлбөр авах үйл ажиллагаанд зарим агрегаторуудын үйл ажиллагаа саад болж, зарим үед үйлчлүүлэгчид ХАБ хоёрын дунд бизнесийн зуучлагч ч маягтай болж байдгийг дурдсан.
2. ОӨАЭТЗБ-тай нягт холбоотой ажиллах боломж тун хязгаарлагдмал, ОӨАЭТЗБ-ын хүн хүч ихээхэн дутагдалтай, ажлын ачаалал нь их учраас ХАБ-д нээлттэй байх нь их ховор гэж байлаа.
3. ОӨАЭТЗБ-ын зүгээс төлөвлөгөөт хяналт шалгалт хийх үед бүтээлийг зүй бус ашиглаж буй хүмүүс урьдчилан мэдээлэл авч “бултсан” байдаг.
4. Зарим нэг зөрчилтэй ХУБ-ын хүмүүс таарахад шуурхай арга хэмжээ авах эрх мэдэл байдаггүй.
5. Зөрчлийн талаарх гомдлыг ОӨАЭТЗБ-д мэдэгдэн асуудал шийдэгдэх хүртэл ихээхэн хугацаа шаардагддаг сул талтай.
6. Энэ хуулийн шинэчилсэн найруулганд туссан ХУБ-ын хяналт нь дэндсэн мэт харагдаж байгаа, бид хянуулах тайлагнах гэхээсээ гишүүдийнхээ эрх ашгийг хамгаалахдаа шуурхай, үр днтэй ажилламаар байна гэж байлаа.
7. ХУБ нь төрийн бус байгууллагын статустай байгаа нь ихээхэн сул талтай. Тухайлбал, эрх эзэмшигчдийн эрхийг хамгаалах ХУБ-ын тоо олшрох нь ойлгомжгүй байдалд хүргэнэ, нөгөө талаас гадаад орны ХУБ-аас манай олон ХУБ-аас сонгож гэрээ хийхэд хүндрэлтэй, учир нь статус сул мөртөө олон тоотой байх нь сонголтын боломж магадлалыг бууруулна. Иймд төрийн статустай нэг хүчирхэг ХУБ баймаар санагдана.
8. Оюуны бүтээлийн үнэлгээг, тухайлбал киноны үнэлгээг гаргах журам юм уу аргачлалтай баймаар байна. Бүтээлийн зүй бус ашиглалтын ганц нэг асуудал шийдэх болоход нөхөн төлбөрийг тооцох гэхээр мухарддаг гэх зэрэг санаа бодол илэрхийлж байлаа.

Үр нөлөөний үнэлгээний ерөнхий дүгнэлт

А. Зорилгод хүрэх байдлын үнэлгээ-г хийхдээ энэ хуулийн шинэчилсэн найруулгын төслийн зорилтыг агуулга буюу дэд зорилтуудаар нь 19 задалж, тэдгээрийг нэг бүрчлэн шинэчилсэн найруулгын харгалзах зүйл заалтуудтай тулгаж үзлээ. Үүнээс дүгнэхэд:

1. Зарим тохиолдолд хуулийн харгалзах хэд хэдэн зүйл хамтдаа тухайн дэд зорилтыг хангахад бүрэн дүүрэн үйлчилж байгаа нь харагдлаа.
2. Зарим тохиолдолд нэг зүйл бүхэлдээ дэд зорилтоо хангаж, түүнд нэмэлтээр өөр зүйлийн хэд хэдэн заалтууд хүч нэмж байгаа нь мэдэгдэв.
3. Мөн түүнчлэн нэг буюу хэд хэдэн зүйл бүхэлдээ зорилтоо хангах боломжгүй ч тэдгээрийн доторх нэг эсхүл хэд хэдэн заалтууд зорилтоо хангаж байлаа.
4. Харьцуулалтын суурь матрицаас ажихад нэг зүйл бүхэлдээ нэгээс илүү дэд зорилтод үйлчилж байх эсвэл нэг заалт нэгээс илүү дэд зорилтыг хангаж байх нь үзэгдэнэ.

Б. Ойлгомжтой байдал-г үнэлэлт дүгнэлт

Зохиогчийн эрх болон түүнд хамаарах хуулийн шинэчилсэн найруулгын эхээс эрх зүйн зохицуулалтын зүйл заалтуудыг хуулийн үзэл баримтлалын хүрээний цогц байдал, логик бүтцийн дагуу нэгтгэн авч үзээд дүгнэхэд:

1. Шинэчилсэн найруулгын үзэл санаа нь ойлгомжтой болж, эрхийг эдлэх, хязгаарлуулах, хэсэгчлэн ашиглуулах гэсэн цогц тогтолцоогоор хэрэгжиж байгаа нь ойлгогдож байна.
2. Түүнчлэн эдлэх эрхийн дэд системүүд нь өөр дотроо задарч, тухайлбал, зохиогчийн эдийн бус баялгийн эрх, бүтээл ашиглах онцгой эрх, хамаарах эрх эзэмшигчийн эдлэх эрхүүдээс бүтсэн нэгэн дэд тогтолцоо, эсвэл зохиогчийн эрхийг хязгаарлах, хамаарах эрхийг хязгаарлах, барилга байгууламж, архитектурын зохиогчийн эрхийг хязгаарлах, зохиогчийн эрхийг хязгаарлахад тавигдах нийтлэг нөхцөл болж задран нэгдээд хэрэгжиж байгаа нь ойлгомжтой байна.
3. Мөн цаашилбал, хэсэгчлэн ашиглах нь зориулалтаараа задарч нэгдэж хэрэгжиж байгаа нь илт байна.
4. Эцэст нь, эрхээ эдлээд төлбөрөө авах, эрхээ шилжүүлээд төлбөр авах, эрхээ хязгаарлуулсан ч эдийн бус баялагийн эрхээ эдлэх, эрхээ насан туршдаа эдлээд өвлүүлэх зэргээр өөр хоорондоо нарийн шүтэлцээтэйгээр зохиогчийн хийгээд эзэмшигчийн эрхээ эдэлж болох хувилбарууд нь илт ойлгомжтой байна.

В. Харилцан уялдаат байдал-г үнэлэлт дүгнэлт

А. “Зохиогчийн эрх болон түүнд хамаарах эрхийн тухай” хуулийн шинэчилсэн найруулгын төслийн хүрээнд зохиогчийн эрхийг хамгаалах, хэрэгжүүлэх байгууллагууд хоорондын эрх зүйн харилцааны илрэл болсон зөвшөөрөл олгох, журам батлах, төлбөрийн хэмжээ тогтоох үйл ажиллагааны хүрээн дэх асуудлыг хуулийн зүйл, заалтуудын уялдаагаар нь авч үзээд дүгнэхэд холбогдох журам батлах, шийдвэр гаргах, зөвшөөрөл олгох, хяналт тавих, үйл ажиллагааны санхүүжилт, бүтэц бүрэлдэхүүнийг нь тоон хязгаарлалтаар зохицуулах зүйл заалтын цогц нь байгууллагууд хоорондын уялдаа, хамаарлыг тодорхой зааж өгч чадсан байна.

В. Энэ хууль болон бусад хууль хоорондын харилцан уялдаа нь өөрийн зүйл заалтуудаараа Монгол Улсын Үндсэн хууль, Иргэний хууль, Зөрчлийн хууль, Эрүүгийн хууль болон олон улсын гэрээ хэлцлийн заалтуудтай нийцтэй бөгөөд давхардал, зөрчил, хийдэлгүй байдлаар илэрч чадаж байна.

С. Хуулийн төслийн дотоод зүйл, заалтуудын холболт, харилцан уялдааны шинжилгээнээс үзэхэд уг хуулийн зүйл заалтууд нь тодорхой хэмжээнд хоёр, гурваараа

шүтэлцээтэй, зарим нэг заалт нь дэд заалтууд үүсгэн задар бас нэгдэн уялдаж байгаа нь илт байна.

D. “Зохиогчийн эрх болон түүнд хамаарах эрхийн тухай” хуулийн шинэчилсэн найруулга нь Дэлхийн оюуны өмчийн байгууллагын гэрээ (2002 оны 5 дугаар сарын 20) болон Утга зохиол, урлагийн бүтээлийг хамгаалах тухай Бернийн конвенц (1979 оны 9 дүгээр сарын 28)-той агуулгаараа нийцтэй байгаа нь харьцуулалтын хүснэгтээс илт харагдсан.

E. “Зохиогчийн эрх болон түүнд хамаарах эрхийн тухай” хуулийн шинэчилсэн найруулгын төслийн нэг чухал онцлог нь оюуны өмчийн олон улсын жишиг рүү дөхүүлж, Дэлхийн оюуны өмчийн байгууллагийн нийтлэг чухал үзэл санаа, ойлголтуудыг тусгаж өгсөнд оршиж байна. Үүнийг уг хуулийн төслийн давуу тал хэмээн үзэж болно. Тухайлбал, уг төслийн зарим заалтуудыг АНУ болон Английн зохиогчийн эрхийн хуулиудын зүйл заалтуудтай товчхон жишиж үзэхэд юуны өмнө гурван бүлэг үзэл баримтлалыг шинэ найруулга өөртөө агуулсныг харж болно. Үүнд:

1. Зохиогчийн эрх болон түүнд хамаарах эрхүүдийг цогцоор нь буюу
 - g. Зохиогчийн эдийн бус баялгийн эрх
 - h. Бүтээл ашиглах онцгой эрх
 - i. Хамаарах эрх эзэмшигчийн эдлэх эрх
 - j. Зохиогч болон гүйцэтгэгч уран бүтээлчийн эдийн бус баялгийн эрхийг хамгаалах асуудлыг дэлгэрэнгүй авч үзсэн байна.
2. Зохиогчийн эрх болон түүнд хамаарах эрхүүдийг хязгаарлах буюу
 - k. Зохиогчийн эрхийг хязгаарлах
 - l. Хамаарах эрхийг хязгаарлах
 - m. Барилга байгууламж, архитектурын зохиогчийн эрхийг хязгаарлах
 - n. Зохиогчийн эрхийг хязгаарлахад тавигдах нөхцөл зэргийг мөн цогцоор нь төсөлд тусгажээ.
3. Бүтээлийг хэсэгчлэн ашиглах буюу
 - o. Мэдээллийн зорилгоор бүтээлийг хэсэгчлэн ашиглах
 - p. Эрдэм шинжилгээ, судалгаа, сургалтын зорилгоор бүтээлийг хэсэгчлэн ашиглах
 - q. Хараа болон сонсголын согогтой, бусад хөгжлийн бэрхшээлтэй хүний хэрэгцээнд зориулан ашиглах
 - r. Архив, музей, номын санд хадгалагдаж байгаа бүтээлээс хэсэгчлэн ашиглах
 - s. Амины хэрэгцээнд зориулан бүтээлийг ашиглах
 - t. Олон нийтийн аюулгүй байдлыг хангах зорилгоор бүтээлийг ашиглахзэрэг асуудлыг мөн иж бүрнээр нь төсөлд тусгасан байна.

F. Оюуны өмчийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага (ОӨАЭТЗБ), хамтын удирдлагын байгууллага (ХУБ), зохиогчийн болон хамаарах эрхийн зөвлөл (Зөвлөл) нь энэ хуулийн долдугаар бүлэгт зохиогчийн эрхийг хамгаалах байгууллагуудад шууд дурдагдсан байгаа бөгөөд тэдгээрийг харьцуулсан хүснэгтээс үзэхэд дараах дүгнэлтүүд гарч байна. Үүнд:

1. Гурван байгууллага бүгд үйл ажиллагааныхаа орлогоор санхүүжинэ гэсэн нь харагдаж байна.
2. Статусын хувьд ОӨАЭТЗБ нь төрийн захиргааны байгууллага, ХУБ нь ашгийн төлөө бус хуулийн этгээд, Зөвлөл нь орон тооны бус статустай байна.
3. Чиг үүргийн хувьд ОӨАЭТЗБ нь Зохиогчийн эрхийг хамгаалах төрийн бодлогыг хэрэгжүүлэх, улсын хяналтыг хэрэгжүүлэх бол ХУБ нь Зохиогчийн эрхийг хэрэгжүүлэх болон хамгаалах үйл ажиллагаа явуулах, харин Зөвлөл нь ОАЭТЗБайгууллагад зөвлөх, хянах, гомдлыг урьдчилан шийдвэрлэх чиг үүрэгтэй байна.
4. Дээд шатны удирдлагын хамаарлын хувьд бол эдгээр гурван байгууллагын хувьд оюуны өмчийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн чухал үүрэгтэй байна.

5. Энэ хуулинд шинээр орж ирсэн Зөвлөлийн хувьд зохиогчийн эрх эзэмшигчдийн эрхийг хамгаалах хүрээнд ХУБ-ын гишүүд, бүтээл ашиглагчид, ХУБ гэсэн талуудын хоорондох маргааныг урьдчилан хянан шийдвэрлэх гол үүрэгтэй нь харагдана.

Г. Эцэст нь нэгтгээд дүгнэхэд:

1. Энэ хуулийн төслийг дагалдан өөрчлөлт оруулахаар төлөвлөж боловсруулсан, зөрчлийн тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай болон Иргэний хуульд өөрчлөлт оруулах тухай боловсруулалт нь зөрчил, давхардал, хийдэлгүй байна.
2. Дэлхийн оюуны өмчийн, тухайлбал, зохиогчийн эрхийн хамгаалалд нийтлэг жишиг болж улс орнуудад тархсан суурь үзэл баримтлалыг, өөрөөр хэлбэл, зохиогч өөрөө эрхээ бүрэн эдлэх боломж, эдийн бус баялагийн эрхээ өөрөө эдлээд бусдад зүй зохистойгоор зөвшөөрөлгүй, үнэ төлбөргүй ашиглахыг хүлээн зөвшөөрөх, эсхүл ашиглах онцгой эрхээ олон хувилбараар бусдад шилжүүлэх зэрэг боломжийг зохиогчийн болон түүнд хамаарах эрх эдэлж буй бүтээгчиддээ энэ хууль анх удаа цогцоор нь олгож байгаа болно.

Зөвлөмж

1. Заалтын томъёололтой холбоотой зөвлөмж

1. Зохиогчдийн нийт боломжит бүтээлүүдийг 7 ба 8-р зүйлүүдээр хоёр том бүлэгт тоочин ангилсан практик үргэлжилж байгаа ч логикийн үүднээс үзвэл тэр хоёр ангилалд багтаагүй хоцрох бүтээлүүд хэзээд байх тул “аль нэг илүү чухлыг нь, тухайлбал, 7-р зүйлд орох бүтээлийг нь тоочиж” дурдаад, нөгөө ангиллыг “7-р зүйлд ороогүй буюу хамаарахгүй бүтээлүүд 8-р зүйлд хамаарна” гэвэл ангилал логик зөрчилгүй утга төгөлдөр болно.
2. “Соёл, боловсрол, инновацийг хөгжүүлэх зорилгоор...” гэж зорилтод оруулсныг “Соёл, боловсрол, инновацийн үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх зорилгоор...” гэж өөрчилбөл практикт илүү нийцтэй болно.

2. Төсөв санхүүтэй холбоотой зөвлөмж

3. “54.4 заалтаар хамтын удирдлагын байгууллагын үйл ажиллагааны зардал нь бүтээл ашиглалтын нийт төлбөрийн дүнгийн 20 хувиас ихгүй байна” гэсэн заалтыг “ХУБ-ын үйл ажиллагааны нийт зардлыг тухайн жилд хуримтлагдсан бүтээл ашиглалтын төлбөрийн дүнгийн 20 хувиар хязгаарлана” гэсэн санаагаар унших боломжтой тул цаанаа “ХУБ-ын төсвийн хэмжээг 20 хувиас хэтрүүлэхгүй байх” хязгаарлалт болно. Иймд практик дээр 20 хувь нь ХУБ-ын ямар хэмжээний үйл ажиллагааг санхүүжүүлэхэд хүрэлцэх вэ? гэдгийг тогтоох нь зүйтэй юм. Хэрэв тэр нь тухайн ХУБ “хөлөө олохуйц” мөнгө биш бол төсвийг нь нэмэх санхүүгийн эх үүсвэр нэмж зааж өгөх шаардлагатай болно.

4. УБ нь зохиогчийн эрхийг хэрэгжүүлэх үйл ажиллагаанаасаа санхүүжиж байгаа тул бүтээлийн хууль бус ашиглалтыг оновчтой илрүүлж, шуурхай шийдснээр санхүүжилтээ нэмэх боломж нээгдэнэ. Иймд ХУБ-ын өнөөгийн практикт зөрчлийг цаг алдалгүй илрүүлж, маргааныг шуурхай шийдэх нь санхүүжилтэнд нь дэмтэй. Х

5. “51.3 заалтаар оюуны өмчийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага үйл ажиллагааныхаа орлогоор санхүүжих бөгөөд үйлчилгээний хөлсний хэмжээг оюуны өмчийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн тогтооно” гэсэн заалт нь тухайн байгууллагын төсөв нь хүрэлцэхгүй тохиолдолд өөрийн орлогоосоо санхүүжилтээ нөхөх, эсвэл зохиогчийн эрхийг хэрэгжүүлэх үйл ажиллагаанд

нэмэлтээр зарцуулах тусгай заалт оруулж өгвөл тухайн байгууллагад хууль зүйн оновчтой дэмжлэг болно.

3. Зохиогчийн эрхийг хэрэгжүүлэх механизмтай холбоотой зөвлөмж

6. Зөвлөл нь зохиогчийн эрхийн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, гарсан зөрчлийг шийдэхэд дэмжлэг болох механизм мөн ч зөрчлийг илрүүлэх шуурхай ажилд шууд нөлөөлөх механизмгүй байна. Гэвч зөвлөл өөрийн орлогоор санхүүжих тул тэр нь үйл ажиллагааны мотиваци болж чадна. Иймд хуулийн дагуу бүтээл ашигладаг хүмүүсийн тоог нэмэгдүүлэх замаар орлогоо нэмэхээс гадна “бултаж сурсан” хууль бус хэрэглэгчийг илрүүлэн зөрчлийг шийдэж орлогоо нэмэх боломж олгох ХУБ-ыг дэмжих механизмыг хуульд тусгах нь зүйтэй. Тухайлбал, зохиогчийн эрхийн байцаагч ажиллуулах эрхийг Зөвлөлд өгч болох юм. Тэр нэгж нь ХУБ-ын гэрээгээр үйл ажиллагааг дэмжээд ажилладаг, эсвэл ХУБ-ын захиалгаар шуурхай дуудлагаар ажилладаг байж болох талтай. Байцаагч нь илрүүлсэн болон шийдүүлсэн хэргийнхээ тоогоор урамшуулал авч цалинждаг байхыг үгүйсгэхгүй.
7. ХУБ-ын санал гомдлын тодорхой хэсэг нь зохиогчийн эрхийн зөрчлийг шуурхай илрүүлэх, тухайн үйлдлийн эзнийг саатуулах эрх дутагдаж байгаатай холбоотой байна. Оюуны өмчийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын дэмжлэг байдаг ч хүнд хүч нь хүрэлцээтэй биш, байцаагчид нь төлөвлөгөөт хяналт шалгалтаас хэтрэхгүй цагийн боломжтой байдаг нь зохиогчийн эрхийг хэрэгжүүлэх ажлын сул тал болж, харин хууль зөрчигчдөд давуу боломж болдог байна. Иймд хууль хэрэгжүүлэх мотиваци сайтай ХУБ-ынханд оюуны өмчийн байцаагчийн эрх олгох эрхзүйн заалтыг хуулинд оруулж өгөх хэрэгтэй юм. Практикаас жишээ татахад, Байгаль орчны байцаагчийн эрхийг байгаль хамгаалах чиг үүрэг бүхий нөхөрлөлүүдэд олгосон туршлага буй. Түүнтэй төстэйгээр оюуны өмчийн “шуурхай албаны байцаагч” мэтийн хувилбаруудыг сонгож хуулийн заалтанд оруулбал “зохиогчийн эрхийг хэрэгжүүлэх” үйл ажиллагааг дэмжих төрийн бодлогоор санхүүгийн тодорхой механизмтай болох гарц байна.

Ашигласан бүтээлүүд, материалууд

1. Хууль тогтоомжийн төслийн үр нөлөөг үнэлэх аргачлал, Засгийн газрын 2016 оны 59-р тогтоолын 3-р хавсралт.
2. Иргэний хууль, 2002 оны 1 дүгээр сарын 10.
3. Хараагүй, харааны бэрхшээлтэй, эсхүл хэвлэмэл бүтээл унших бэрхшээлтэй хүмүүст зориулан хэвлэн нийтлэгдсэн бүтээлийг хүртээмжтэй болгох тухай Марракешийн гэрээг соёрхон батлах тухай.
4. Барааны тэмдэг, газар зүйн заалтын тухай, шинэчилсэн найруулга, 2010 оны 6 дугаар сарын 10.
5. Зохиогчийн эрх болон түүнд хамаарах эрхийн тухай /Шинэчилсэн найруулга/2006 оны 1 дүгээр сарын 19-ний өдөр
6. Зөрчлийн тухай /Шинэчилсэн найруулга/ 2017 оны 5 дугаар сарын 11-ний өдөр
7. Захиргааны ерөнхий хууль, 2015-06-19
8. Эрүүгийн хууль, 2015-12-03.
9. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай, 20-07-01.
10. Аж үйлдвэрийн өмчийг хамгаалах тухай Парисын конвенц - 1979 оны 9 дүгээр сарын 28
11. Бүтээгдэхүүний загварын олон улсын ангилал тогтоох тухай Локарногийн хэлэлцээр 1979-09-28
12. Бүтээгдэхүүний загварын олон улсын хадгалалтын тухай Гаагийн хэлэлцээр
13. Барааны тэмдгийг бүртгэх бараа үйлчилгээний олон улсын ангиллын тухай Ниццийн хэлэлцээр
14. Барааны тэмдгийн олон улсын бүртгэлийн тухай Мадридын хэлэлцээрийн протокол
15. Барааны тэмдгийн улсын бүртгэлийн тухай Мадридын хэлэлцээр
16. Дэлхийн оюуны өмчийн байгууллага байгуулах тухай конвенц 1979-09-28
17. Дэлхийн оюуны өмчийн байгууллагын гэрээ
18. Патентийн хамтын ажиллагааны гэрээ – 1979-09-28
19. Тоглолт болон дуу авианы бичлэгийн тухай Дэлхийн оюуны өмчийн байгууллагын гэрээ 2002-05-20.
20. Утга зохиол, урлагийн бүтээлийг хамгаалах тухай Бернийн конвенц 1979-09-21
21. Патентын олон улсын ангиллын тухай Страсбургийн хэлэлцээр 1979-09-28
22. Худалдаанд хамаарах оюуны өмчийн эрхийн тухай хэлэлцээр
23. Гаалийн тухай хууль, 2008-05-20.
24. Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай, 2010-07-08
25. Copyright Law of the United States and Related Laws Contained in Title 17 of the United States Code, December 2016
26. <https://www.legalinfo.mn>
27. <https://www.copyrightwitness.com/>